ХАЙРТ МОНГОЛ ОРНОО МАНДУУЛЬЯ!

ХИЛ СУДЛАЛ

ХСИС-ИЙН ХИЛИЙН СУРГУУЛЬ,
МОНГОЛЫН ХИЛ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ НИЙГЭМЛЭГИЙН ОНОЛ-МЭДЭЭЛЛИЙН СЭТГҮҮЛ

16 ДАХЬ ЖИЛДЭЭ *УЛИРАЛД НЭГ УДАА ГАРНА*

01-02/33-34
2013

АГУУЛГА

ХИЛ СУДЛАЛ-ОНОЛ, ПРАКТИК

А.Муратхан. Хилийн боомтын хөгжлийн хэтийн төлөв ба хамтын ажиллагаа

Н.Галбадрах. Хилийн отрядын даргын шийдвэрт оруулах, ар тал техникийн албаны даргын саналын агуулга

Г.Галбадрах. Улсын хилээр нэвтрэх авто тээврийн хэрэгсэлд гүнзгийрүүлсэн шалгалт хийхэд анхаарах зарим асуудал

Д.Жавхлант. Хилийн аюулгүй байдлыг хангах талаар ОХУ-ын төрөөс баримталж буй улс төр-дипломат бодлого

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ АЖИЛ

Н.Батчулуун. Техникийн ашиглалтын тухай ойлголт, түүний үзүүлэлтүүд

С.Оюунчимэг. Цэргийн экологийн тухай зарим асуудал

СУРГАЛТЫН ОНОЛ, АРГА ЗҮЙ

В.Жавхланцогт Хилийн отрядын "Дүрвэгсэд нэвтэрсэн үеийн ажиллагаа"-ны сургалтыг боловсронгуй болгох зарим асуудал

Д.Нямдорж. Оюуны зураглал хэмээх шинэ бичиг үсэг

ГАДААДЫН ХИЛЧДИЙН АЛБА, АМЬДРАЛ

Х.Гөлгөө. Усан хилийг найдвартай манаж хамгаалахад шинэ техник, технологи зайлшгүй хэрэгцээтэй

Ё.Хадхүү. Гадаадын улс орнуудын гол, нуурын эргийн хамгаалалт

Х.Асхар. ОХУ-ын хилийн шалган нэвтрүүлэх албанд хийгдэж буй техник хэрэгслийн шинэчлэл

ХИЛИЙН ТҮҮХ

Ш.АРВАЙ- Мянган удаа сонсохоор нэг удаа үз

Н.Даваадорж. Байтаг уул орчмын газар нутгийн маргаан

Л.Одзаяа. Манж чин улсын хойд зүгийн хилийн талаар явуулсан бодлого ба Тагна-Тува

4.Ж.Гэрэлчимэг. Цэргийн сэтгэл судлалын түүхэн хөгжил, сэтгэл зүйн ажлын онцлог

ШИНЭ НОМ

Хилийн харуулын тактик ажиллагаа (гарын авлага)

Бүс нутаг-хил хамгаалалтын үзэл баримтлал

ХИЛ СУДЛАЛ, ОНОЛ ПРАКТИК

ХИЛИЙН БООМТЫН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

Доктор, профессор, бэлтгэл хурандаа А.Муратхан

Даяарших үйл явц хүчтэй өрнөж байгаа энэ үед дэлхийн улс орнууд улам бүр нээлттэй болж, улсын үүд хаалга болсон хилийн шалган нэвтрүүлэх боомтыг хөгжүүлэх, нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах, эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох талаар улс бүхэн хүч чармайлтаа тавин ажиллаж байна.

Ялангуяа Европын холбоо, зарим хөгжингүй улс орон хоорондынхоо хилийн боомтын ажиллагааг хөнгөвчлөх, хамтарсан хилийн шалган нэвтрүүлэх боомт байгуулах, бие биедээ итгэл хүлээлгэх, технологийн дэвшил, арга хэрэгслийг ашиглах, хилийн менежментийг сайжруулах, хил хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоог зохицуулах талаар нэлээд үр дүнд хүрч байна.

Гиймээс бид улс орон бүхний хилийн аюулгүй байдлыг хангасан, цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд түлхэц болохоор, туршлага болгон нэвтрүүлэхээр, үлгэр авч хэрэгжүүлэхээр зарим нэг хилийн боомтын талаар та бүхэнтэй санал солилцохыг хүсэн дараах материалыг танилцуулж байна.

Европын холбооны орнуудаас хамтарсан хилийн шалган нэвтрүүлэх боомтыг зохион байгуулж байгаа талаар

Бүх оронд хил нь онцгой "*мэдрэмтгий*" субьект бөгөөд тухайн улс орны тусгаар тогтнолын бодит хил хязгаар болохоос гадна, олон улсын эрх зүйн дагуу "*төрийн хууль ёсны нутаг дэвсгэрийн хязгаарыг тодорхойлогч шугам*" юм.

Европын интеграцчилал, бүс нутгийн хамтын ажиллагааны үйл явц нь хилийн асуудлыг улс хоорондын хоёр талын уламжлалт харилцааны онцгой салбар, тусгайлсан хүрээ болгон гаргаж ирсэн байна. Өнөө үед интеграцчилал нь өөрөө улс орон бүр хилийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаагаас, Европын Холбооны(ЕХ) бодлого, зарчим, стандарт, шаардлагад нийцүүлэн хилийн хяналт шалгалт, менежментээ хэрхэн сайжруулж байгаагаас тус тус шууд хамаарах болсон байна. Европын холбооны гишүүн орон болон шинээр элсэхээр бэлтгэж буй улс бүхэн энэ хүрээний үйл ажиллагаагаа ЕХ-ны шаардлагад нийцүүлэхийн тулд тодорхой чармайлт гарган хилийн боомтод хилийн хяналт шалгалт явуулдаг төрийн байгууллагуудын бүтэц бүрэлдэхүүн, хүч хэрэгсэл,үйл ажиллагаагаа сайжруулах, өөрчлөх, зохион байгуулах арга барилаа цоо шинэ түвшинд гаргах зэрэг цогц арга хэмжээ авч байна.

Энэ үйл ажиллагааны явцад ЕХ-ны болон дэлхийн бусад улс оронд хяналт шалгалтын харьцангуй шинэ хэлбэрүүд бий болсоор байна. Хил, гаалийн хяналтын энэхүү хэлбэрийн зохион байгуулалт нь улс төр, эдийн засгийн

нэгдмэл нэг зорилтын хүрээнд хоёр улсын хоорондын харилцан итгэлцэл өндөр дээд түвшинд байх ёстой гэдгийг баталж байна. Энэ нь хилээр зорчигч болон ачаа бараа нэвтрэх үеийн журмыг хялбаршуулахад чиглэсэн улс төрийн зориг гаргасны үр дүн юм. *Хамтарсан* эсвэл *холимог хяналт шалгалтын* тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэхдээ ЕХ-ны орнууд дараах **үндсэн зорилтуудыг** мөрдөж байна:

- Зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг хянаж нэвтрүүлэх нарийн төвөгтэй, цаг хугацаа их шаардсан хүнд хэцүү журмыг арай хурдан, хялбар журмаар солих;
- Илүү үр дүнтэй хилийн хяналт, шалгалтыг бий болгох;
- Хилийн шалган нэвтрүүлэх боомтын үйл ажиллагааны зардлыг багасгах;
- Авилга, дамын наймаа, амьд бараа наймаалцах гэх мэт үзэгдлүүдтэй холбоотой эрсдэлийн түвшинг дээшлүүлэх.

Үүний зэрэгцээ ийм төрлийн хилийн хяналтыг бий болгон зохион байгуулахад дараах зайлшгүй шаардлага гарч байна. Үүнд:

- Хилээр нэвтэрч буй хувь хүн, бараа таваар болон хилийн хяналтыг үр ашигтай явуулах ажлыг хангахтай холбоотой асуудлаар улс орнууд хоорондоо хурдан шуурхай мэдээлэл солилцох тогтолцоог бий болгох;
- Хоёр орны хилийн хяналт хариуцсан байгууллагуудын хооронд нягт хамтын ажиллагааг улам идэвхжүүлэх;
- Гэмт хэрэгтэй тэмцэхэд хүчин чармайлтаа нэгтгэн ажиллах;
- Хилийн боомтоор дамжин өнгөрөх хурдыг нэмэгдүүлэх зэрэг болно.

Хилийн хамтарсан шалган нэвтрүүлэх боомт (ХШНБ) байгуулах нь ***улс төрийн шинжтэй*** дараах тодорхой нөхцөлүүдийг агуулж байдаг. Тухайлбал:

- Хоёр улсын Засгийн газар ийм төрлийн хяналт, шалгалт хилийн боомтод нэвтрүүлэх зайлшгүй шаардлага байгааг зохих түвшинд ухамсарлах;
- Талууд хоорондоо ийм хэлбэрийг сонгосныг зарчмын хувьд харилцан ойлголцсон байх;
- Улс төрийн болон захиргааны зохих шийдвэр гаргасан байх;
- Хилийн шалган нэвтрүүлэх боомтыг зохион байгуулах, үр ашигтай үйл ажиллагаа явуулахад шаардлагатай эрх зүйн хэм хэмжээний үндсийг бий болгох;
- Өөрийн эсвэл хөрш улсын нутаг дэвсгэр дээр ХШНБ байгуулахтай холбоотой зөвшилцөлд хүрэх;
- Хилийн шалган нэвтрүүлэх боомтыг шинэчлэн зохион байгуулах, нэмж тоног төхөөрөмж суурилуулахад шаардагдах зардлыг нөхөн санхүүжүүлэх, хөрөнгө мөнгийг хуваарилах.

Практик түвшинд хилийн шалган нэвтрүүлэх боомтыг байгуулахад эхний ээлжинд шалган нэвтрүүлэх боомтын үр ашигтай ажиллагааг хангах, өргөтгөн сайжруулах, тохижуулахад шаардлагатай дэд бүтцийг бий болгох хэтийн төлөвийг тодорхойлно.

Үүний дараа хил дээр хяналт шалгалт явуулах эрх бүхий байгууллагуудын төвийн болон орон нутгийн удирдлагуудын түвшинд ажлын гэрээ хэлцлийг байгуулан, үйл ажиллагааны уялдаа холбоотой дараах зүйлүүдийг тохирсон байх. Үүнд:

- Хилийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд тэдний оролцооны түвшин, хэмжээ, хэлбэр;

- Хяналт шалгалтад оролцож буй байгууллагуудын хоорондын ажил үүргийн хуваарилалт, тэдний бүрэн эрх, хүлээх хариуцлага;

- Ажил үүргийн бо̀лон цаг хугацааны хувьд бие биеэ орлон ажиллах журам тогтоох;

- Хяналт явуулах журам, үе шат, цаг хугацаа, газар орон, зах хязгаар, ажиллагааболон үйлдлээр нь нарийн тодорхойлж өгөх;

- Ажлын бүлэг, ээлжийг зүй зохистой зохион байгуулах, тэдний бүрэлдэхүүн, эрх үүргийг тодотгох.

Хилийн хамтарсан шалган нэвтрүүлэх боомт байгуулах *эрх зүйн чиг хандлага:*

Хилийн шалган нэвтрүүлэх боомт байгуулах эрх зүйн үндэс нь хоёр улсын түвшинд эсвэл хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан хоёр талын гэрээ хэлэлцээр юм. Эдгээр гэрээ, хэлэлцээрүүд нь хилийн шалган нэвтрүүлэх боомтыг байгуулах үндсийг бүрдүүлэх бөгөөд байнга нарийвчлан тодотгогдож, хэлэлцэн тохирогч орнуудад үйлчилж буй хууль тогтоомж, үйл ажиллагаанаас хамааран нэмэлт баримт бичгүүдийг дагалдан гаргаж болно.

Эдгээр баримт бичгүүд нь хилийн боомтуудын үйл ажиллагааны гол асуудлуудыг зохицуулж байдаг. Тухайлбал:

1. *Хоёр улсын хоорондын хил дээр ХШНБ байгуулах үндсэн зорилго;*

2. *Хилийн шалган нэвтрүүлэх боомтын эрх зүйн байдал (статус).*

Эдгээр боомтууд нь хуучин үйлчилж байсан эрх зүйн *байдал* (статус)-тай байж болохгүй бөгөөд зөвхөн хүлээн авч буй талын хууль тогтоомжид бүрэн захирагдан ажиллах ёстой;

3. *Хилийн шалган нэвтрүүлэх боомтын ажилтны эрх зүйн байдал (статус).*

Юуны өмнө хил, гаалийн хяналт, шалгалт явуулж буй ажилтнууд нь албан үүргээ гүйцэтгэж байх үедээ хилийн шалган нэвтрүүлэх боомтын нутаг дэвсгэрт ямарч хориг саадгүй нэвтрэхтэй холбоотой эрх эдлэхээс өөр ямар нэгэн тусгай эрх эдлэх ёсгүй. Хоёр улсын хоорондын харилцаа болон дотоод дүрэм журмаас хамааран зочилж буй орны албаны ажилтнууд албан баримт бичиг болон үндэсний иргэний үнэмлэх, албан паспортаа биедээ авч явах ёстой.

4. *Хилийн шалган нэвтрүүлэх боомтын болон түүнд ажиллагсдын аюулгүй байдал.*

Хилийн шалган нэвтрүүлэх боомт байрлаж байгаа хүлээн авагч улс орон тухайн боомтын барилга байгууламж, дэд бүтэц, үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын ажилтнуудын аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээнэ гэсэн нийтлэг журам байдаг байна.

5.Албаны дүрэмт хувцас өмсөх

Хилийн шалган нэвтрүүлэх боомт оршин байгаа нутаг дэвсгэрт ажиллаж буй албан хаагчид заавал үндэсний дүрэмт хувцсаа өмсөх үүрэгтэй.

6. Зэвсэг хэрэглэх.

Европын холбоонны дүрмээр хилийн шалган нэвтрүүлэх боомт оршин байгаа нутаг дэвсгэрт албан үүрэг гүйцэтгэх үед биедээ галт зэвсэг заавал авч явах ёстой, харин хилийн шалган нэвтрүүлэх боомт байрладаг гадаад орны нутаг дэвсгэрт зөвхөн өөрийгөө

хамгаалах зорилгоор зэвсэг хэрэглэж болно.

7. *Холбоо харилцаа.*

Тухайн салбарын хамтын ажиллагааны хүрээнд харилцаа холбооны хэрэгслийн бие биедээ нөлөөлөх сөрөг хүчин зүйлүүдийг арилгах боломжийг бий болгох чиглэлийн арга хэмжээг улс хоорондын болон Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр зохицуулдаг. Үүнд хилийн шалган нэвтрүүлэх боомт оршин байгаа нутаг дэвсгэрт зочилж буй орны хил хяналтын байгууллагын албан хаагчид, хилийн шалган нэвтрүүлэх боомтын ээлжийн жижүүрүүд хоорондоо болон удирдах дээд байгууллага, штабтайгаа холбогдоход зориулан зөвшөөрөгдсөн холбооны хэрэгсэл, түүний давтамж, техник хэрэгслийг эзэмшихтэй холбоотой дүрэм, хүлээн авч буй орны байгууллага, албадаар үйлчлүүлсний төлбөр хийх журам зэргийг тогтоон өгч болно.

8. *Хяналт явуулах, үзлэг шалгалт хийх, саатуулах эрх.*

Европын холбооны орнуудад мөрдөгддөг нийтлэг журамд өөр орны нутаг дэвсгэрт байрлаж байгаа хилийн шалган нэвтрүүлэх боомтод хяналт шалгалт явуулах заалтуудыг тусгасан байдаг. Эдгээр нь үндэсний нутаг дэвсгэрт үйлчилж буй зохих дүрэм журамтай ижил тэнцүү байх ёстой.

Түүнээс гадна бүс нутгийн улс орнууд хилийн шалган нэвтрүүлэх боомт дээр саатуулах эрхтэй холбоотой өөр өөр дүрэм журам гарсан байдаг. Зарим тохиолдолд зочилж буй орны хилийн хяналтын байгууллагууд хүлээн авч буй орны иргэдийг саатуулах, байцаалт явуулах эрхгүй хэдий ч өөрийн орны болон гуравдагч орны иргэдийн хувьд эдгээр эрхийн бүгдийг эдэлдэг.

Бусад тохиолдолд зөвхөн өөрийн орны иргэдийг саатуулахыг зөвшөөрдөг ба гуравдагч орны иргэдийг нутаг дэвсгэрт нь хилийн шалган нэвтрүүлэх боомт оршин байгаа орны хилийн хяналтын байгууллага саатуулах эрхтэй байдаг.

9. *Хураагдсан эд зүйлийг зохицуулах журам.*

Зочилж буй орны хил хяналтын байгууллагууд хууль бус эд зүйлийг хураах, түүнийг хадгалах, үндэсний нутаг дэвсгэрт нь дагалдан хүргэх эрхтэй хэмээн гэрээгээр тогтоож өгнө.

10. *Санхүүгийн шинжтэй асуудлууд.*

Хилийн шалган нэвтрүүлэх боомтын санхүүжилттэй холбоотой талуудын хүлээвэл зохих хариуцлага, төлбөр, тооцоо, гаалийн татвар, хураамж авах журмыг улс хоорондын гэрээнд тусгасан байна.


11. *Албан ажлын нотломж бусад баримт бичгээр зохицуулагдах асуудлууд*/ Хилийн шалган нэвтрүүлэх боомтын бодит хил хаагуур явах, хоёр орны албад болон ээлжүүдийн хоорондын хамтран ажиллах журам, ажлын арга барил, эрх мэдэл, хариуцлага, албан үүргийн хуваарилалт, хилийн шалган нэвтрүүлэх боомтын дэд бүтцийн удирдлага, бие бүрэлдэхүүн онцгой нөхцөлд хамтран ажиллах журам, зохион байгуулалт/.

12. *Бусад асуудлууд*

Хамтарсан хилийн шалган нэвтрүүлэх боомтыг байршлаас хамааран зохион байгуулах загвар (Польш Улсын туршлагыг үндэс болгов)

Хилийн шалган нэвтрүүлэх боомтын "Төгс" хэлбэр. Хоёр улсын

Зураг 1. "Төгс" хилийн шалган нэвтрүүлэх боомт



хилийн шугам дээр өөрийнхөө нутаг дэвсгэрт байгуулах нь зөв оновчтой хэлбэр юм гэдгийг Европын холбооны улсуудын туршлагаар батлагдаж байна. Ингэснээрээ хоёр улсын хяналт шалгалтын байгууллагууд нь өөр өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулна гэсэн утгатай юм /зураг 1-ээр үзүүлэв/.


Энэ тохиолдолд зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараа нь зөвхөн улсын хилээр орох, гарах чиглэлд тухайн улсын нутаг дэвсгэрт нэг талын хяналт шалгалтаар орж байх бөгөөд өөр ямар нэгэн урьдчилсан хилийн хяналт шалгалт гэсэн ойлголт байхгүй болно.

Энэхүү хэлбэрийн хилийн шалган нэвтрүүлэх боомтод хилийн хяналт, шалгалт явуулдаг байгууллага бүр эрх үүргийн хэмжээнд өөрийн улсын хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлдэг бөгөөд шууд харилцан холбоотой ажилласнаар "Гараас гарт" гэсэн хяналт шалгалтын зарчмыг хэрэгжүүлэн ажиллах боломжоор хангагдаж байгаа юм.

Ийм хэлбэрээр хилийн шалган нэвтрүүлэх боомтыг зохион байгуулснаар хилийн хяналт шалгалтын үйл ажиллагааг бусад хоёр талд тус тусдаа, эсвэл холимог хэлбэрээр байгуулсан хилийн шалган нэвтрүүлэх боомттой харьцуулахад улс төр, эдийн засаг, санхүү, техник, хууль эрх зүйн хүрээнд гардаг олон тооны хүндрэлтэй асуудлыг энгийн хялбар болгож байгаад чухал ач холбогдол нь оршино.

Гэсэн хэдий ч энэхүү хэлбэрийн хилийн шалган нэвтрүүлэх боомт нь газар орон, хууль эрх зүй, улс төр, эдийн засгийн болон бусад шалтгаануудаас үүдэн ховор тохиолддог.Ийм учраас улс орнууд хилийн шалган нэвтрүүлэх боомтыг хилийн шугамаас тодорхой зайд байгуулах шаардлагатай байдаг байна.

Зураг 2. "Тусдаа" хилийн шалган нэвтрүүлэх боомт



Хилийн шалган нэвтрүүлэх боомтыг **"Тусдаа байх"** хэлбэрээр зохион байгуулах уламжлалт хэлбэр нь улс орнууд өөрийн нутаг дэвсгэрт хилийн шугамаас тодорхой зайд орших ШНБ дээр зорчигч, тээврийн хэрэгсэл,

ачаа барааг улсын хилээр орох, гарах аль ч үед нь хяналт шалгалтыг явуулдаг. Ингэснээрээ тухайн улсын хилийн хяналт шалгалтын байгууллагууд нь ямар нэгэн хориг хязгаарлалтгүй, хараат бус өөрийн эрх хэмжээ, хуулийн хүрээнд хяналт шалгалтын төрөл, арга хэлбэр, үйл ажиллагаагаа явуулах боломж олгодгоороо онцлогтой юм. Энэхүү уламжлалт найдвартай, энгийн зохион байгуулалттай ШНБ нь олон талын дутагдлуудыг өөртөө агуулдгаараа хоёр улсын харилцааны хөгжилд саад болж байдаг байна.

Хилийн боомтод явагдах хяналт шалгалтын энэхүү хэлбэр нь:


- эхний ээлжинд шалгалт явуулах цаг хугацаа их шаарддаг байдал;
- зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг хилийн хоёр талд хоёр өөр хилийн боомтууд дээр хоёр удаа шалгагдаж гарах байдал юм.

Ийм хэлбэрийн хилийн шалган нэвтрүүлэх боомтууд нь өөр өөрийн гэсэн хяналт, шалгалтын арга хэлбэр, шалгалтын горим, хэмнэлттэй бөгөөд хөрш улсын хилийн боомтуудтайгаа зөвшилцдөггүй үйл ажиллагаагаа явуулдаг нь амьдрал дээр ихээхэн бэрхшээл, дутагдлыг өөртөө агуулдаг.

Эдгээр болон бусад дутагдлууд нь улсын хилээр нэвтрэх үед нэлээдгүй асуудлыг үүсгэдэг байна. Жишээлбэл: ийм хэлбэрийн хяналт шалгалт нь түргэн муудаг хүнсний бүтээгдэхүүний худалдаа арилжаанд бодитой хүндрэлийг учруулдаг байна.

Улс орны аюулгүй байдал, эдийн засаг, гааль, цагаачлалын талаарх төрийн бодлогын хүрээнд улс хоорондын харилцан итгэлцлийн хэмжээнээс хамааран "тусдаа байх"

Зураг 3. "Тусдаа" нэг чиглэлийн хилийн шалган нэвтрүүлэх боомт
А. гарах чиглэлд



хилийн боомтуудын үйл ажиллагааг зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг тодорхой давуу нөхцөлтэйгээр улсын хилээр нэвтрүүлэх хэлбэрээр солих нь ашигтай гэдгийг олон улс орон хүлээн зөвшөөрөөд байна.

Польш улсын туршлагаас харахад тусдаа байсан хилийн шалган нэвтрүүлэх боомтуудыг **"Нэг чиглэлд тусдаа хяналт шалгалт явуулах"** хялбарчилсан хэлбэрээр сольсон нь тун үр ашигтай болжээ.

Энэхүү хилийн хяналт шалгалтын арга хэлбэр нь тухайн улсын хил хяналтын байгууллагууд нь өөрийн нутаг дэвсгэртээ зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг зөвхөн орох эсвэл гарах чиглэлд нь хяналт шалгалтыг явуулах явдал юм /зураг 3, 4-т үзүүлэв/.

Ийм учраас улсын хилээр нэвтэрч буй зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараа тухайн хилийн боомтуудаар хоёр дахин хийгддэг хяналт шалгалтаас нэг удаа хяналт шалгалтад хамрагддагаараа уламжлалт хилийн боомттой харьцуулахад ихээхэн хялбар болсноор гол ялгаа нь харагдаж байна.


Уламжлалт хилийн боомтын хяналт шалгалтаас энэхүү хяналт шалгалтын арга хэлбэрт шилжсэнээр хилийн

хяналт шалгалтын үйл ажиллагааны гол үзүүлэлт болох улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг түргэн шуурхай нэвтрүүлэх цаг хугацаа багасч, боомтын нэвтрүүлэх хүчин чадал нь ихэсч байгаагаараа давуу талтай байдаг байна.

Ийм учраас энэхүү хяналт шалгалтын арга хэлбэр нь зорчигч, бизнесийн байгууллагуудад ихээхэн таатай нөхцөлийг бүрдүүлж өгч байна.

Ингэснээрээ уламжлалт хилийн боомтууд дахь одоогийн байгаа хил хяналтын байгууллагуудын ажилтнуудын орон тоог нэлээд багасгаж, ашигтай ажиллах хэлбэрт шилжсэн байна.

Зураг 4. "Түсдаа" нэг чиглэлийн хилийн шалгах нэвтрүүлэх боомт
Б. Орох чиглэлд



Энэхүү хэлбэрийн хилийн хяналт шалгалтын дутагдалтай тал нь газар нутгийн маргаантай асуудал, мөн багагүй хэмжээгээр хууль бус наймаа, цагаачлалын асуудалтай холбоотойгоор зарим улс орнуудад илэрдэг байна.

Тодорхой тохиолдлуудад хилийн хяналт шалгалтын байгууллагууд зөрчлүүдийг илрүүлж байгаа хэдий ч хоёр үе шаттайгаар хилийн хяналт шалгалт явуулдаг байсныг нэг болгосон нь мэдээж хэрэг түүний илрүүлэлтийн байдалд нөлөөлж хувь хэмжээ нь багасч байна.

Нөгөө талаасаа тухайн хоёр улс орнуудын эдийн засаг, хууль эрх зүйн хүрээнд төрийн бодлогууд нь хэр их ялгаатай байна, Тэр хэмжээгээрээ энэхүү хяналт шалгалтын хэлбэрийн үр ашиг багатай байна.

Зарим бараа бүтээгдэхүүнийг экспорт, импортлоход тухайн улс хориглосон байдлаар, харин нөгөө улсад хязгаарлаагүй байдлаар өөр өөрийн хууль дүрмээр зохицуулсан байх тохиолдлууд байдаг.

Энэхүү хэлбэрийн ШНБ-тай улс орнуудын хувьд нэг чиглэлд явж буй зорчигч, ачаа барааг тухайн улс орон хяналт шалгалтгүй нэвтрүүлсэн тохиолдол гараагүй байгаа нь амьдрал практикт нотлогдож байна.

Гэсэн хэдий ч улс орнууд ихэвчлэн энэ хэлбэрийн хяналт шалгалтыг орох чиглэлд ашиглаж байгаа нь туршлагаас харагдаж байна.


Үүний гол шалтгаан нь эдийн засгийн хөгжлийн чиг хандлагаас болж сонголтоо хийсэн байдаг. Эдийн засгийн хувьд зарим нэг улс орон өөрийн дотоодын бүтээгдэхүүнээ дэмжих, экспортын асуудалдаа голчлон анхаарч, орж ирж байгаа хямд төсөр импортын бараанаас татгалзаж буйгаа илэрхийлж энэ хэлбэрийн буюу орох чиглэлд хяналт шалгалтаа явуулах хувилбарыг сонгодог байна.

Өөр нэг хилийн хяналт шалгалтын хэлбэр болох хагас холимог хяналт шалгалт буюу хамтарсан хяналт шалгалт. Энэ нь нэг чиглэлд хоёр улсын нутаг дэвсгэрт байрлан үйл ажиллагаа явуулах. Энэхүү хяналт шалгалтын хэлбэр нь тухайн улсуудын нутаг дэвсгэрт нөгөө улсын хилийн хяналт

шалгалт явуулах төлөөлөгч хилийн боомтод байрлан зөвхөн нэг чиглэлд үйл ажиллагаагаа хамтран явуулна гэсэн ойлголт юм. Өөрөөр хэлбэл нэг улсын хилийн боомтод хоёр улсын хилийн хяналт шалгалтын ажилтнууд нэг чиглэлд хяналт шалгалтаа явуулах хэлбэр юм. Энэ хэлбэрийн хяналт шалгалтыг явуулах хоёр хувилбар байдаг. Үүнд:

- Эхний хувилбар /зураг 5-д үзүүлэв/. **Нэг улсын нутаг дэвсгэр дээр хоёр талын хилийн хяналт шалгалтын бүх үе шатуудыг зөвхөн тухайн улсаас гарч байгаа чиглэлд явуулах**. Энэ үед гарах чиглэлд явуулж буй хилийн хяналт шалгалтыг өөрийн нутаг дэвсгэрээс гарч байгаа үед, харин орох үеийн хяналтыг хөрш улсын нутаг дэвсгэрт явуулах хэлбэр юм.

Зураг 5. Тухайн улсын нутаг дэвсгэрт хамтарсан хилийн шалгах нэвтрүүлэх боомт гэрах чиглэлд




- Хоёр дахь хувилбар /зураг 6-д үзүүлэв/. Эхний хувилбарын эсрэгээр буюу хоёр улсын бүх хилийн хяналт шалгалтын үйл ажиллагааг тухайн улсын орох чиглэлд явуулах. Энэхүү хэлбэрийн хяналт шалгалт нь орох чиглэлд хяналт шалгалтыг зөвхөн өөрийн нутаг дэвсгэртээ, харин гарах чиглэлийн хяналт шалгалтыг нөгөө улс руу орох чиглэлд нь явуулах үйл ажиллагаа юм.

Эхний хувилбарын хагас холимог хяналт шалгалтын хэлбэрийг нэг улсын нутаг дэвсгэрт хилийн боомтод нөгөө улсын хил, хяналтын байгууллагуудын бүрэн эрхт төлөөлөгч байрлан хамтарсан хяналт шалгалтыг явуулахад оршино.

Хилийн хяналт шалгалт нь хамтран ажиллах гол зарчимд тулгуурлана. Хоёр улсын хил, хяналтын байгууллагын ажилтнууд нь өөрийн улсын болон хөрш улсын хилийн боомтод хяналт шалгалтын үйл ажиллагаагаа хамтран явуулахад оршино.

Зураг 6. Тухайн улсын нутаг дэвсгэрт хамтарсан хилийн шалгах нэвтрүүлэх боомт орох чиглэлд



Тийм учраас хоёр улсын аль аль нь өөрийн болон хөрш улсаас ажиллах албаны бүлэг хүмүүсийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хангахад ихээхэн анхаарах ёстой. Иймд хоёр улс боомтоо тохижуулах, ашиглахад зориулсан төсөв хөрөнгө ижил түвшинд гаргаж, адил хэмжээтэй зарцуулах шаардлага гарна.

Энэхүү хилийн боомтыг зохион байгуулахын тулд уламжлалт бус байдлаар хоёр талын гэрээ хэлэлцээрүүдийг тусгайлан хийх шаардлагатай болно.

Иймм учраас уг хэлэлцээрт шинээр

үүсэх дараах асуудлуудыг шийдвэрлэх ёстой. Үүнд:

- Хил хяналтын байгууллагуудыг өөрийн нутаг дэвсгэрт ажиллуулах тухай улсын байр суурь;
- Явуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хязгаарлалт;
- Нэг газарт ажиллах хоёр улсын хил, хяналтын байгууллагуудын эрх үүргийн хуваарилалт.

Хяналт шалгалтын энэ хэлбэрийн гол давуу тал нь "Үр дүнтэй, богино хугацаанд хяналт шалгалтыг явуулж улсын хилээр нэвтрүүлэх" гэсэнд оршиж байна.

Энэхүү хяналт шалгалтын үр ашигтай хэлбэр нь эхний ээлжинд нягт хамтран ажиллаж хилийн хяналт шалгалтыг хүч нэмэгдүүлэх, хилээр нэвтрэх урсгал хөдөлгөөнийг нэгэн зэрэг тогтворжуулах явдал юм.


Хилийн хяналт шалгалт явуулах ийм загварын хилийн боомтыг зохион байгуулахад үүсэх гол дутагдал нь үйл ажиллагааны төсөв хөрөнгийн асуудал юм /ямар ч улс орон нэг л хилийн боомтыг санхүүжүүлэх үүрэгтэй/.

Мөн энэхүү загвар нь өөрийн нутаг дэвсгэртээ хүлээн авч байгаа улс нь газар орны маргаан, эрх зүйн хязгаарлалтын асуудлаа хэрхэн шийдвэрлэсэн байдал нь хоёр улсын хил, хяналтын байгууллагуудын үйл ажиллагаанд шууд нөлөөлнө.

Хамтарсан хяналт шалгалтын үйл ажиллагааг зөвхөн нэг улсын нутаг дэвсгэрт явуулах хэлбэр нь тэргүүний гэж болохоор загвар байдаг /зураг 7-д үзүүлэв/.

Энэ загвар нь нэг хилийн боомт нь аль нэг улсын нутаг дэвсгэрт байгуулж, түүндээ хоёр улсын хил,

Зураг 7. Нэг улсын нутаг дэвсгэрт хамтарсан хилийн шалган нэвтрүүлэх боомт



хяналтын байгууллагууд нь үйл ажиллагаагаа явуулах явдал. Ингэхийн тулд хилийн боомтод үйл ажиллагаа явуулж байгаа нөгөө улсын хил, хяналтын байгууллагууд нь өөрийн нутаг дэвсгэртээ хүлээн авагч улсын эрх зүйн орчинд, мөн олгогдож буй эрх үүрэгт зарим нэг байдлаар дасан зохицох шаардлага гарч ирнэ. Яагаад гэвэл тухайн газар нутагт тодорхой эрх зүйн шинжтэй үйл ажиллагаа явагдах бөгөөд хуулийн үүднээс харахад өөрийн явуулж буй үйл ажиллагаа нь өөрийн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр байх учиртай байдаг.


Ийм загварын хилийн шалган нэвтрүүлэх боомтод хийгдэх хяналт шалгалт нь янз бүрийн загваруудыг ашиглах боломжтой. Нэг чиглэлд буюу хоёр чиглэлд ч хамтарсан хяналт шалгалтыг явуулж болдог байна. Хилийн шалган нэвтрүүлэх боомтод үйл ажиллагаа явуулах хяналтын байгууллагуудын ашиглах тоног төхөөрөмж, дэд бүтэц, бодит эрх үүргийн зааг ялгааг сайтар хуваарилах шаардлага гардаг. Зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараа, эд зүйлийг холбогдох баримт бичигтэйгээр энэхүү шугамыг нэвтрэн өнгөрснөөр нэг улсын хилийн хяналт шалгалт дууссанаар,

аль нэг бүлэг хяналт шалгалтын бүрэн дуусгавар болсноор улсын хил нэвтэрсэнд тооцно.

Европын холбооны улсын туршлагаас харахад "Боловсронгуй болгосон хамтын хяналт шалгалт" гэсэн хамтарсан хяналт шалгалтын хэлбэрийг хэрэгжүүлсэн явдал /зураг 8-д үзүүлэв/. Энэ нь зөвхөн нягт хамтын ажиллагаагаар зогсохгүй хамтарсан бүлэг хяналт шалгалтын ажил юм. Энэхүү хяналт шалгалтын үйл ажиллагаагаараа "нэг зогсоол, гараас гарт" гэсэн зарчмын хүрээнд хилийн хяналт шалгалтын явцыг түргэн шуурхай болгох, эрх үүргийн хуваарилалтын шугам бий болгох шаардлагагүй болсон байна.

Харин нэг талын хяналт шалгалтын бүрэн эрх нөгөө талд шалгуулах баримт бичгийг хүлээлгэн өгснөөр дуусгавар болдог.

Зураг 8. "Боловсронгуй" хамтарсан хилийн хяналт шалгалт хийх хилийн боомт



Энэхүү хяналт шалгалтын хэлбэр нь хоёр улсын хооронд хамтран ажиллах, харилцан итгэлцэлийг өндөр түвшинд байлгахад оршино.

Жишээлбэл: Польш-Герман, Герман-Польш, Австри-Унгар, Унгар-Австрийн хилийн боомтууд.

Хяналт шалгалтын энэ хэлбэр нь хилийн хяналт шалгалтын хугацааг багасгахаас гадна бусад давуу талуудыг бий болгодог. Үүнд: авилга, хээл хахуулийн эрсдэл багасах, хоёр улсын байгууллага хоорондын хамтын ажиллагаа өндөр түвшинд явагдах, харилцан мэдээ мэдээлэл, туршлага солилцох гэх мэт.

Энэхүү хяналт шалгалтын хэлбэр нь хилийн боомтыг зохион байгуулах өргөн хүрээтэй сонголтуудыг бий болгодог. Жишээлбэл: Hegyeshalom / Nickelsdorf/ Унгар-Австрийн зорчигч нэвтрэх хилийн боомт нь Унгар улсын нутаг дэвсгэрт, харин олон улсын ачааны тээврийн хэрэгсэл /TIR/ нэвтрэх хилийн боомт нь Австрийн нутаг дэвсгэрт байрлах жишээтэй.

Хамтарсан хяналт шалгалт нь хил, хяналтын байгууллага хоорондын хамтын ажиллагааны буюу орон нутгийн чиглүүлэгч бүлэг гэсэн удирдлагын нэг хэлбэрийг бий болгосон ба тэр нь дараах үүргийг биелүүлдэг байна. Үүнд:

- хамтарсан хилийн шалган нэвтрүүлэх боомтын хоёр улсын хил, хяналтын байгууллагуудын харилцан ажиллах төлөвлөгөөг боловсруулах;
- дэд бүтцийн асуудлыг чиглүүлэн удирдах;
- шалгалтын горим болон хяналт шалгалтын үйл ажиллагааны горим тогтоож батлах гэх мэт.

Дээрх бүх хяналт шалгалтын хэлбэрүүд болон хамтарсан хяналт шалгалтын үед тохиолдох ерөнхий нэг хүндрэлтэй асуудал бий.

Энэ нь хилийн шалган нэвтрүүлэх боомт, хилийн шугам хоорондын зай хэмжээ юм.

Улсын хилээр зорчих зорчигч,

тээврийн хэрэгсэл, ачаа бараа хилийн хяналт шалгалт дууссанаар хуулийн хүрээнд тухайн нутаг дэвсгэрээс гарсанд тооцдог учиртай. Гэвч бодит байдал дээр хилийн шугам нэвтрэн өнгөрснөөр тооцдог.

Хилийн шугам, хилийн шалган нэвтрүүлэх боомт хоорондох зай хэмжээ, зам харгуй муу тавигдсан байна /өөрөөр хэлбэл хууль бусаар улсын хил нэвтрэх нөхцөл байдлыг үгүйсгэхгүй/, тэр хэмжээгээр хуулийн болон практик шинж чанартай ихээхэн эрсдэлтэй асуудлууд хоёр улсын эрх зүйн орчны хүрээнд үүсч болно.

Түүнээс гадна хоёр улсын хууль эрх зүйн баримт бичиг, хоёр улсын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд олон талаас нь тайлбарлах нөхцөл байдлаас гарах зөв арга зам нь хамтарсан хилийн шалган нэвтрүүлэх боомтын хилийн шугамыг бусад хил хязгаараас зааглаж сайн тод харагдахуйц хийх нь чухал асуудал юм.

Мэдээж хэрэг хоёр улсын байгууллагууд хамтарсан хилийн шалган нэвтрүүлэх боомтыг зохион байгуулахын тулд олон асуудлыг шийдвэрлэх шаардлага гарч ирнэ. Үүнд:

- дэд бүтэц, хяналт шалгалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, холбоо харилцааг хамтран ашиглах;

- хилийн шалган нэвтрүүлэх боомтод нөгөө улсаас ирж ажиллах ажилтнуудын бүрэн эрхийг тодорхойлох;

- нөгөө улсад очиж ажиллах зорилгоор албан томилолтоор ирж байгаа ажилтнуудын эрх зүйн баталгаа;

- хил дээр авч буй албан татвар зэрэг асуудлууд.

Европын холбооны улсын туршлагаас харахад энэ бүх асуудлуудыг шийдвэрлэж боловсруулсан стандарт загвар хувилбар одоогоор байхгүй байна.

Герман-Польш, Герман-Чех, Австри-Унгарийн улс хооронд байгуулсан хамтарсан хилийн шалган нэвтрүүлэх боомтууд л гэхэд хилийн боомт тус бүр дээр нь онцлог байдалд нь тааруулан шийдвэрлэж өгсөн байдаг байна.

Тухайн хилийн шалган нэвтрүүлэх боомтын байрлаж буй газар орны онцлог, ачаалал, дэвшилтэт техник технологоор хийгдсэн тоног, төхөөрөмжийг нэвтрүүлэх, улс орнуудаас гаргасан санал, хяналт шалгалтын тэргүүн туршлага, арга барил зэргийг хамтарсан хилийн шалган нэвтрүүлэх боомт байгуулах үедээ хамтран хэлэлцэн шийдвэрлэж ирсэн байна. Европын холбооноос хилийн хяналт шалгалтыг төрлөөр нь ангилж, зохион байгуулах ажлын горимыг *"Хавсралт №1"*-рт үзүүлсэн болно.


Эцэст нь дүгнэлт болгож хэлэхэд хоёр улсын харилцан бие биедээ итгэх итгэлцэл, улс төрийн харилцан ашиг сонирхол зэрэг нь хамгаас чухал бөгөөд хамтарсан хилийн шалган нэвтрүүлэх боомтыг үр дүнтэй зохион байгуулах эсэх нь энэ бүгдээс шууд хамааралтай байдаг нь туршлагаас харагдаж байна.

Хилийн боомтын буюу шалган нэвтрүүлэх байрыг бид дөрвөлжин байшин байх ёстой гэж төсөөлдөг ойлголт өөрчлөгдөж өнөө үед уран барилгын хэмжээнд хүрч тусгайлан төлөвлөдөг болжээ.


Энэ нь Гүрж улс, Турк улсын хил дээр баригдсан хилийн шалган нэвтрүүлэх боомтын барилга /зураг 1, 2, 3-т үзүүлэв/-аас харагдаж байна. Энэхүү

боомтын барилгын зураг төслийг J. Mayer, H6 Architects студид хийсэн байна.

Хилийн боомтын барилга байгууламжид стандарт шаардлагын дагуу байх ёстой өрөө, тасалгаанаас гадна уг байгууламжийн дээд хэсэгт боомтын ажилчидад зориулсан ресторан, ажил, амралтын өрөө, хурлын заал байгаа бөгөөд харин дээд орой хэсгийг харуулын талбай болгон ашигладаг байна.



Зураг 1.Гүрж, Турк улсын хил дээр хилийн шалган нэвтрүүлэх боомтын гаднаас харагдах байдал.



Зураг 2.Гүрж, Турк улсын хил дээр хилийн шалган нэвтрүүлэх боомтын холоос харагдах байдал.




Зураг 3.Гүрж, Турк улсын хил дээр хилийн шалган нэвтрүүлэх боомтын доторх байдал, шалгагчийн кабиныг байрлуулсан байдал.

Хавсралт № 1

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ТӨРЛӨӨР НЬ АНГИЛЖ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГОРИМ

Хамтарсан хилийн шалган нэвтрүүлэх боомтын шалган нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд чухал хэсгийн хилийн боомтууддаа хяналт шалгалтыг төрлөөр нь ангилж, шалгалтын горимыг сайжруулан, зохион байгуулах нь зүйтэй.



Хилийн хяналт шалгалтын үйл ажиллагаа дуусгавар болох

Тайлбар:

TIR болон бусад транзит тээвэрлэлтийн хяналт шалгалт:

- Ачаа барааны ……. үнэмлэх TIR
- Баталгаа
- Тээврийн хэрэгсэл
- Ачаа бараг ачсан газар
- Транзитаар хил нэвтрэх гарц /орох, гарах/
- Ачаа бараг буулгах газар

Ердийн хяналт шалгалт:

1. *Гаалийн декларацци /импорт, экспорт/*

- Ачаа барааны бүртгэл
- Үнэлгээний ангилал
- Тоо хэмжээ
- Төрөл
- Ачаа барааны хэсэг, тоо ширхэг
- Код
- Зөвшөөрөл, хязгаарлалт, чанар хэмжээ
- Импорт, экспорт хийхийг хориглосон байдал

2. *Дагалдах баримт бичгүүд:*

- Барааны падаан
- Ачаа барааны гарал үүслийн гэрчилгээ
- Тамга, лац
- Бусад дагалдах баримт бичгүүд

3. *Барааны үнэлгээний хяналт шалгалт:*

- Татварын тогтолцоо
- Хөнгөлөлт
- Татвараас хэсэгчилэн чөлөөлөгдөх
- Статистик өгөгдэхүүнийг шалгах

Хилийн албаны хяналт шалгалт:

- Баримт бичиг, виз
- Дагалдах баримт бичиг /онцгой болон аюултай ачаа бараа ачсан үед/
- Цагаачлалын хуудас

Бусад төрлийн хяналт шалгалт:

- Мал, амьтан
- Эрүүл ахуй

Гүнзгийрүүлсэн үзлэг шалгалт:

- Тээврийн хэрэгсэлд
- Баримт бичиг, визний
- Саатуулах
- торгууль

Татвар төлөх нэгдсэн нэг байр байна.

Гаалийн болон бусад бүх төлбөр гүйлгээ хийх нэг банкны оффистэй. /Бэлэн мөнгөөр хяналт шалгалтын төлөөлөгчдөд төлбөр хийхийг хатуу хориглоно/.

ХИЛИЙН ОТРЯДЫН ДАРГЫН ШИЙДВЭРТ ОРУУЛАХ, АР ТАЛ ТЕХНИКИЙН АЛБАНЫ ДАРГЫН САНАЛЫН АГУУЛГА

хурандаа Н.Галбадрах

Санал боловсруулахад харгалзан үзэх хүчин зүйл:

Хил хамгаалах байгуулага, хилийн цэрэг нь :

Улсын хил хамгаалах асуудалтай холбогдох хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, улсын хилийн дэглэм, болон хил орчмын дэглэм зөрчигсдийн үйл ажиллагааг тухай бүрт нь илрүүлж таслан зогсоохын тулд хилийн отряд бие бүрэлдхүүн зэвсэглэл, техник, албаны амьтад тусгай хэрэгсэл ашиглан цэргийн арга хэмжээ явуулна.

Хилийн отрядын ар талын хангалтыг тусгай төлөвлөгөөгөөр:

- ✓ Төвлөрсөн хангалт
- ✓ Орон нутгийн хангалт
- ✓ Хосолсон хангалт хэлбэрээр зохион байгуулна.

Улсын хил хамгаалах үндсэн үүрэгтэй уялдан дараах хүч хэрэгслийг ашиглана. Үүнд:

1.Хилийн цэргийн бие бүрэлдэхүүн

2.Албаны амьтад

3.Инженерийн байгууламж (төхөөрөмжлөл)

4. Техник хэрэгслэл

5. Материал хэрэгслэл

6. ХХТХ- ний гишүүд

Харилцан ажиллагаатай байгууллагын хүч хэрэгсэл

1.Хилийн тагнуул болон тагнуулын гүйцэтгэх ажлын хүч хэрэгсэл

2.Цагдаа, Дотоодын цэргийн хүч хэрэгсэл

3. Дэмжих анги, салбарын хүч хэрэгсэл

4.Агаараас дэмжих хүч хэрэгсэл

УХХ байгуулгын албан хаагчид албан үүрэг гүйцэтгэх явцдаа хүн нэг бүрт болон бүлэг хүмүүс, эрлийн ажиллгааны үед томилогдсон бүлэг бүр тусгай хэрэгсэл, албаны нохой бие хамгаалах аргыг хэрэглэх зааврыг улсын прокуророор хянан батлуулж мөрдөнө.

Ар талын хангалтыг зохион байгуулж явуулахдаа:

- ✓ Хүнсний
- ✓ Хувцасны (тоног хэрэглэлийн)
- ✓ Техникийн
- ✓ Барилга, орон сууцны
- ✓ Шатахууны
- ✓ Зэвсэг, галт хэрэглэлийн
- ✓ Хүн эмнэлгийн
- ✓ Мал эмнэлгийн
- ✓ Инженерийн
- ✓ Худалдаа үйлчилгээний гэж зохион байгуулна.

Хилийн отрядын ар тал техникийн албаны дарга нь:

Отрядын даргын тушаал, шийдвэрийг биелүүлэхэд шаардагдах ахуйн орчныг бүрдүүлэх, отряд заставын бие бүрэлдэхүүний материал техникийн хангалт үйлчилгээг зохион байгуулах, түүний хэрэгжилтийг хангах ажлыг хариуцна.

Үүнд:

- ➢ Бие бүрэлдэхүүний ахуйн хангамжыг зохион байгуулах
- ➢ Бүх төрлийн материал хэрэгсэлийн хангалт, эмнэлэг эрүүл ахуй үйлчилгээг тасралтгүй зохион

байгуулж удирдан ажиллах

- Материал хэрэгсэл бэлтгэх татан авах хадгалах хамгаалах тавьж олгох ажлыг зохион байгуулж бүх төрлийн нөөцийг бүрдүүлэх нөхөн сэлбэх
- Анги салбарын бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэж байх.
- Техник хэрэгсэл инженерийн байгууламж болон зэвсэг галт хэрэгсэл, хими радиацын хангалтыг зохион байгуулж хадгалалт, хамгаалалт эзэмшилт, ашиглалтанд хяналт тавьж түүний засвар үйлчилгээг тогтоосон хугацаанд тусгай төлөвлөгөөгөөр явуулж байх.
- Материал хэрэгсэлд хөрөнгийн тооцоо бүртгэлийг батлагдсан хувиарын дагуу хийж эрүүл ахуй хорио цээрийн стандартыг мөрдөж ажиллах
- Материал хэрэгслийн тайлан тооцоог хугацаанд нь гаргаж бараа материалын үлдэгдлийг мэдэж байх
- Мал аж ахуй, газар тариалан туслах аж ахуй, фермерын аж ахуйг хөгжүүлж тэдгээрийн үр дүнг тооцож төсөв хөрөнгө хэмнэх ажлыг зохион байгуулах
- ХЦАА-г анги салбарт хөтлөн явуулж ар талын бие бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах

Ар тал техникийн албаны дарга шийдвэрт оруулах саналын агуулга

- Бие бүрэлдхүүний материал хэрэгслээр хангагдсан байдал
- Автомашин техник тоног төхөөрөмж хэрэгслүүдийн ашиглалтын байдал болон шатахуун бусад шаардагдах техник үйлчилгээ хийх сэлбэг шатах тослох материал хэрэгслээр хангах журам
- Бие бүрэлдхүүний зэвсэг галт, хэрэгслийн хангалтын байдал, хангалт хийх журам
- Нөөцийн цуваажилтийн байдал (үл хөдлөх, урсгал, шилжих нөөц)
- Инженерийн үндсэн хүч хэрэгслийг төвлөрүүлэх хэсэг, чиглэл, улсын хилийг инженерийн байгууламжаар төхөөрөмжлөх болон өнгөлөн далдлалтын арга хэмжээ инженерийн ажилд ашиглах хүч хэрэгсэл
- Ар талын хангалтыг зохион байгуулах арга хэмжээнүүд (алба тус бүрээр)
- Онцгой нөхцөл байдал үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд
- Хилийн эрлийн ажиллагааны үеийн ар тал хангалтыг зохион байгуулах бодомж төлөвлөгөө
- Ар талын хангалтыг зохион байгуулж явуулахад шаардагдах хүч хэрэгсэл, нэмэгдэл бие бүрэлдэхүүн

Зэрэг асуудлуудыг цогц хэлбэрээр төлөвлөж алба тасгуудын дарга нарын тооцоо судалгаа, хийгдэх ажлын төлөвлөгөөг үндэслэн боловсруулж, шийдвэрт тусгах саналаа отрядын даргад илтгэнэ.

Улсын хилийг хүч нэмэгдүүлэн хамгаалах үед:

Хилийн отряд, бэлтгэл застав, заставуудын бэлтгэл хүчний хүч хэрэгсэлийн хүрэлцээ, материал хэрэгсэлийн хангалтын байдал, үүрэг гүйцэтгэх боломж, уналга техник хэрэгслийн байдал, нөөцийн цуваажилт, нэн яаралтай хэрэгжүүлэх арга хэмжээний талаар илтгэх.

Хилийн застав, харуулыг хүч нэмэгдүүлэх, шинээр хөдөлгөөнт бүлэг томилох, ХХТХ-ний гишүүд

ард иргэдийг хил хамгаалтанд оролцуулахад шаардагдах хүч хэрэгсэл, тэдгээрийн бэлэн болох хугацаагаар талын хүч хэрэгслийн бэлэн байдал зэрэг асуудлаар саналаа илтгэх.

Харилцан ажилгаатай байгууллагаас хариуцсан хэсэгт томилогдох хүч хэрэгсэл, тэдгээрийн ар талын хангалтыг зохион байгуулах журам

Отряд заставуудын бэлэн байдал, ар талын хангалтыг оператив 06 тоот удирдамжинд заасны дагуу хангалтын зэрэгт хүргэж хангах.

Бэлэн байдлын зэргүүдэд шилжихэд хэрэгжүүлэх арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах

Харилцан ажиллагаа мэдээ мэдээллийг цуглуулах дүн шинжилгээ хийх ар тал хангалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгч илэрсэн зөрчил дутагдал материал хэрэгслийн хангалтыг нэн яаралтай нөхөж хангах арга хэмжээг тасралтгүй авна.

УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРЭХ АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ГҮНЗГИЙРҮҮЛСЭН ШАЛГАЛТ ХИЙХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

хошууч Г.Галбадрах

Улсын хилээр нэвтэрч байгаа авто тээврийн хэрэгсэлд нуугдсан хил зөрчигч, хилээр нэвтрүүлэхийг хориглосон буюу хязгаарласан эд зүйлийг илрүүлэх зорилгоор үзлэг шалгалтыг хийдэг. Олон улсын практикт автомашинд нуусан хилээр нэвтрүүлэхийг хориглосон буюу хязгаарласан эд зүйлийг илрүүлэхийн тулд гүнзгийрүүлсэн шалгалтыг дараах байдлаар явуулдаг.


Автомашины дотор талд:

- Хянах самбарын ар тал
- Хөгжим болон кассетны үүр
- Жолоочийн хайрцаг
- Суудлын дэвсгэр дор
- Сандал, түшлэгний дотор, доод тал, хоорондын зай
- Цонхыг буулгаж үзэх
- Тоглоом болон машины чимэглэл
- Үнсний сав
- Толгойн түшлэг

Хянах самбарын ар тал ба жолоочийн урд талын хэсэг


- Урд хэсгийг битүүмжилсэн эсэх
- Аваарын бөмбөлгийг авсан эсэх
- Урд хэсгийн зарим эд анги хоосон байгаа эсэх






Хаалга

- Хаалганы жин мэдэгдэхүйц хүндэрсэн байх
- Тогших үед бөглүү чимээ сонсогдох
- Пластик хаалтны дотор хоосон зай бий эсэх
- Хаалтыг сольсон болон хөдөлгөсөн эсэх






Шал

- Шалыг зузаалсан эсэх
- Шалны бүрээсийг хуулсан болон шинээр тавьсан эсэх
- Нэмэлт утас байгаа эсэх

Таазны хэсэг


- Тааз хэтэрхий намхан байгаа эсэх
- Шинэ хадаастай байгаа эсэх
- Хадаас нь хуучин нүхнээсээ өөр газар хадагдсан байгаа эсэх





Суудал

- Суудал хатуу болон хүнд байгаа эсэх
- Суудлын бүрээс шинэчлэгдсэн болон нөхөөс тавигдсан эсэх





Гадна талд:

- Багажны хайрцаг
- Дугуйны нум
- Буферийн ар тал
- Урд гэрлүүд дотор
- Дугуйны таг
- Түлшний банкны хоолой

Урд талын буфер

- Нэмэлт тор төхөөрөмжилсөн эсэх
- Буферыг доторлосон эсэх
- Эд ангийг тогших үед өөр чимээ сонсогдох__

Хөдөлгүүрийн хэсэг

- Хөдөлгүүрийн хаалт хэтэрхий хүнд эсэх
- Шинэ болон нэмэгдэл зай хураагуур байгаа эсэх
- Шинэ болон нэмэгдэл утас, ороомог суурьлуулсан эсэх
- Радиатор болон тосны шүүлтүүр хүйтэн байх







Хянах самбарын үүрийн хэсэг

- Шинэхэн түлэгдсэн тэмдэг болон будагдсан эсэх
- Машины маркын тэмдэглэгээг хуулсан болон өөрчилсөн эсэх

Дугуй

- Шинэ болон цэвэрхэн эсэх
- Жигд бус, хавантай эсэх
- Гарын хээ болон мөр байгаа эсэх
- Дугуйны хошуунаас ер бусын үнэр үнэртэх
- Тогших үед хатуу биет мэдрэгдэх

Бензиний банк

- Шинэ банк тавьсан эсэх
- Шинэ эрэг болон эрэг нь хөндөгдсөн эсэх
- Тогших үед өөр чимээ сонсогдож байгаа эсэх





Багаж

- Хаалга маш хүнд байгаа эсэх
- Доторлогоо нь шинэ болон өөрчлөгдсөн эсэх
- Шал нь өргөгдсөн эсэх
- Илүү зай хураагуур болон хайрцаг байгаа эсэх
- Нөөц дугуй байгаа эсэх

Ар талын хэсэг

- Буферээ хатуулсан эсэх
- Шинэ улсын дугаартай болон бэхэлсэн эрэг нь шинэ сэвтэй эсэх





Машины доод тал

- Радиаторын доод хэсэг
- Моторын тосны шүүлтүүр
- Яндан
- Банкны доор
- Аралыг нийтэд нь
- Гагнуурын шинэ ул мөр байгаа эсэх
- Эд ангиуд галд түлэгдсэн шинж тэмдэгтэй эсэх

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад хартамхи, зэвсэг галт хэрэгсэл, бусад зах зээлийн эргэлтэд улс хооронд тээвэрлэлт хийн худалдаа хийхийг хориглосон бараа, эд зүйлсийг дээрх байдлаар тээвэрлэн гарахыг оролдсон, хэрэглэсэн заль мэхийг үзүүллээ. Манай улсын хилийн боомтуудаар энэхүү хэлбэрээр хориглосон болон хязгаарласан бараа, эд зүйлсийг гаргахгүй гэсэн баталгаа алга байна. Иймд хилийн боомтод тээврийн хэрэгслийн үзлэг шалгалт хийх манаанд томилогдсон хэн ч байсан сонор сэрэмжтэй шалгах зүй ёсны шаардлага гарч буйг анхаарах нь зүйтэй юм болов уу.

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР ОХУ-ЫН ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ УЛС ТӨР-ДИПЛОМАТ БОДЛОГО

дэд хурандаа Д.Жавхлант

ОХУ-ын гадаад бодлого нь ОУЭЗ-н нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэж байгааг түүний 1993 оны Үндсэн хууль болон эрх зүйн бусад чухал актад нотлон заасан байна. 1997 онд баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь энэ гүрэн гадаад бодлого, дипломат ажиллагаандаа олон туйлт бүтцийн дэг журам дэлхийд бүрэлдэн тогтох хандлага идэвхжиж байгааг харгалзжээ. Олон улсын харилцаанд цэргийн болон бусад хүчний гүйцэтгэх үүрэг арилаагүй байгааг дээрх үзэл баримтлалд тэмдэглэсэн байна.

Улс төр-дипломат ажиллагааны гол чиглэл нь олон улсын харилцааны аливаа асуудлыг уян бөгөөд бодит хэлэлцээний үндсэн дээр холбогдох талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг олж шийдвэрлэж байх, үзэл сурталжихаас чөлөөтэй байх зарчмыг баримтлаж байна.

ОХУ нь улс гүрнүүдийн эрх тэгш харилцааг хөгжүүлж, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь аливаа орны аюулгүй байдлыг хангах нэг чухал хүчин зүйл гэж онцлон анхаарч байна. Үүнээс үндэслэн өөрийн гадаад бодлогын зорилтуудыг улс төр-дипломатын аргаар хангахыг гол барилаа болгож, эн тэргүүнд тавьж байгаа гол зорилтуудаас дурдвал:

а) улс орны аюулгүй байдлыг улс төрийн аргаар бүх талаас нь хангах, тухайлбал түүний бүрэн эрх, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататгах;

б) хилийн эргэн тойронд болон бус нутаг, дэлхийн хэмжээнд тогтвортой байдлыг бэхжүүлэх;

в) ТУХН-ийн орнууд болон

ойр зэргэлдээ бусад улстай эрх тэгш, харилцан ашигтай, зарчмын шинэ харилцааг бүрэлдүүлэх, мөн ОХУ-ын эдүгээ шийдвэрлэж байгаа зорилтуудыг амжилттай хэрэгжүүлсэн туршлага бүхий улсуудтай түншлэлийн харилцаатай байх стратегийн чиглэлийг үргэлжлүүлэх. Тэгэхдээ, ТУХН нь ОХУ-ын гадаад бодлогод хамгийн чухал байр эзлэхийг цохон тэмдэглэж байгаа юм;

г) дэлхийн нөлөөллийн тэнцвэрт болон олон улсын харилцааг зохицуулах олон талын үйл явцад ОХУ-аас их гүрнийхээ хувьд гүйцэтгэх үүрэг ролийг нэмэгдүүлэх;

д) аливаа улсыг дайсагнагч юмуу нөхөрсөг гэж урьдаас ялгаварлан үзэхгүйгээр бүх улстай хамгийн найрсаг бөгөөд харилцан ашигтай харилцаа тогтоох эрмэлзлийг ОХУ үндэс болгох зэрэг юм.

ОХУ-ын хил орчмын нөхцөл байдал нь 2010 онд цэргийн номлолоо эргэн харж шинэчлэхэд хүргэсэн бөгөөд түүний 8 дугаар зүйлд "гадаад улс орнууд (гадаадын бүлэг улсууд) ОХУ болон түүний холбоотон улсуудын хилийн ойролцоох нутаг болон хил орчмын бүст цэргийн хүч байрлуулах (хуримтлуулах нь ОХУ-д гаднаас аюул учруулж байна гэж тооцохоор заасан нь хилийн аюулгүй байдлыг хангаснаар үндэсний аюулгүй байдал баталгаажиж байдгийг нотолж байгаа төдийгүй ОХУ-ын аюулгүй байдлын хил хязгаар нь тус улсын хилийн зурвасаас хальж хил дагуух хөрш орнууд болон холбоотон улсуудын хилээр зааглагдах болсон байна. Энэ нь ОХУ болон хөгжингүй бусад улс орнууд хилийн аюулгүй байдлаа хангах арга хэмжээг улсынхаа нутаг дэвсгэрийн заагаар хязгаарлахгүй түүнээс цааш холбоотон (хөрш зэргэлдээ) улсын хилийн аюулгүй байдал баталгаажсанаар өөрийн аюулгүй байдал хангагдана гэж үзэх болсныг харуулж байна. Өөрөөр хэлбэл ОХУ шинэ номлолдоо аюулгүйн жийргэвч бүсийг бий болгох үзэл санааг шингээжээ.

ОХУ-ын хилийн аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангахад ГХЯ нь чухал байр суурь эзлэх бөгөөд Оросын улсын хил орчимд болж байгаа мөргөлдөөнүүдийг зогсоох, сөргөлдөөнийг зохицуулах, тэдгээрийг ОХУ-ын нутагт дэлгэрүүлэхгүй байхын тулд ихээхэн шургуу дипломат ажиллагаа явуулдаг. ОХУ-ын нэгдмэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хадгалан бататгах нь дипломат ажиллагааны нэг чухал зорилт болсоор байгааг гадаад бодлогын үзэл баримтлалд нь цохон тэмдэглэсэн байна.

ОХУ-ын манай улстай хиллэсэн хилийн хэсэгт хилийн аюулгүй байдлыг хангах бодлогоо нутаг дэвсгэрээ тэлэх бодлого болгон хувиргаж, түүндээ улс төр-дипломатын аргыг хэрхэн ашиглаж байсныг түүхэн сургамжуудаас харж болно. Тухайлбал, ЗСБНХУ, Хятадын нэгэн адил улсын хил дээр түрэмгийлэл үйлдээгүй ч, Монголын талд ихээхэн дарамт шахалт үзүүлж Монгол Шарын даваанаас баруун тийш Асгатын дабааны хяр хүртлэх 1305 км Монгол улсын Туваатай хиллэдэг хэсгийг улс төр-дипломатын аргаар салган авсан байдаг (4 дүгээр хавсралт). Мөн түүнчлэн Кремль нь Монгол-Зөвлөлтийн хил тогтоох талаар санал гарч байх үед ч Увс аймгийн хойд хэсгийн асар уудам нутгийг Хөвсгөлийн баруун хойд

зах хүргэн таслаж авах төлөвлөгөөг Москвад боловсруулан Зөвлөлтийн төлөөлөгчид хилийн асуудлын талаарх өөрсдийн төлөвлөгөөгөө Монголын талд өгсөн бөгөөд энэ нь Увс аймгийн хойд талыг тэр чигт оруулаад, Тэсийн голоос хойшлоод Тагны нурууг давуулаад Хөвсгөл аймгийн Шишигтийн гол, Шишигтийн нуруу оруулаад зурсан гар зураг байв. Эцэст нь мөн адил Монголын төр засагт янз бүрийн шахалт үзүүлсээр зорилгодоо хүрч байсан юм.

Дээрх байдлууд нь Зөвлөлт засгийн нутаг дэвсгэрээ тэлэх зорилгоо "буу дуугаргахгүй" буюу улс төр-дипломатын аргаар хэрэгжүүлж бусдын нутгийг эзлэн таслаж булаан авах бодлого байсан. Өөрөөр хэлбэл Лео Пасволский "Эзэнт гүрэн, Зөвлөлт хоёрын дипломат бодлого өнгөн дээрээ өөр өөр боловчиг цаагуураа гайхалтай адилхан байдаг юм" хэмээн хэлсэнчлэн дээрх түүхэн баримтууд Орос улс нутаг дэвсгэрээ тэлэх бодлогоо хэрэгжүүлж байсан нэгэн жишээ бөгөөд газар нутгийн талаар баримтлах төрийн бодлого нь засаглалаас үл хамааран ихээхэн алсыг харсан байдгийг нотлож байна.

Өнөөдөр ОХУ хилийн аюулгүй байдлыг хангахад хилийн орон зайг эзэнгүйдүүлэхгүй байх бодлогыг хэрэгжүүлж байна. Тухайлбал 2001 онд баталсан "ОХУ-ын хил орчмын бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал" бөгөөд энэ нь ОХУ-ын хил орчмын бүс нутгийн субъектүүдийн хөгжлийг дэмжих, аж ахуй, соёл хүмүүнлэгийн харилцааг бэхжүүлэх, хилийн хоёр талд буй үндэс нэгт ард түмнүүдийн харилцааг энгийн болгох, найрамдлыг зузаатгах зорилготой юм. Энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлсэнээр хилийн бүсийн Тува, Буриад, Халимагийн хүн ардын эрх ашгийг харгалзан үзэж, ОХУ, түүний субъектүүдийн зүгээс хиллэж буй улстай тогтоосон эдийн засаг, нийгэм, соёл, захиргааны болон бусад харилцаа холбоог бэхжүүлсэнээр хилийн аюулгүй байдал хангагдах таатай нөхцөл бүрдэнэ үзэж байна.

Үүнээс гадна ОХУ нь хилийн аюулгүй байдлыг хангахад онцгой хч холбогдол өгч байгаа нь ОХУ-ын Холбооны Хилийн алба, түүний Ерөнхий командлалыг Холбооны яамдуудын адил эрхтэйгээр байгуулсан явдал юм.

Холбооны хилийн алба нь улсын хилийн болон эдийн засгийн бүсийн хамгаалалтыг хариуцаж Хилийн цэргийг зохион байгуулалтын хувьд бэхжүүлэн хөгжүүлэх төрийн бодлогыг боловсруулах чиг үүрэгтэй. ХХА-ыг ОХУ-ын сайдын эрх хэмжээтэй Хилийн албаны захирал, ерөнхий командлагч удирдах бөгөөд хилийн цэргийн үйл ажиллагааны үр дүнгийн тухай ОХУ-ын Ерөнхийлөгчийн өмнө тайлангаа тавьдаг болгон өргөжүүлсэн бөгөөд нь ердийн үзэгдэл биш юм. Энэ нь Алс Дорнодын байлдааны ажиллагааны театрын цэрэг-улс төрийн байдалтай шууд холбоотойгоор үүссэн гэж ойлгож болох юм.

ОХУ-ын хил дээр улсын болон ард түмнийхээ ашиг сонирхолыг хамгаалах, хилийн аюулгүй байдлыг хангах улс төр-дипломатын ажиллагааны үндсэн хэлбэр нь хилийн төлөөлөгчийн ажиллагаа юм.

ОХУ-ын хилийн төлөөлөгч, тэдгээрийн орлогч нарыг албан тушаалд томилох чөлөөлөхийг ОХУ-ын

ХХА-ны захирал зөвшөөрөл олгосноор ОХУ-ын Бүс нутгийн удирдах газрын дарга нар шийдвэрлэж байна. Харин хилийн төлөөлөгчийн аппаратын нарийн бичгийн дарга, орчуулагч нарыг томилох, чөлөөлөх асуудлыг ОХУ-ын ХХА-ны Бүс нутгийн удирдах газрын дарга шууд шийдвэрлэж байгаа бөгөөд хилийн төлөөлөгчийн орлогч нараас гадна тэдгээрийн туслахуудыг хилийн отряд, тусгай комендатурын офицеруудаас томилж байна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ АЖИЛ

ТЕХНИКИЙН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

дэд хурандаа Н.Батчулуун

Хил хамгаалах байгуулагын хангалтад байгаа дугуйт болон хуягт техник, мотоцикль, тусгай, зориулалттай автомашин /холбоо, хими, инженер, нисэхийн, засварын болон техникийн үйлчилгээний тээврийн хэрэгсэл/ ачааны ,суудлын автомашин, трактор, чиргүүлүүд нь төрөл бүрийн материалаар өндөр нарийвчлал-тайгаар боловсруулагдсан анги, хэсгүүд цахилгаан болоод цахимын бичил бүдүүвч схемүүдээс бүтсэн цогцолборуудын нэгдэл юм. Энэ машинууд нь дулааны энергийг механик энергид хувиргагч дотоод шаталтын хөдөлгүүрийн хүчээр хөдөлгөөнд шилжиж ажил гүйцэтгэдэг.

Улсын хил хамгаалах албаны зориулалттай автомашин, дугуйт болон хуягт тээвэрлэгч ,мотоцикль нь байгаль цаг уурын янз бүрийн нөхцөлд, тухайлбал газар орны тэгш болоод тэгш бус, элс шороо, ус намаг, цас зэрэг бартаа саадтай газруудад албаны бэлтгэл сургалт, албаны үүрэг гүйцэтгэдэг учраас тэдгээрийн зангилаа, цогцолбор механизмууд, эд анги, жижиг хэсэг нь механик хольц, химийн найрлагатай хольц, температурын нөлөөллөөс элэгдэлд ордог. Зохион бүтээгчдийн тооцоолсноор үйлдвэрээс гарч байгаа, автомашин, дугуйт болон хуягт тээвэрлэгчүүдийг бүтээлчээр урт хугацаанд зөв ашигласан нөхцөлд тэдгээрийн анхны чанарууд нь бага хэмжээгээр өөрчлөгдөх боловч цогцолбор механизмын хэвийн ажиллагаа алдагдах ёсгүй. Гэвч ашиглалтын янз бүрийн нөхцөлд автомамшины анхны чанар, үзүүлэлтүүд, хэмжигдэхүүнүүд нь зохих хэмжээгээр өөрчлөгдөн элэгдэж эвдрэх явдал байдаг. Хил хамгаалалтын бүх төрлийн техникүүд нь эрчимт ажиллагаанд зохицсон, түлш хэмнэх, хялбар жолоодогдох ,туулах өндөр чадвартай, техникийн үйлчилгээ,засвар хийхэд тохиромжтой зохион бүтээгдсэн гэж үздэг. Автомашин,хуягт техникийн чанар нь тэдгээрийн ашиглалт, найдвартай ажиллагаа, техникийн үйлчилгээний зохион байгуулалт, түүний чанараас онцгой их шалтгаална. Зэвсэглэл техникийн ашиглалт гэсэн ойлголтыг задалж зөв ойлгож хэрэглэх нь чухал юм. Иймд ашиглах, ашиглалт гэсэн ойлголт нь:

Автомашин, хуягт техникийг зориулалтын дагуу эзэмших, тэдгээрийн эвдрэлгүй байдал, хэвийн ажиллагааг хангахад хийгдэх техникийн үйлчилгээ тэдний чанар байдлыг урт удаан хугацаанд өөрчлөлтгүйгээр дахин эзэмшихэд бэлэн байлгахын тулд зохион байгуулж хийх, хадгалах, шаардлагатай газар нь эвдрэл гэмтэлгүйгээр хүргэхийн тулд тээвэрлэлт гэсэн 4 төрлийн үйлдлийн нэгдлийг "АШИГЛАЛТ" гэнэ. Ингэхлээр ашиглалт гэдэг нь: техникийн үйлчилгээ, эзэмшилт, хадгалалт, тээвэрлэлт гэсэн 4 төрлийн үйлдийн нэгдлээс бүтэж байна. Энэ нь техникийн ашиглалтын 4 үзүүлэлт юм.

Бид ашиглалтыг зөвхөн эдэлгээ буюу эзэмшилттэй андуурах явдал байдаг. Ашиглах, ашиглалт гэсэн үгийг дээрх 4 үзүүлэлтийн нийлбэр гэж ойлгож болно.

Автомашин техникийн эзэмшилт гэдэг нь: Тэдгээрийн үүрэг, зориулалтын дагуу өдөр ,сар жилээр тогтоож өгсөн гүйлт, шатах, тослох материалын лимитэд багтааж хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган зохих эрхийн актаар зөвшөөрөгдсөн зүйлд хэрэглэхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл бүх төрлийн зэвсэглэл машин техник, хувцас, материалуудын эдэлгээ эзэмшилт гэдэг нь тэдгээрийг тогтоож өгсөн үүрэг, зориулалт, норм лимитэд багтааж шаардагдах тушаал, дүрэм, заавар, хууль, тогтоомж, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган хэрэглэхийг хэлж байна. Иймээс ашиглалтын нэг үзүүлэлт болох эзэмшилт нь хувь болон бүлэг хүмүүсийн сахилга зохион багуулалт, санаачилга, мэргэжил, мэдлэгийн түвшин, тухайн зэвсэг машин техникийг ашиглах талаар гарсан дүрэм, заавар, хууль тогтоомжийг чанд сахин биелүүлснээр хангагдана. Гэтэл өөрийн эзэмшилдээ байгаа зэвсэг машин техниктээ эзний болон мастерын ёсоор хандахгүй зэргээс албаны зориулалтын зэвсэг машин техник тоногдох, эд анги нь солигдох, хугацаанаас өмнө эвдрэх, аваар осол гаргах зэрэг зөрчил дутагдал гарч энэ нь техникийн эзэмшилтийн үзүүлэлийг бууруулдаг байна. Эзэмшигч нь хэн боловч, тээврийн хэрэгслийг ажил үйлчилгээнд гарах үүрэг авмагцаа тэдгээрийн техникийн бэлэн байдлыг зохих заавар, зөвлөмжийн дагуу шалган бэлтгэж саадгүй үүрэг гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэх болно.

Цаашид техникийн ашиглалт эзэмшилт, хадгалалт үйлчилгээний талаар цуврал зөвлөмжүүд ниитлэгдэх болно.

ЦЭРГИЙН ЭКОЛОГИЙН ТУХАЙ ЗАРИМ АСУУДАЛ

ахлах дэслэгч С.Оюунчимэг

Агуулга: Цэргийн экологи, түүний тогтолцоо, цэргийн экосистем гэсэн ойлголтыг задлан шинжилж харьцуулан судлах замаар биологийн, үйлдвэрлэлийн, цэргийн экологийн тухай орчин үеийн ойлголтуудыг нарийвчилан судлахад оршино.

Түлхүүр үгнүүд: Экологи, цэргийн экологи, цэргийн экологийн тогтолцоо, эко систем, экологийн талаархи үзэл баримтлал.

Олон улсын хэмжээнд цэргийн экологи болон цэргийн экологийн хүрээнд хамаарах асуудлууд 1990-ээд оны эхнээс анх удаа үүсэн гарч эрдэмтэд өргөн хүрээтэйгээр судлах зайлшгүй шаардлага тулгарсан байна.

Цэргийн экологи гэдэг нь: (экологийн нэгэн шинэ салбар юм)-үндэсний аюулгүй байдал болон Монгол улсын зэвсэгт хүчин бусад цэргийн хүрээнд экологийн аюулгүй байдлыг хангах онолын үндэслэл, тэдгээрийг хэрэгжүүлэх практик арга зүйг боловсруулж улмаар аливаа цэргийн үйл ажиллагааг явуулахдаа хүрээлэн байгаа орчин, байгаль цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан цэргийн бүтэц, зохион байгуулалт, харилцан ажиллагаатай холбогдсон экологийн асуудлыг судлахад чиглэгдсэн хэд хэдэн салбар, шинжлэх ухааны зааг, уулзвар дээр үүсэн гарч ирэн хөгжиж байгаа салбар юм гэж эрдэмтэд тодорхойлдог байна.

Олон улсын хэмжээнд цэргийн экологи нь байгаль хамгааллын асуудлыг онцгойлон авч үзэж байгаатай холбогдуулан манай орны шинжлэх ухааны академиас батлан хамгаалах яам, зэвсэгт хүчин бусад цэргийн нэгтгэл, анги, салбаруудтай хамтран судалгааны болон практик ач холбогдолтой өргөн цар хүрээтэй арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна.

Цэргийн экологийг- инженерийн (үйлдвэрийн, авто тээврийн), технологийн, загас агнуур, хөдөө аж ахуйн (газар тариалан, мал аж ахуй) эрүүл ахуйн, уран барилга, хот байгуулалтын гэх зэрэг бусад хавсарга экологитой адилтган авч судлах нь оновчтой гэж дэлхийн эрдэмтэд тодорхойлсон байна.

Эдгээр хавсарга экологиуд нь хүн төрөлхтний амьдрал үйл ажиллагааны аль ч салбарыг ямар нэг доройтол, мөхөлд хүргэхгүйгээр байгалийн нөөц баялагийг ашиглах хамгийн зүй зохистой, оновчтой шилмэл аргуудыг сонгон судлах, хэрэглэх, хүн төрөлхтний биосферийг эвдэн бусниулах, сүйрүүлэх сөрөг үр дагавар, механизмуудыг тогтоон тодорхойлоход үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн байдаг. Экологи ба аюулгүй байдал гэсэн ойлголтууд нь өөр хоорондоо нягт уялдаа холбоо бүхий салбар бөгөөд Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль тогтоомжуудад онцгой байр суурийг эзлэх болоод байна.

Эндээс үндэслэн **экологийн аюулгүй байдал гэдэг нь:** -Экологийн онц аюултай нөхцөл байдал үүсэх үед хүрээлэн байгаа орчин, төр, нийгэм, хувь хүн найдвартай хамгаалагдсан байх нөхцөл байдлыг хэлдэг. Үүнтэй нэгэн адилаар цэргийн үйл ажиллагаанд экологийн аюулгүй байдал гэсэн ойлголт нь : -Байгалийн нөөц баялгийг зүй зохистойгоор оновчтой зөв ашиглах, хүрээлэн байгаа орчноо унаган төрхөөр нь хадгалах, нөхөн сэргээх, ард иргэдийн

болон цэргийн бие бүрэлдэхүүний амин чухал ашиг сонирхлыг сахин хамгаалахад чиглэгдсэн иж бүрэн цогц арга хэмжээг зэвсэгт хүчин бусад цэргийн нэгтгэл, анги, салбаруудаас авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм гэж цэргийн эрдэмтэд тодорхойлсон байна.

Ерөнхий экологи нь хүрээлэн байгаа орчин болон бүх төрлийн амьд организмын оршин тогтнох, амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлж хадгалан үлдээхэд үйлчилдэг зүй тогтол, хуулиудыг судалдаг бол **цэргийн экологи** нь байлдааны болон тайван цагт цэргийн ямар нэг үйл ажиллагаатай холбогдон хэрэгжиж байгаа цэргийн арга хэмжээг явуулах явцад цэргийн албан хаагчдын үүрэг гүйцэтгэх ур чадвар, нэгтгэл, анги, салбаруудын үүрэг биелүүлэх чадамжийг хадгалахад чиглэгдсэн экологийн шинжтэй асуудлуудыг судалдаг. Орчин үеийн нөхцөлд цэргийн үйл ажиллагаанд болон улсын хил хамгаалах өдөр тутмын үйл ажиллагаанд шинэ нэр төрлийн техник, хэрэгсэл технологийг өргөн хүрээтэй ашиглах болж байгаа нь цэргийн экологийн асуудалд онцгой анхаарах шаардлага гарч байна.

Энэ нь ялангуяа химийн, физикийн шинжлэх ухааны ололт амжилтанд тулгуурласан болон сансрын хиймэл дагуултай холбогдсон орчин үеийн техникийг ашиглах чиг хандлага давамгайлж улмаар цэргийн техникийн объектуудыг барьж байгуулах, байршуулах асуудал нь цэргийн экологийн онц чухал асуудал болоод байна. Цэргийн техникийн объектуудыг оновчтой байршуулах, зүй зохистойгоор ашиглах нь хүрээлэн байгаа орчинд экологийн хувьд хор хохирол учруулахгүй байх нөхцлийг бүрдүүлж байхыг шаардана. Цэрэг техникийн объектуудыг байршуулах гэдэг нь байгаль цаг уур, физик газар зүйн янз бүрийн бүсэд нийцсэн байх дүрэм журмыг тогтоож тухайн техник хэрэгслүүдийг үр өгөөжтэй ашиглах, бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, үүрэг гүйцэтгэх чадварыг удаан хугацааны туршид хадгалах, амьдрал үйл ажиллагаа, ахуй нөхцөлд нь зохицсон таатай эрүүл саруул орчинг бүрдүүлэхийг хэлнэ.

Цэргийн экологи гэсэн ойлголтын хүрээнд "Цэргийн экологийн тогтолцоо", "Цэргийн экосистем" гэсэн ойлголтууд нэн чухал ач холбогдолтой болохыг эрдэмтэд тэмдэглэж ирсэн. Үүнд: Бие бүрэлдэхүүн (цэргийн нэгтгэл, анги, салбарууд), цэргийн зэвсэг техникийг ашиглах үе шатлал болон хүрээлэн байгаа орчинд тэдгээрийн зүгээс нөлөөлөл үзүүлэхтэй холбогдсон асуудлууд хамаардаг.

Тухайлбал, тэдгээрт цэргийн хээрийн сургууль, дадлага явуулахад зориулагдсан хээрийн сургалтын цогцолбор, төвүүд, буудлагын талбай, цэргийн аж ахуй, ар талын хангалт үйлчилгээний зориулалттай газрууд зэрэг бусад төрлийн байгууламж, объектууд хамаарагдана. Цэргийн объектууд гэсэн ойлголтод: - байлдааны бэлтгэл сургалт явуулахад зориулагдсан байнгын байрлалын районд байрласан объектууд болон цэргийн нисэх буудал, тэдгээртэй холбогдсон үйлчилгээний зангилгаанууд, пуужингийн техник хэрэгслүүдийн байршлууд, удирдлагын байрууд, ар талын хангалтын бусад объектууд ордог байна. Эдгээрийг нийлүүлээд цэргийн экологийн тогтолцоо буюу үйл ажиллагаа явуулах хүрээлэн байгаа орчинтой нь хамтруулан цэргийн экосистем гэсэн ойлголтыг бүрдүүлдэг.

Олон улсын эрдэмтдийн үзэж байгаагаар цэргийн экологийн тогтолцоо нь орчин үеийн нөхцөлд тавигдаж байгаа шаардлагыг зохистой

түвшинд хүртэл хангаж чадахгүй байгаа бөгөөд цэргийн экосистем нь дэлхийн биосферт хамгийн их хор хохирол учруулаад зогсохгүй байгаль орчныг мөхөлд хүргэх аюулыг хадгалсаар байна гэжээ. Эндээс үндэслэн цэргийн сургалтанд, ялангуяа цэргийн сургуулиудад суралцагчдад (сонсогч, оюутнууд) заагдаж байгаа экологи, байгаль хамгаалал гэсэн хичээлийн агуулга ач холбогдлыг сайжруулахад анхаарал хандуулж тэдэнд экологи, байгаль хамгаалахтай холбогдсон сэтгэлгээний болон экологийн сэтгэл зүйн шилдэг чанаруудыг төлөвшүүлэх асуудлыг нэн түрүүнд авч судлах нь зүйтэй гэж үзэж байна.

Ялангуяа цэргийн экологи, цэргийн экологийн тогтолцоо, цэргийн экосистем гэсэн ойлголтыг судлан шинжлэх чиглэлээр суралцагчид болон багш нараас судалгааны чиглэлүүдийг сонгон авч бакалаврын, магистрын, докторын зэрэг олгох судалгааны ажилд өргөн хүрээтэй шинжилгээ судалгаа явуулах нь чухал байгааг үндэслэл болгон энэхүү сэдвийг дэвшүүлж байна. Цаашид энэ асуудлаар багш, сонсогчдыг оролцуулсан дугуйлан, секцийг ажиллуулан байгаль орчин, экологийн зөв хүмүүжилтэй ирээдүйн офицер, ажилтан албан хаагчдыг сургаж бэлтгэх нь хууль сахиулахын их сургууль, бусад цэргийн сургуулиудад дэвшигдэж байгаа нэгэн чухал ач холбогдолтой асуудал болж байна. Дараа дараагийн дугаарт энэхүү сэдвийг үргэлжлүүлэн дэлгэрүүлэн судлах болно.

СУРГАЛТЫН ОНОЛ, АРГА ЗҮЙ

ХИЛИЙН ОТРЯДЫН "ДҮРВЭГСЭД НЭВТЭРСЭН ҮЕИЙН АЖИЛЛАГАА"-НЫ СУРГАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

докторант, дэд хурандаа В.Жавхланцогт

ХО-ын сургалт бэлтгэл (цаашид СБ гэх) нь Монгол Улсын ҮАБ, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах чиг үүрэг, ХХБ-ын хэтийн хөгжил, улсын хил хамгаалалтын эрэлт хэрэгцээнд нийцсэн, бие бүрэлдэхүүнийг албаны үйл ажиллагааг зохион байгуулахад хэрэгтэй бүхэнд сургах зорилготойгоор явагдах бөгөөд цэргийн сургалтын онол, арга зүйн ерөнхий зүй тогтол, зарчмын дагуу зохион байгуулагддаг.

ХО-ын бие бүрэлдэхүүнд дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх ажиллагааг амжилттай зохион байгуулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, дадлага, чадварыг олгох нь ХО-ын бэлэн байдлын чадавхийг дээшлүүлэх нэг хүчин зүйл бөгөөд үүнийг сургалтаар хангах боломжтой юм.

ХО-ын СБ нь ХХБ-ын сургалтын тогтолцооны салшгүй хэсэг тул түүнийг салангад хэлбэрээр авч үзэх нь өрөөсгөл юм. Тиймээс дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх ажиллагааны сургалтыг боловсронгуй болгох асуудлыг ХХБ-ын сургалтын тогтолцоонд ХО-ын сургалт бэлтгэлийн эзлэх байр, суурь, харилцан хамаарлын зүй тогтолтой уялдуулан тодорхойлох нь оновчтой байж болох юм.

ХО-ын сургалт бэлтгэлийг зохион байгуулах ажиллагаа нь ХХЕГ-ын даргын баталсан ХХБ-ын "Сургалт бэлтгэл-2012" хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байна. ХХБ-ын СБ-ын зорилгыг "...хилийн отряд/анги/, застав/салбар/-ын албаны болон цагийн байдлын өрнөлтийн үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийг хангах..." **[Хил хамгаалах ерөнхий газар."Сургалт бэлтгэл-2012" хөтөлбөр.УБ.,2009.140х.9]** гэж тодорхойлсон нь улсын хил хамгаалах албаны үйл ажиллагааны явц дахь сургалтыг авч үзсэн байна гэж болох юм. Гэтэл уг зорилгыг хангах ХХБ-ын СБ-ын тогтолцоог "...цэргийн мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх, жигдрэлтийг хангах, хөгжүүлэх..." **[Хил хамгаалах ерөнхий газар."Сургалт бэлтгэл-2012" хөтөлбөр.УБ.,2009.140х.36]** гэсэн сургалтуудаас бүрдэхээр тодорхойлсон нь улсын хил хамгаалах албаны үйл ажиллагааны явц дахь болон хилийн албаны мэргэжилтэн бэлтгэх сургалтын бие даасан үйл явцыг тус тус нэгтгэсэн байна гэж үзэхэд хүргэж байгаа юм.

ХХБ-ын бүх шатны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургалт нь Монгол Улсын боловсролын хууль тогтоомжийн дагуу "Мэргэжлийн", "Бакалаврын", "Магистрын", "Докторын" гэсэн шатлал бүхий суралцагчид нийгмийн болон тухайн мэргэжлийн ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэхэд чиглэгдсэн, сургалтын тусгай эрх бүхий байгууллагуудаар зохион байгуулагдах

шаардлагатай бие даасан цогц үйл явц байдаг нь "Сургалт бэлтгэл-2012"-оор дэвшүүлсэн зорилготой төдийлөн зохицохгүй юм.

ХХБ-ын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургалт, ХО-ын СБ хэдийгээр тус тусдаа зохион байгуулагдах боловч агуулгын хувьд харилцан хамааралтай хэрэгжих зүй тогтолтой. Энэ нь ХО-ын СБ-ийг цэргийн мэргэжлийн шат шатны сургууль төгсөж, ХО-ын холбогдох албан тушаалуудад томилогдсон албан хаагчдын эзэмшсэн мэргэжлийн мэдлэг, чадварын төвшин дээр суурилан зохион байгуулагддагаар илэрч байгаа юм. Тиймээс дээрх сургалтуудын харилцан хамааралтай, зүй тогтолт шинжид үндэслэн, ХХБ-ын сургалт бэлтгэлийн цаг хугацаа, үечлэлд тулгуурлан, сургалт зохион байгуулж ирсэн өмнөх туршлага, түүний ололт, амжилтыг хөгжүүлэн боловсронгуй болгох зарчмаар ХХБ-ын сургалтын тогтолцоог дараах шаталсан хэлбэрээр авч үзэж болох юм **/1 дүгээр зураг/.** Дээрх байдлаар зохион байгуулагдсан сургалтын тогтолцооны загварчлалыг ХХБ-ын сургалтад нэвтрүүлж, улмаар мэргэжил олгох сургалтын байгууллагын мэргэжилтэн бэлтгэх сургалтын төлөвлөгөөнд нэгдүгээрт цэргийн сургалтыг зохион байгуулж явуулах онол, арга зүйн хичээлүүдийг шинээр нэмэх, хоёрдугаарт дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх ажиллагааны онолын үндэслэл, эрх зүйн орчин зэргийг холбогдох хичээлүүдийн агуулгад, ХО-ын ажиллагааны арга тактикийн нийтлэг авч үзэх агуулгыг "Хилийн алба" хичээлийн "Онцгой байдлын үеийн хил хамгаалалт" гэсэн бүлэгт тус тус нэмэн тусгаж бүх шатны мэргэжилтэн бэлтгэх сургалтыг зохион байгуулах шаардлагатай юм. Ингэснээр ХО-ын бие бүрэлдэхүүний хүрээнд зохион байгуулах дүрвэгсэд нэвтэрсэн үед авах арга хэмжээ, тактик, харилцан ажиллагааны сургалтыг боловсронгуй болгох үндсэн нөхцөл бүрэлдэнэ гэж үзэж байна.

Дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх ажиллагааны сургалтыг боловсронгуй болгох асуудлыг дангаар нь авч үзэх нь тогтолцоот шинж чанар бүхий ХХБ-ын сургалтын орчны хүрээнд дээр дурдсанчланөрөөсгөлойлголтболохюм. Тиймээс ХО-ын СБ-ийг боловсронгуй болгох асуудлын хүрээнд авч үзэх нь оновчтой бөгөөд боловсрол судлалын шинжлэх ухааны онол, УХХ албаны онцлогт нийцүүлэн дараах асуудлуудыг харилцан уялдаа холбоотойгоор цогц байдлаар шийдвэрлэснээр хангагдаж болох юм. Үүнд:

- Сургалтын үйл ажиллагааны чиг хандлага, тогтолцоо;
- Сургалтын хэрэгцээ, шаардлага;
- Сургалтын технологи;
- Сургалтын үр дүн, үнэлгээ тус тус болно.

ХО-ын албаны СБ-ийн дэд тогтолцоо нь нэг талаас цэргийн шинжлэх ухааны болон ХХБ-ын эрдэм шинжилгээ-сургалтын үйл ажиллагаатай, нөгөө талаас тухайн бүс болон ХО-ын УХХ ажиллагааны онцлогтой нягт уялдаа, холбоотойгоор шаталсан хэлбэрээр явагдах зүй тогтол бүхий хэлбэртэй байх шаардлагатай гэж үзэж байгаа юм **/2 дугаар зураг/.**

ХО-ын албаны СБ-ийн тогтолцооны төвшин бүрт онолын мэдлэг, олгох, чадваржуулах чиглэлийг зохистой

харьцааг тогтоох чиг хандлагыг баримтална. Өөрөөр хэлбэл ХО-ын албаны СБ-ийн тогтолцооны элементүүд болох бие бүрэлдэхүүний, манаа, салбаруудын жигдрэлтийн, удирдлага, штабын бэлтгэлийн сургалтуудад тус тус ялгамжтайгаар болон эдгээрийн дотоод бүтцэд буй сургалтад оролцогч субьектуудын төвшин бүрт онолын болон дадлагын сургалтын оновчтой харьцааг тогтоох юм.

Дүрвэгсэд нэвтэрсэн үеийн ажиллагааны сургалт бэлтгэл нь тухайн бүсийн онцлог, нөхцөл байдалтай шууд холбоотой бөгөөд ялангуяа дүрвэгсэд нэвтэрч болзошгүй чиглэлд байгаа ХО-ын СБ-ийн агуулгад бусад чиглэлийн ХО-уудаас илүү багтаамж, цагтайгаар, үүсэн бий болж болзошгүй цагийн байдалд тухайн ХО-ын боломжид тулгуурлагдсан ажиллагаа явуулахад чиглэгдсэн байх шаардлагыг бий болгож байна. Энэхүү шинж нь ХО-ын СБ нь "...сургалт, бэлтгэл нь хэрэгцээнд төвлөрсөн сургалт мөн" **[Эрдэнээ.Ц. Мэргэжлийн цэргийн сургалт хэрэгцээнд төвлөрдөг. Цэргийн шинэчлэл сэтгүүл.УБ.,2009.№2.т.16-20х.16]** үзсэн цэргийн салбарын эрдэмтдийн тодорхойлсон зарчимтай нийцэж байгаа юм. Тиймээс ХХБ-ын СБ-ийн хөтөлбөрт тухайн ХО-ын СБ-ийн агуулгад дүрвэгсэд нэвтэрсэн үеийн ажиллагааны арга тактикт сургах сэдвийг оруулах, сургалтын багтаамжийг тогтоох зэрэг асуудлуудыг өөрсдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тодорхойлох уян хатан сонголтын зарчмыг тусгаж өгөх шаардлагатай байна.

ХО-ын СБ-ийн агуулгад дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх ажиллагааны сургалтыг өөрийн хэрэгцээ шаардлагатай нийцүүлэн тусгасан тохиолдолд түүнийг зохион байгуулах арга ажиллагааг сургалтын технологийг боловсронгуй болгох асуудлын хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

ХО-ын "Сургалтын технологи" хэмээх ойлголтыг цэргийн хэрэг, УХХ-ын болон ХО-ын СБ-ийн онцлогт нийцүүлэн "Улсын хил хамгаалах албаны болон цагийн байдлын өрнөлтийн үед үүрэг гүйцэтгэж чадах мэдлэг, дадлага, чадвар, жигдрэлтийг олгох үйлийг зохион байгуулж, явуулах арга, хэлбэр, хэрэгслийг хамгийн оновчтой байдлаар ашиглах үйлдлийн эрэмбэ дарааллын зохистой хувилбар" гэж тодорхойлж болох юм.

ХО-ын СБ-ын технологи нь сургах ба суралцах, ажиллагааны жигдрэлтийг хангах үйлдлийн нэгдэл байх бөгөөд дээрх тодорхойлолтод үндэслэн хичээлийн агуулга хоорондын уялдаа бүхий стандарт, арга зүйн оновчтой хувилбар бүхий дараах бүтэцтэй байхаар загварчилж болох юм. Үүнд:

1. Сургалтын зорилго;
2. Агуулга;
3. Хэлбэр;
4. Хэрэглэгдэхүүн;
5. Арга;
6. Үр дүн;
7. Үнэлгээ тус тус болно /3 дугаар зураг/.

Сургалтын үйл ажиллагааны үр дүн, түүнд өгөгдөж буй үнэлгээ нь сургалтын зорилгыг дахин тодорхойлох эргэх холбоотой байх ба Хилийн отрядын сургалтын технологийн онцлог болно. Өөрөөр хэлбэл сургалтын агуулга нь Улсын хил хамгаалах алба, түүний явцад үүсэж болзошгүй цагийн байдлын

өрнөлтийн ямар ч үед үүрэг гүйцэтгэж чадах мэдлэг, дадлага, чадвартай байх зорилготой нийцэж байх ёстой гэсэн үг юм.

ХО-ын СБ-ийн технологийн загварчлал нь сургалтын тогтолцооны зүй тогтолын дагуу ХХБ-ын нийтлэг сургалтад адилхан үйлчлэх тул дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх ХО-ын ажиллагаанд бие бүрэлдэхүүн, хилийн манаа, томилгоот бүлэг, салбар нэгжүүдийг бэлтгэх сургалтыг боловсронгуй болгох асуудлыг дээрх сургалтын технологийн бүрдэл хэсгүүдийн дагуу авч үзэх нь оновчтой байж болох юм.

Дүрвэгсэд олноор улсын хил нэвтрэн орж ирсэн тохиолдолд ХО-оос авч хэрэгжүүлэх ажиллагааны арга тактикт сургаж, бэлтгэх асуудал нь тухайн ХО-ын УХХ-ыг зохион байгуулах явцад үүсэж болзошгүй ажиллагааны бэлэн байх хэрэгцээн дээр суурилж буй чанар, урьдчилан тогтоогдоогүй цагийн байдлын өрнөлтийн дагуу оновчтой шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх шаардлага зэргийг үндэслэн СБ-ийн зорилгыг тодорхойлох шаардлагатай юм. ХО-ын СБ-ийн зорилго нь "УХХ албаны болон цагийн байдлын өрнөлтийн үед үүрэг гүйцэтгэх мэдлэг, дадлага, чадвар ба чадавхийг олгоход оршино" гэж болох юм.

Дүрвэгсэд нэвтэрсэн үеийн ХО-ын ажиллагааны сургалтын агуулгыг сургалтын төлөвлөлтийн шаталсан зарчимд тулгуурлан бий болгож болох бөгөөд энэ тохиолдолд сургалтын төлөвлөлтийн баримт бичгүүдэд сэдвээр нь тусгаж өгсөн байх шаардлагатай юм. Гэтэл өнөөдөр ХО-ын СБ-ийн сургалтын тасгаас тодорхой агуулга, багтаамж үгүй хичээлийн нэрсийн жагсаалтыг тушаалаар батлуулан сургалтыг зохион байгуулж, байгаа нь сургалт явуулах цаг хугацаатай зохицохгүй, хичээлийн агуулгын уялдаа холбоо бүрдэхгүйд хүрч улмаар СБ-ээр дэвшүүлсэн зорилгыг хангахад сөргөөр нөлөөлж буй нэг хүчин зүйл болж байгаа юм. Тиймээс ХО-ын СБ-ийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсрол судлалын ухааны зарчим, нийтлэг хандлагын дагуу, УХХ алба, ХО-ын хэрэгцээ, боломжид үндэслэн дараах байдлаар эрэмбэлэн тогтоож, боловсруулах нь зүйтэй болов уу. Үүнд:

- Сургалтын төлөвлөгөө;
- Хичээлийн хөтөлбөр;
- Ээлжит хичээлийн цаг, сэдвийн төлөвлөлт тус тус болно.

Дээрх сургалтын баримт бичгүүдийг зөвхөн дүрвэгсэд нэвтэрсэн үеийн ХО-ын ажиллагааны сургалтын агуулгаар, бие даасан хэлбэрээр боловсруулна гэж ойлгож болохгүй юм. Дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдлэг, дадлага, чадвар олгох асуудлыг ХО-ын СБ-ын хүрээнд "Бие бүрэлдэхүүн"-ий, "Удирдлага, штаб"-ын, "Хилийн манаа, салбарын жигдрэлт"-ийн СБ-ийн төлөвлөгөөний агуулгыг бүрдүүлж буй хичээлүүдэд бие даасан сэдэв байдлаар оруулах нь оновчтой хувилбар байх болов уу.

ХО-ын СБ-ын сургалтын төлөвлөгөө нь харилцан хамааралтай агуулга бүхий хичээлүүдийн нэгдэл байх бөгөөд боловсруулахдаа ХО-ын СБ-ийг зохион байгуулж явуулж байгаа цаг хугацаатай шууд уялдаатай авч үзэх шаардлагатай. Өнөөдөр ХО-ын СБ-ийг албаны онцлогт нийцүүлэн дараах цаг хугацаа, үе шаттайгаар зохион байгуулж

явуулж байна. Үүнд:

- Байнгын бие бүрэлдэхүүний 1 дүгээр ээлжийн сургалт 1-4 дүгээр сарыг дуустал 4 сар, 2 дугаар ээлжийн сургалт 7-10 дугаар сарыг дуустал 3 сар буюу 7 сарын хугацаанд 7 хоногт 6 цагаар, нийт 168 цагийн багтаамжтайгаар нэг бүрийн бэлтгэл, бүлэг болон салбарын жигдрэлт, нэмэлт сургалт гэсэн дараалалтайгаар;

- Хугацаат цэргийн сургалтыг цэрэг татлагатай уялдуулан 2 ээлжээр зохион байгуулж, тус бүр "Цэргийн анхан шатны сургалт", "Нэг бүрийн сургалт", "Хилийн манаа, харуул/бүлгүүд/-ын сургалт, бэлтгэл", "Хилийн застав/салбар/-ын жигдрэлт"-ийг тус тус бүр 4 долоо хоногийн, "Албанд дадлагажуулах бэлтгэл"-ийг 10 хоногийн хугацаатайгаар;

- Түрүүч нарын сургалтыг сард 1 удаа 6 цагаар бага дарга, манааны ахлагч, инженер, техникийн бага мэргэжилтэн бэлтгэх сургалтыг 7 хоногийн хугацаатайгаар жилд 2 удаа тус тус зохион байгуулж байна.

Дээрх ХО-ын СБ-ийг зохион байгуулах цаг хугацааны шаардлагатай нийцүүлэн ХО-ын СБ-ийн төлөвлөгөөг тухайн жилийн ХХЕГ-ын даргын удирдамжийн дагуу тухайн чиглэлийн УХХ хэрэгцээ шаардлагад үндэслэсэн агуулга, багтаамжтайгаар боловсруулж, ХО-ын даргын тушаалаар баталгаажуулан зохион байгуулж болох юм. Мөн СБ-ийн төлөвлөлтийг хийхэд зайлшгүй харгалзан үзэх нэг асуудал бол сургалтын үе шатууд юм. Сургалтын үе шатууд нь сургалтын агуулгыг цагийн байдлын өрнөлтөд бие бүрэлдэхүүн, бүлгүүд, нэгж, салбаруудын гүйцэтгэх үүрэг шатлан өргөжих ажиллагааны болон цэргийн сургалтын зарчимтай нийцсэн залгамж чанартай байх шаардлагад үндэслэгдэнэ. Сургалт явуулах цаг хугацаа, УХХ албаны болон цагийн байдлын өрнөлтийн үед үүрэг гүйцэтгэхэд бэлтгэх цэргийн сургалтын шаардлагыг харгалзан дүрвэгсэд нэвтэрсэн үеийн ажиллагааны сургалтыг дараах байдлаар ХО-ын СБ-ыг үе шатанд хуваан авч дэс дараалсан хэлбэрээр зохион байгуулж болох юм. Үүнд:

1. УХХ албаны бэлтгэл сургалт:

- Бие бүрэлдэхүүний сургалт;
- Удирдлага, штабын сургалт;
- Хилийн манаа, салбарын бэлтгэл;

2. Цагийн байдлын өрнөлтөд үүрэг гүйцэтгэх бэлтгэл сургалт /тусгай үүргийн сургалт/:

- Хүн нэг бүрийн бэлтгэл сургалт;
- Удирдлага, штабын бэлтгэл сургалт;
- Хилийн харуул, манаа, бүлгүүдийн жигдрэлт;
- Хилийн отряд, застав, салбарын жигдрэлт;
- УХХ-д дэмжлэг үзүүлэх байгууллагуудын харилцан ажиллагааны жигдрэлт тус тус болно

ХО-ын СБ-ийг УХХ албаны бэлтгэл сургалтыг бие бүрэлдэхүүнд хил хамгаалах албаны онол, эрх зүй, тактик, харилцан ажиллагааны зарчим зэрэг суурь мэдлэгийг олгох, бататгах, сэргээх чиглэлээр явуулж, улсын хилийг ердийн болон хүч нэмэгдүүлсэн хамгаалалтын хэлбэрүүдэд авч хэрэгжүүлэх ажиллагааны дадлага, чадвар олгох чиглэлийг тусгасан агуулгатай байж болно. Энэ тохиолдолд дүрвэгсдийн талаарх олон улсын эрх

зүйн хэм хэмжээг "Эрх зүй"-н, авах арга хэмжээний ерөнхий зарчим, тактик, Монгол Улсын болон хил орчмын нутаг дэвсгэрийн онцлог, УХХ-ыг өөрчлөн зохион байгуулах хэрэгцээ, шаардлага, үндэслэл зэрэг асуудлыг "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал", "Хил хамгаалах урлаг" болон "Хилийн алба"-ны хичээлүүдэд бүлэг сэдэв байдлаар тус тус тусган оруулж, бие бүрэлдэхүүнд дүрвэгсдийн эрх зүйн байдлын талаарх мэдлэг олгох боломжтой юм.

Цагийн байдлын өрнөлтөд үүрэг гүйцэтгэх бэлтгэл сургалт /тусгай үүргийн/-ыг цагийн байдлын тодорхой нөхцөлд, дүрвэгсэд нэвтэрсэн үеийн "Аюулгүй байдлыг хангах", "Түр хамгаалалт олгох" арга хэмжээг хэрэгжүүлэх томилгоот бүлгүүдэд үүрэг гүйцэтгэх албан тушаалтан, цэргийн алба хаагчдыг томилгооны дагуу бүлэглэж, дараах агуулгатай байхаар зохион байгуулж болох юм. Үүнд:

1. Хүн нэг бүрийн бэлтгэл сургалт:

- Аль ч бүлгүүдэд томилогдон үүрэг гүйцэтгэх чадвар эзэмшүүлэх;
- Ажиллагааны явцад өгөгдөх үзэгдэх болон биет дохиог ашиглаж чаддаг байх;
- Шаардлагатай нөхцөлд хуулийн дагуу байлдааны зэвсэг, тусгай хэрэгслийг чадварлаг ашиглаж чаддаг байх;
- Улсын хилээр нэвтрэн орж ирсэн бөөн иргэдийн үйлдлээс дүрвэгсэд болон өдөөн хатгах үйлдлийн ялгааг таних чадвартай байх;
- Ажиллагааны зорилгыг өөрийн томилгоот үүргийн хүрээнд хангах, биеэр гүйцэтгэх дадлага эзэмших;

2. Удирдлага, штабын бэлтгэл сургалтыг Хилийн манаа, Харуул, Заставын болон томилгоот бүлгүүдийн, штабын алба, нэгжийн дарга нарын хүрээнд:

- Урьдчилсан болон шууд бэлтгэлийг хангах арга хэмжээг тодорхойлох;
- Ажиллагааг зохион байгуулах, шийдвэр гаргах;
- Ажиллагааг удирдах, харилцан ажиллагаатай байгууллагуудад зарлан мэдээлэх, хүч хэрэгслийг татан оролцуулах;
- Газар орон дээр байр зүйн болон тактикийн баримжаалал хийх;
- Дүрвэгсдийн үйдлийг баримтжуулах, хуулийн шаардлагын дагуу бэхжүүлэн авах арга зүйг эзэмших;
- Үүссэн нөхцөл байдлыг үнэлэх, томилгоот албан тушаалын эрхийн хүрээнд оновчтой шийдвэр гаргах;
- Хөрш улсын болон олон улсын түгээмэл гадаад хэл дээр дүрвэгсэдтэй холбоотой сэдвээр анхан шатны ярилцлага хийх;
- Хүч хэрэгслийн боломж, чадавхийг тооцох;

3. Хилийн харуул, манаа, бүлгүүдийн жигдрэлт:

- Хилийн манаа өгөгдсөн үүргийн дагуу томилгоот үүргээс шилжин ажиллах журам;
- Дүрвэгсэд ба бөөн иргэд нэвтэрсэн үеийн томилгоот бүлгийн гишүүдийн үүргийн хуваарилалт, авах арга хэмжээний дараалал;
- Харилцан аюулгүй байдлыг аргачлал;
- Ажиллагааны район хүртэл хөдөлгөөн үйлдэх журам;

4. Хилийн отряд, застав,

салбарын болон УХХ-д дэмжлэг үзүүлэх байгууллагуудын харилцан ажиллагааны жигдрэлтыг цагийн байдал үүсгэх замаар сургалт явуулж байгаа салбарын гүйцэтгэх үүргийг тухайн салбараас томилогдох бүлгүүд, албан тушаалтнуудын гүйцэтгэх үүрэг, харилцан ажиллагааг цаг хугацаа, газар орон дээр үүрэг гүйцэтгэх дадлага олгох агуулгыг тус тус тусгах замаар бүрдүүлнэ.

Дүрвэгсэд нэвтэрсэн үеийн ХО-ын ажиллагааны сургалтын технологийн дэд тогтолцоо болох сургалтын хэлбэр нь дээрх сургалтын үе шатны агуулгатай шууд хамараалтай байдаг зүй тогтолтой. ХО-ын СБ-ын үе шат болох "УХХ албаны бэлтгэл сургалт"-ын үр дүнд тулгуурлан "Цагийн байдлын өрнөлтөд үүрэг гүйцэтгэх бэлтгэл сургалт /тусгай үүргийн сургалт/"-ыг зохион байгуулах бөгөөд УХХ албаны онцлогийг тусгасан цэргийн сургалтын дараах хэлбэрүүдийг ашиглаж болох юм. Үүнд:

- Хүн нэг бүрийн СБ-д "Лекц", "Семинар", "Бие даалт", "Бүлгийн дасгал", "Хээрийн нэгдсэн хичээл"-ийг;
- Удирдлага, штабын СБ-д "Бүлгийн дасгал", "Тактикийн аргачилсан цогцолбор дасгал", "Тактикийн шуурхай дадлага", "Штабын нэгдсэн болон хэсэгчилсэн дадлага", "Команд-штабын сургууль", "Команд-штабын хээрийн сургууль"-ийг;
- Хилийн харуул, манаа, бүлгүүдийн жигдрэлтийн СБ-д "Тактик жагсаалын хичээл", "Тактикийн хичээл"-ийг;
- ХО, застав, салбаруудын болон УХХ-д дэмжлэг үзүүлэх байгууллагуудын харилцан ажиллагааны жигдрэлтийн СБ-д "Тактик жагсаалын хичээл", "Тактикийн хичээл", "Тактикийн хээрийн сургууль"-ийн хэлбэрүүдийг тус тус ашиглан зохион байгуулах боломжтой юм.

Дүрвэгсэд нэвтэрсэн үеийн ХО-ын ажиллагаад сургах жигдрэлтийн сургалт нь цэргийн шинжлэх ухааны онол, арга зүйн хүрээнд цэргийн сургалтын дээр дурдсан тусгай хэлбэрийг ЦАХ-дад цогц чадамж эзэмшүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн хичээл хоорондын харилцан уялдаа, логик дарааллын эрэмбэ бүхий цогцолбор байдлаар зохион байгуулах шаардлагатай.

ХО-ын сургалтын технологийн нэг бүрдэл хэсэг бол сургалтын хэрэглэгдэхүүн юм. Сургалтын хэрэглэгдэхүүн нь прагматик сургалтын чиг хандлагад тулгуурласан ХО-ын СБ-ийг зохион байгуулахад анхаарах чухал үзүүлэлт байна.

Дүрвэгсэд нэвтэрсэн үеийн ХО-ын ажиллагааны жигдрэлтийн сургалт нь цэргийн сургалтын хэлбэрүүдийн онцлогт нийцсэн хэрэглэгдэхүүнийг бэлтгэх бөгөөд нийтлэг дараах хэсэгт хуваан авч үзэж болох юм. Үүнд:

1. Төлөвлөлтийн бичиг баримтууд:
   - Сургалт явуулах бодлого төлөвлөгөө;
   - Сургалтыг удирдах төлөвлөгөө;
   - Тактикийн цагийн байдал;
   - Цагийн байдал хөгжүүлэх төлөвлөгөө;
   - Сургуулийн удирдагчийн гарын авлага;
2. Материал, техник хэрэгслүүд:
   - Байр зүйн зураг
   - Техник хэрэгсэл
   - Шатах, тослох болон бусад

материал

- Дууриалган үзүүлэх хэрэгслүүд тус тус болно.

Дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх ХО-ын ажиллагааны сургалтын технологийн нэг бүрдэл бол "Сургалтын арга зүй" юм. Сургалтын арга зүй нь ХО-ын СБ-ийн хүрээнд дүрвэгсэд болон бөөн иргэдийн асуудлыг шийдвэрлэх сургалтын чиг хандлага, агуулга, хэлбэр, хэрэглэгдэхүүнд үндэслэгдсэн, цэргийн шинжлэх ухааны хууль, зүй тогтол, зарчимтай нийцсэн, сургалтын зорилгыг хангах, үр дүнг бий болгоход чиглэгдсэн зарчим, арга, аргачлалыг цогцоор тодорхойлсон байна.

Дүрвэгсэд нэвтэрсэн үеийн ХО-ын ажиллагааны сургалтыг дээр дурдсанчлан агуулга, сургалтын үе шат тус бүрээр хүрсэн байх төвшинг тодорхойлох замаар шаталсан үнэлгээний системийг бий болгох нь сургалтын үр дүнг тодорхойлох ХО-ын СБ-ын технологийн гол элемент байна. Дүрвэгсэд нэвтэрсэн үед авч хэрэгжүүлэх ХО-ын ажиллагааны талаар ямар нэг туршлага сургамж байхгүй, уг сэдвээр сургалт зохион байгуулагдаагүй байгаа тул энэхүү судалгааны ажлаар дэвшүүлсэн ажиллагааны тогтолцоо, арга тактикийг турших, ХО-ын СБ-ийг боловсронгуй болгох сургалтыг зохион байгуулах шаардлагатай юм. Тиймээс ХХЕГ-ын мэргэжлийн хэлтэс, Хилийн албаны сургуулийн мэргэжлийн тэнхимийн багш, эрдэмтэн судлаачид, НҮБ-ын ДДКГ-ын Монгол Улс дахь төлөөлөгч, хүмүүнлэгийн болон УХХ-д дэмжлэг үзүүлэх байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан хамтарсан Команд штабын сургуулийг явуулж, үр дүнг нэгтгэн энэхүү сэдвээр сургалт явуулах заавар боловсруулан ХО-ын СБ-ын хүрээнд зохион байгуулах боломжтой юм. Цаашид ХХЕГ-ын сургалт, цэргийн албаны зохион байгуулалтын хэлтсээс жил бүрийн цагийн байдлын өрнөлтийн үед үүрэг гүйцэтгэх сэдвийг ХХБ-ын хэтийн эрэлт хэрэгцээ, хөгжлийн чиг хандлагатай уялдуулж, тодорхойлон, ХХБ-ын сургалтын нэгдсэн тогтолцооны хүрээнд эрдэм шинжилгээ, судалгаа-сургалт бэлтгэл гэсэн цогц байдлаар хэрэгжүүлэхээр зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

1 дүгээр зураг

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ЗАГВАРЧЛАЛ

2 дугаар зураг

ХИЛИЙН ОТРЯДЫН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ТОГТОЛЦООНЫ ЗАГВАРЧЛАЛ

3 дугаар зураг

ХИЛИЙН ОТРЯДЫН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЗАГВАР

ОЮУНЫ ЗУРАГЛАЛ ХЭМЭЭХ ШИНЭ БИЧИГ ҮСЭГ

доктор, профессор, бэлтгэл хурандаа Д.Нямдорж

Хүн төрөлхтөн гурван төрлийн бичиг үсгийг мэддэг гэнэм, Үүнд:

1.Уламжлалт бичиг үсэг

2.Шинжлэх ухааны бичиг үсэг

3.Оюун ухааны бичиг үсэг

Монголчууд уламжлалт бичиг үсэгт бараг бүгдээрээ тайлагдсан, шинжлэх ухааны бичиг үсэгт хэдхэн хүн тайлагдсан, харин оюун ухааны бичиг үсэгт огт тайлагдаагүй гэвэл та зөвшөөрөх үү? Зөвшөөрөхөөс аргагүй гэнээ, яагаад гэдгийн учир харин яваандаа тайлагдана, дуустал тэвчээртэй уншигтун.

Уншигч та бичиг үсэгт тайлагдсан уу гэж асуувал танд хачин сонсогдох байх,... та "Би бичиг үсэгт тайлагдаагүй байж чиний бичсэнийг уншиж байгаа хэрэг үү" гэх биз, гэтэл тийм биш болоод байна, учрыг өгүүлье.

Хүн төрөлхтөн 1) Анхдагч түвшний буюу уламжлалт, 2) Дунд түвшний буюу шинжлэх ухааны, 3) Дээд түвшний буюу оюуны гэсэн гурван бичиг үсэгтэй ажгуу. Тэгэхлээр, тухайн хүний бичиг үсэгт тайлагдсан эсэхийг асуухдаа чухам аль түвшнийх нь вэ гэдгийг эхэлж тодруулах шаардлагатай болох юм. Бичиг үсэг гэж ерөнхий ярих бус доод-дунд-дээд түвшний бичиг үсэг гэж ялган салгаж ярих учиртай.

НЭГ. УЛАМЖЛАЛТ БИЧИГ ҮСГИЙН ТУХАЙ

Хүн төрөлхтөн бичиг үсэг гэдэг ойлголтыг цаг үе бүрд өөр өөрөөр ойлгож, тэр хэмжээгээрээ бичиг үсгээ сайжруулсаар эдүгээтэй золгосон байх бөлгөө...Эрт үеийн хүмүүс хад чулуун дээр ан гөрөөсний гэх мэт олдэв зураг сийлдэг байж. Эдгээр нь одоогийн бидэнд түүхийн дурсгал, соёлын их өв төдийгүй хаана, ямар үндэстэн, хэдүйд амьдарч байсан, бид яг энд байсан эсэхийг тодруулах баримт юм. Өвөг дээдэс маань аажмаар хэд гурван дүрс бүхий бичигтэй болжээ, өмнөхөөсөө хамаагүй том дэвшил, тэгээд дүрсийнхээ тоог олшруулав, зарим газарт тэмдэгт зохиож эхэлж, түүнийгээ галиглан дуудах болов.

Тэмдэгт үсэг ашиглах нь дүрс бичгээ бодвол сурах, хэрэглэхэд хялбар байсан тул тархах нь илүү байжээ. Бичиг үсгийн анхны хэлбэр нь "юм бичиг" гэх бөгөөд цааш нь "зураг бичиг", "санаа бичиг", "өгүүлбэр бичиг", "үеийн бичиг", "цагаан толгойт бичиг" гэсэн дараалалтай гэнэ. Томоохон бүс нутаг юмуу хаагдмал овог аймгууд өөр өөрсдийнхөөрөө үсэг зохиож байв, ингээд олон үсэг бичиг үүссэн байна, бас үүнд хаадын ч гэмээр ухаантны ч гэмээр хүчин зүйл нөлөөлж нэг үндэстэн гэхэд л үе үе бичиг үсгээ өөрчлөн сольж байж, энд дэвшил ч байсан, уруудалт ч байсан.

Та бидний энд ярилцан буй дүрс болон үсэг хэрэглэдэг бичиг үсгийг **уламжлалт бичиг үсэг** хэмээдэг. Уламжлалт бичиг үсгээр санаа бодлоо бичиж илэрхийлдэг юмуу бусдын бичсэнийг тайлан уншиж чаддаг хүнийг уламжлалт бичиг үсэгт тайлагдсан гэнэ. Бичиг үсэгт тайлагдах түвшин нь хувь хүн, өрх гэр, байгууллага, улсын

хэмжээнд ялгаатай байж болно.

Монголчууд бидний хувьд гэхэд, 1206 онд Их монгол улс уйгуржин бичгийг /Монгол бичиг, Худам монгол, Хуучин бичиг гэх мэт нэртэй/ төрийн бичиг болгосон, 1269 онд Хубилай хаанызарлигаар Пагва лам Лодойжалцан дөрвөлжин бичиг зохиож төрийн албаны бичиг хэмээн зарласан. Энэ бичиг Юан гүрний мөхөл 1368 он хүртэл 100 жил хэрэглэгджээ. 1648 онд Зая бандид Намхайжамцын зохиосон тод бичгийг ойрдууд 300 гаруй жил хэрэглэсэн, одоо ч ОХУ-ын халимаг, БНХАУ-ын Шинжаанд ашигласаар байна. 1686 онд улс төр хийгээд шашны номын тусгай зорилгоор Энэтхэгийн ланз үсэгт дулдуйдан өндөр гэгээн Занабазар соёмбо үсэг зохиосон. Улс төрийн зорилго нь манж нарын түрэмгийллийг сөргүүлэн Монгол улсын тусгаар тогтнолын бэлэгдэл болгох, шашны номын тусгай зорилго нь шашин суртлын хүрээнд номын гурван гол хэл буюу монгол, төвд, самгард хэлээр нэгэн зэрэг бичиж болохуйц байхад оршин байжээ. Бас Занабазарыг хэвтээ дөрвөлжин бичиг зохиосон ч гэлцдэг. Байгаль нуурын орчимд өнгөрсөн зууны эхээр буриад лам Агваандоржиев монгол хийгээд тод үсгийн хэлбэр дүрсийг тусгасан "буриад шинэ үсэг" хэмээхийг зохиожээ, олон ард Вагиндрагийн үсэг гэдэг, Агвааныг самгардаар Вагиндра гэнэ.

Одоогийн бидний хэрэглэдэг шинэ үсгийн /Кирилл/ дүрэм 1942 онд гарч, 1946 оны 1 сарын 1-нээс "...бүх хэвлэл ба улсын албан хэргийг шинэ үсгээр..." явуулах болсон. Манай аав, ээж нар 1930-аад онд латин үсэг сурсан гэдэг, бидний үеийнхэн 1960-аад онд кириллд тайлагдсан, хүүхдүүд маань 1990-ээд онд уйгуржин бичигтэй болохчоон аядаад одоо уйгуржин ч үгүй, кирилл ч үгүй, харин хагас дутуу латинтай болох нь ээ,... бидний гурван үе гэхэд л гурван өөр уламжлалт бичиг үсэгтэй боллоо,... энэ бол 20 дугаар зууны түүх, одоо интернет, энээ тэрээ гэхээр кирилл үсэг нэг л биш ээ, сольж таарах нь гээч, латин руу шилжинэ гэсэн үг л дээ, гэтэл хятадууд дэлхийд ноёлох үед ханз-руу хазайхад хүрнэ, үүнийг мэдэрсэн хүмүүс ханз руу хандраад эхэлсэн нь нууц биш, тэгж байтал арабууд өндийнө, араас нь бичдэг араб бичиг рүү бас л хазайх уу?,... бичиг үсгээ солих бүрд л бүх хүн маань бичиг үсэггүйд тооцогдоно, улсынхаа бүх хүнийг шинэ бичигт тайлах их ажил өрнөнө,энэ ажлыг хийхгүй байх аргагүй ээ, эс хийвэл хөгжил дэвшлээс бид л хоцорно, ийнхүү та бид дөрвөн зүг найман зовхис руу үсчсээр байх нь ээ.

Уламжлалт бичиг үсэг буй болсноор хүн төрөлхтөнд мэдлэг хуримтлуулах, түүнийгээ хойч үедээ дамжуулах том бололцоо нээгдсэн бөгөөд үүний ачаар хүн төрөлхтөний танин мэдэхүй урагшилж, шинжлэх ухааны хур их мэдлэгийн сан бүрдсэн билээ.Энэ бол уламжлалт бичиг үсгийн давуу тал нь. Уламжлалт бичиг үсэгт бас сул тал бий, олон хэл дээр олон бичиг үсгээр байгаа мэдээллийг нэгээс нөгөө рүү нь хөрвүүлэх, хүмүүст хүргэхэд багагүй цаг гарздаж маш их хөрөнгө хий хоосон урсдаг.

Хүн өөрийнхөө үр төлийг л хөөрхөн, сайхан гэдэг, улс үндэстнүүд ч мөн ийм, манай бичиг үсэг л хамгийн сайн нь, хөөрхөн нь гэж номлодог, та нар биднийг дага, наад муухай шувууны

мөр шиг юмаа орхи гэж бусдыгаа ятгана, хүчтэй нь хүчгүйгээ сүрдүүлнэ, ингээд хэрүүл маргаан үүсдэг, үүссээр ч байна, хүчтэй нь ялдаг хорвоо юм чинь бид ялагдах биз, муу амлалаа гэвүүзэй, энэ янзаараа байвал бид ялагдана, харин ялахын төлөө, ядаж л ялахгүй ч гэсэн ялагдахгүй, эн чацуу байхын төлөө зүтгэе гэвэл өөр хэрэг л дээ,... даяаршлын найранд ганзгалж очоод бусдад үзүүлж бардамнах, нүүр тахлах хоёр гуравхан юмны маань нэг нь энэ уйгуржин юм шүү дээ, уг нь.

Уламжлалт бичиг үсгийг эртний грекийн аугаа их сэтгэгч Сократ үл тоодог байж, тэрээр "бичиг үсэг гэдэг чинь хүний сэтгэлгээг хаан боогдуулж таарна, хэдхэн үсгийг яаж ч холбосон хүний санааг яагаад ч бүрэн илэрхийлж чадахгүй, тийм ёс хаа ч байхгүй" гээд бичиг үсэг сураагүй гэдэг. Үнэхээр ч тийм, жишээлбээс, инээж баярласан хэдэн хүн байг, яг ижилхэн хэмжээтэй баярлана гэж яав ч байхгүй, инээх нь хүртэл ялгаатай, зарим хүн баярлахаараа уйлдаг, уйлах нь бас л өөр, гэтэл үсэг бичгээр үүнийг яаж оноож илэрхийлэх вэ?, аргагүй л хүч дутна, баярлав-уйлав гэхэд л болчих уу, дэндүү ерөнхий байна.

Монголчууд бид өнгөрсөн зуунд уламжлалт бичиг үсгээ 3 удаа сольсон, одоогоор нэг л тодорхой бус байдалтай болчихлоо... Манай эрдэмтэд үүнийг голдуу улс төрийн талаас нь тайлбарладаг. Одоо бодохнээ нь, бас ч гэж дан ганц улс төрийн шалтгаан байгаагүй бололтой юм, гол нь эдгээр бичиг үсэг монгол хүний оюуны хэрэгцээг хангахдаа сул, бидний сэтгэх хурдыг гүйцэж чадахгүй байжээ. Бодол гүйцдэг босоо бичиг хэмээх уйгуржин нь бусдаасаа илүү, гэхдээ мэдээж хэрэг, бодлыг яаж гүйцэхэв, бодол сэтгэлгээ гэдэг хормын хурдтай билээ.

Хүний тархинд бодол санаа нэг дор цулаараа орж ирнэ, эхлээд хагас нь дараа нь нөгөө хагас нь гэх мэтчилэн унжран сунжрахгүй, гар хурууны хөдлөх хурдыг дагаж аажмаар ар араасаа бага багаар мөлхөн ирдэг, дугаарлан зогсдог бодол гэж байхгүй ээ.

ХОЁР. ШИНЖЛЭХ УХААНЫ БИЧИГ ҮСЭГ

Шинжлэх ухааны хур их мэдлэгийг хойч үедээ дамжуулах, шинжлэх ухааны салбаруудын хооронд мэдээлэл солилцоход уламжлалт бичиг үсэг хүч мөхөсдөнө. Том зузаан толь бичиг хэрэглээд ч хүч дутна, бас алдаа мадаг гарна. Аугаа суут Эйнштейний томъёолсон "харьцангуйн ерөнхий онол"-ын тэгшитгэлийг /огторгуйд буй масс, энергийн холбоосыг харуулдаг 4 хэмжээст 16 компонент бүхий тензор тэгшитгэл/ яаж үгээр илэрхийлэх вэ?, англи хэлнээс яаж монгол руу хөрвүүлэх вэ?, ядаж л "тензор" гэдэг үгийг оноож зөв орчуулахсан.Ийм учир шалтгааны улмаас шинжлэх ухаан нь өөрийн гэсэн бичиг үсэгтэй болсон байна, үүнийг загвар хэмээмой. Загвар гэхээр зарим эрдэмтэд "мода загвар, модель загвар" гээд ойлгочих гэм буй, би охид хүүхнүүдийн бие хувцасны загварыг бус, шинжлэх ухааны "тоон загвар"-ыг ярьж байна.

Тоон загвар гэхээр математик загвар бөлгөө. Яагаад заавал тоон загвар гэсэн, яагаад түүхийн загвар, философийн загвар, эрүүл мэндийн загвар, эрх зүйн загвар гэхчлэн бусад шинжлэх ухааны салбаруудаар нэрлээгүй нь дараах

учиртай, тайлбарлаваас: Шинжлэх ухаан нь хөгжин төгөлдөржих тусмаа улам бүр математикжиж, тоон загвар, тоон тэгшитгэлээр өөрийгөө илэрхийлдэг болно.

Шинжлэх ухаан нь математикийг хэрэглэдэг болсон тэр үедээ л сая төгс боловсронгуй болно гэдгийн учир энэ. Энэхүү математик хэмээх хэл нь өөрийн гэсэн бичиг үсэгтэй байж таарна, тэр нь тоон-загвар, тоон тэгшитгэл ажгуу. Эндээс математик бол шинжлэх ухааны хэл нь юм гэсэн үндэслэл гардаг байна. Дээр нэр дурдсан Эйнштейний зохиосон алдарт тензор тэгшитгэл нь тоон загвар мөн. Ер нь орчин үеийн онолын физик нь тэр чигээрээ тоон загвар болсон байна.

Эдүгээ шинжлэх ухаанууд гойд ихээр математикжиж, судлаачид нь тоон загвараар л үр дүнгээ илэрхийлж хоорондоо ярилцдаг болов, ингэж л шинжлэх ухаан хөгжинө, ингэж л судлаач эрдэмтэд ялгарна. Эрдэмтэн таны ажилладаг салбар математикийг ямархуу төвшинд хэрэглэдэг бол ? багавтар хэрэглэдэг үү, тэгвэл энэ салбар чинь хөгжлийнхөө хүүхэд насандаа байна, дөнгөж л хэлд орох төдий шулганаж байна гэсэн үг.

Математик загвар хэмээх энэхүү шинжлэх ухааны хэл бичиг нь өмнө дурдсан уламжлалт хэл бичгээс олон талаар давуу юм, хамгийн наад зах нь гэхэд л, чиний математик, миний математик гэж өмчлөхгүй, энэ нь сайн тэр нь муу гэхгүй, нэгээс нөгөөрүү нь хөрвүүлнэ гэж цаг мөнгө үрэхгүй, олон хүнийг орчуулагч-хэл бичиг судлаач болгож ядраан зовоохгүй, хэлний толь бичиг зохиох, хэрэглэх гэж ажил удахгүй, бас миний бичиг нь босоо, чинийх бол хэвтээ, минийх толгойноосоо эхэлдэг, чинийх бөгснөөсөө эхэлдэг гэхчлэн хэрэлдэж муудалцахгүй... амар юм.

Уйгуржин,Кирилл, Латин цагаан толгойг хоёрхон сарын дотор сурч болно, харин математик загвар зохиодог, хэрэглэдэг болно гэвэл 20-иод жил шаардагдана, хэцүү эд л дээ, ийм хэцүү болохоор нь манай нийгэм-хүмүүнлэгийн ухааныхан халшраад байгаа юм, бичиг үсгийг нь сурахгүй болохоор удаан настай бүтээл хийнэ гэж юу байхав, монголын нийгэм хүмүүнлэгийн ухаан нялх балчир байгаа гэж бичиг үсэгт тайлагдах ажлаас биеэ чөлөөлөх нь буруу, оролдох хэрэгтэй, айж эмээх хэрэггүй, ингэхэд ер нь манайхан шинжлэх ухаан л монголыг аварна, шинжлэх ухааныг л ихэд хөгжүүлье гэж олонтаа ярих атлаа шинжлэх ухааныхаа бичиг үсэгт тайлагдая гэж бараг үл дуугарна, бичиг үсэггүй хэлгүй,... байж хэн дуртай нь...аварна, аварна гэж хашгирснаар аврагдахгүй,... хөгжүүлье, хөгжүүлье гэж уриалснаар хөгжихгүй нь ээ,... ядаж л шинжлэх ухааныхаа хэл-бичиг үсгийг нь сурахгүй юмаа гэхэд гадарладаг болчихвол нэг алхаж буй нь тэр.

Математикаар шинжлэх ухааны цөөн хэдэн хүн л өөр хоорондоо ярилцдаг гэвэл хараахан тийм биш. Математик нь хүний оюун ухааныг хөгжүүлдэг төдийгүй сэтгэлгээг нь эрэмбэлэн цэгцэлдэг шалгарсан хэрэгсэл юм, ийм учраас монголдоо хамгийн олон уншигчтай Математик сонин "Цэгцтэй сэтгэх нь математикт суралцахаас эхэлнэ" гэсэн уриатай ажээ.

ГУРАВ. ОДОО ХҮН ТӨРӨЛХТӨНИЙ ОЛСОН ГУРАВДАХЬ БИЧИГ ҮСЭГ БОЛОХ “ОЮУНЫ ЗУРАГЛАЛ”-ЫН ТУХАЙ ӨГҮҮЛЬЕ.

Эхлээд ОЮУНЫ ЗУРАГЛАЛ хэмээх бичиг үсэг монгол хүнд хэр ойр байсан, ер нь бид энэ бичиг үсгийг огт мэдэлгүй өдий хүрэв үү гэсэн асуултаас эхэлье. Монголчууд бидний хувьд энэ бичиг үсэг нь цоо шинэ зүйл хараахан биш гэж болно. Баруун монголын алдарт туульч Парчин 6000 мөр шүлгийг логикийн ямар ч алдаагүй шүлэглэн хайлдаг байж, манай нутагт уйгуржин ч үгүй, кирилл ч үгүй атлаа 1000 мөр шүлгийг урсган уншдаг хүмүүс хэд хэд байсан, тэд ерөөхдөө дадмаг нь яана, хүүхдийг харж байгаад л ерөөлөө урсгачихна, цэцэн цэлмэг нь жигтэйхэн, одоо ч удам судар нь тасраагүй байгаа, миний аав сургуульд сураагүй хүн л дээ, өөрөө л уйгуржин сурсан гэсэн, тэрээр “ одоогийн та нарын толгой тархи чинь яачихсан юм, дүйнгэ болчихсон юм шиг, яриа хөөрөө чинь дотроо авцалдаа муутай гэдэг нь, бодоод л хэлчих хэдэн үгний төлөө юунд тэгтлээ цаас шагайна вэ, тэр хэдэн өгүүлбэрийг чинь хүн л бичсэн байж чадна, заавал тэр хүнийг дагаж, өөрөө өөрийнхөө оюун бодлыг баглан хүлж байх хэрэг юун” гэдэгсэн. Аав маань бичиг үсэг харж үг хэлдэг даргыг их л голдог байж билээ.

Монголчуудыг “...олон зуун жилийнхээ түүх соёлыг бичиг үсэггүй байсныхаа балгаар гээн хаясан, аман зохиолын төдий уламжлалтай, ихэд хоцрогдсон ард түмэн” гэж европчууд хэлдэг. Европчуудын тархины хэмжээ биднийхээс даруй 52 граммаар хөнгөн, ингэхлээр жижигдүү байгаа нь юуных бол, тэд чээжлэн тогтоох, холбон сэтгэх ажлаас өөрийгөө холтгон, түүнийгээ цаасанд даатгасан, харин бидний өвөг дээдэс толгойдоо даатгасан, тэгэхлээр байнга дасгал хийж, үр ачдаа ухаан бодлоороо дамжуулах гэж ажилласан толгой тархи том байлгүй яахав, атираа нугачаа олонтой, санах ой нь багтаамж сайтай байж таарна,...бидний муу гэж ад үздэг аман зохиол маань ийм л хэрэгтэй зүйл байжухуй, бидний өвөг дээдэс тийм ч унхиагүй муу хүмүүс байгаагүй бололтой.

Одоо монгол хүн, тухайлбал Парчин гуай тэр их мэдээллийг тархи толгойдоо яаж хадгалдаг байсан бол, гэдэг асуултанд хариулах гэж оролдоё. Хэрвээ туульч Парчин уламжлалт бичиг үсэгт тайлагдсан болж гэм, одоогийн бидэн шиг 20 мөр чээжлэхээс хэтрэхгүй байсан нь тодорхой. 20 мөр шүлгийг дөнгөн данган чээжилдэг /уламжлалт бичиг үсэгт дулдуйддаг/ аргачлалаар яагаад ч 6000 мөрийг давахгүй, энд өөр аргачлал хэрэгтэй болно.

Парчин вээр тархиндаа л найддаг байж, том тууль гэдэг нэг ёсны том уул юм, том уулыг гуу жалганаас нь, дотроос нь тодорхойлон магтана гэвэл яагаад ч бүтэхгүй, болох ч үгүй, гуу жалгын ёроолд буй хүнд уул бүтнээрээ харагдахгүй, харин тэр уулыг алсаас харах хэрэгтэй, тэгвэл уулын ерөнхий хэлбэр, тогтоц, байрлал, гуу жалгынх нь бүтэц, гол горхиных нь урсгалын зүг чиг харагдана, хаанаа модтой, оройдоо юутай, ан амьтан, хүн зон хаагуур нь яасхийж нутагладаг гэх мэт нь нүднээ тодрон үзэгдэнэ. Би энд алсаас харна гэдгийг тэртээд буй өөр уулын орой дээрээс нөгөө уулыг нь харж, дурандахыг хэлээгүй байна, толгойн дотроо уулыг багтаах буюу сэтгэн бодохыг хэлж байна.

Ер нь ямарваа юмс, үзэгдлийн хөгжлийн учир утга, зүй тогтлыг нь олохын тулд тэр юмс үзэгдлийг дотроос нь нягтлахын сацуу гаднаас нь оюун ухаанаараа дүгнэж цэгнэвэл илүү гүнд нь орж болно. Сэтгэгчид бодож бясалгасаар л байгаад хайж буй зүйлийнхээ угт нь хүрдэг, яг хүрээд очихоор тийм ч хэцүү юм байгаагүй нь илэрдэг аж. Парчин туульч эхлээд хайлах туулийнхаа гол араг ясыг тоймолчихно, дараа нь хэсгүүдээ хэрхэн зангидах оньс уяагаа бэлтгэчихнэ, ингэсэн байхад шүлэглэн урсгаад л байна, логикийн алдаа гарахгүй, уяагаа уртасгаад, шинэ зангилаа үүсгээд л яваад байна, 6000 шад шүлэг бол тархины хувьд ёстой өчүүхэн зүйл л дээ, тархи гэдэг тийм агуу бөлгөө. Энд гагцхүү Парчингийн босгосон араг яс тархины өөрийнх нь салбайж цацарсан сүлжээн бүтэцтэй тохирч байх ёстой. Тархины салбайж цацарсан сүлжээг хооронд нь холбохын тулд элдвийн уяа хүлээснээс нь салгах учиртай, өөрөөр хэлбэл, сэтгэлгээгээ чөлөөлөх ёстой, ингэвээс онгод орж сэтгэлгээний агуу гайхам чадал өөрт мэдрэгдэнэ, оюун тархийг ийм төлөвт оруулах өвөрмөц аргууд бий, тухайлбал тархийг гаднаас нь содон сайхан онч дохиогоор эвтэйхэн "доргиовол" сэтгэлгээ нь өөрөө аяндаа цацран гийдэг байна, ийм аргыг Парчин хэрэглэдэг байж, хөг нь орсон товшуурыг гартаа авч хэд гурав дуугаргаж," Алаг морины хялгас билээ. Арван хурууны эрдэм билээ. Товшуур минь дуутай шүү, бие минь цуутай шүү" хэмээн аялгуулан эхлэхэд тархи аажмаар хар аяндаа ажилдаа орно, уран үгс урсан ирнэ, бие сулран тавирна, ингэж бие-оюун-хэл гурав нэгдэн нийлнэ, товшуурын ая дор Бум-Эрдэнийг ёстой хайлсан шиг хайлна шүү дээ, энэхүү үйл явцад тууль сонсогчид бас нэгдэнэ, бүх хүний санаа сэтгэл туульдаа шингэнэ,... жинхэнэ амьд урлаг гэдэг энэ байх.

Өндөр гэгээн Занабазар муугүй визуаль /орон зай цаг хугацаанд нь харж сэтгэх/ сэтгэж чаддаг байсан нь түүний уран бүтээлүүдээс тод харагддаг юм. Тэрээр тухайн үеийнхээ монгол, төвд, самгард хэлээр зэрэг бичиж болох бичгийг олох гэсэн оролдлогоороо нэгэн төрөл бичиг үсэг зохиож, түүнийгээ соёмбо хэмээн нэрийджээ. Монгол улсын төрийн далбаанд байрладаг энэхүү соёмбо нь самгардаар, "өөрөө буй болсон гэгээн гэсэн утгатай гэнээ. Магадгүй, Занабазар вээр олон хэлээр нэгэн зэрэг бичдэг бичиг үсэг л хамгаас чухал болно гэдгийг зөнгөөрөө мэдэрсэн ч байж мэднэ, тэрээр өөрөө визуаль сэтгэдэг хүн болохоороо өөрийнхөө тэрхүү орон зай өнгө будгийн сэтгэлгээг бичиг үсэгт ядаж л эвтэйхэн харагдах зураг байдлаар оруулахсан гэж бодсон байх, тэгээд өөрийн эрхгүй уран зургийн хольцтой соёмбо бичиг рүү хазайсан хэрэг.

Мэдээж, цаг үедээ уусаж, орон ахуйд баригдаж, шашин суртлын нөлөөнд орсон биз, энэхүү соёмбо бичгийг өнөөдөр хэрэглэхгүй байгаа нь чухал бус, хамгийн чухал нь өнгө-будаг, дүрс-хэлбэр, орон-зайн сэтгэлгээг бичиг үсгээр илэрхийлэх гэж оролдсонд л Занабазарын оюун сэтгэлгээний чадал оршиж байгаа юм. Хэл ба сэтгэлгээний хооронд онцгой эерэг холбоос бий, харин сэтгэлгээ ба бичиг үсгийн хооронд яг тийм эерэг холбоос бий гэхэд хэцүү, ямартай ч уламжлалт бичиг үсэг буй болсноор хүний сэтгэх чадвар хөгжсөн ч,...бас хумигдсан ч...

.Сул сэтгэлгээг бичиг үсэг дээш

татна, үүнийг "уншихаа боливол сэтгэхээ болино" хэмээн товч илэрхийлж болно, гэтэл хүчтэй-чадалтай сэтгэлгээг бичиг үсэг хазаарлан дөнгөлнө, уншаад л, бичээд л байхаар аяндаа сэтгэлгээ нь төлөвшөөд, оюун нь хөгжөөд, шинэ соргог зүйлсийг ундруулаад байна гэвэл хараахан тийм биш юм. Уншсаар л, бичсээр л байгаа, олон ном үйлдвэрлэсэн, одоо тэгээд эцэст нь харахад сэтгэлгээ нь зогсонги болсон хүмүүс бидний дунд цөөн бус бий, тэд оюун бодлоо бичиг үсгийн илэрхийлж чадах тэр зааг хэмжээгээр хязгаарлан боомилсон ажгуу. Хүний сэтгэлгээг хязгаарлагдмал тооны элдэв үсэг, дүрс, тэдгээрийн комбинацийн тусламжтайгаар бүрэн илэрхийлж яав ч чадахгүй нь ээ.

Сэтгэлгээний дөрвөн том төрөл-ай бий, үүнд: Визуаль сэтгэлгээ, хамгийн том нь бөгөөд сэтгэлгээний нийт дүнд 40%-ийг эзэлнэ гэнэ, дараа нь Латерал, эзлэх хэмжээ нь 30%, гуравт нь Каузал, эзлэх хэмжээ нь 20%, эцэст нь хамгийн бага нь болох Вертикал сэтгэлгээ, тэрээр үлдэх 10%-ийг өөрт хамаатуулж чадна гэнэ. Визуаль, Латерал, Каузал сэтгэлгээг уламжлалт бичиг үсгээр илэрхийлэхэд ихээхэн хүндрэл учирна,... яагаад ч барахгүй,... гэтэл сэтгэлгээний энэ гурван төрөл нь нийлбэр дүнгээрээ 90 хувь болж байгааг та анзаарав уу?. Тэгэхлээр хүний сэтгэлгээний 90%-ийг илэрхийлж чадах шинэ бичиг үсэг хэрэгтэй болох нь ээ дээ, янз нь... Эндээс дүгнэвэл, уламжлалт бичиг үсгээр хүн таны сэтгэлгээний аравны нэгийг л тоймлон харуулж дөнгөнө, үлдэх аравны ес буюу ерэн хувийг нь дөнгөхгүй.

Мэргэд шинжлэх ухааны цоо шинэ нээлт, ололтоо голдуу өөрийн дотоод зөн билгэд дулдуйдан хийсэн байдаг. Хүний зөн билгийг хөгжүүлдэг тийм бичиг үсэг олохсон гэж тэд оролдсоор байж, тэрч бүү хэл, Леонардо да Винчи мэтийн суутнууд өөрийн гэсэн бичиг үсэгтэй байж, тэр нь одоо бидний нүдээр харахад нэг бодлын сараалж тор ч юм шиг, нөгөө бодлын тоглоод ч юмуу эсвэл ухаангүй үедээ хамаа намаагүй сараачсан зураг ч юм шиг, өнгө будаг холилдсон, тийм нэг хачиндуу цацарсан арзгар эрээн юм байх аж. Ёстой л, мэддэггүй бидэнд эрээн цоохор, мэддэг өөрт ньмэргэн цоохор гэгч болой.

Энэхүү хачин бичиг үсэг нь тэр хүний зөн билгийг дотроос нь өдөөдөг байсан бололтой. Уламжлалт бичиг үсэг гарснаас хойш л хүний зөн билиг унтрах тийшээ хандсан байх гэж надад хааяа бодогдох юм, танд тэгж бодогдохгүй байна уу гэж Ц.Дэмбэрэл доктор асуужээ. Хүүхэд сургуульд орох нас нь болоогүй, бага балчир байхдаа элдвийн зүйл зохион ярьдаг, тэдний зарим нь сүрхий зөв логиктой байдаг, харин сургуульд ороод хэд гурван үсэгтэй, уншдаг болоод ирэхээрээ тэгж хамаагүй зохиохоо болиод, сурах бичгэндээ баригдаад, бусдын зохиогоод, олны танил болчихсон шүлэг, оньсого, өгүүлэл, туужийг яг тэр хэвээр нь хуулан уншаад эхэлдэг, ингээд л оюун ухааны урхинд ордог, ийм хүүхдийг багш нь магтаад л онц дүн тавиад эхэлнэ, онц сурсаар байгаад оюун ухаанаа дөнгөлөн чөдөрлөсөн хүн мөн ч олондоо,...онц авсных нь тоогоор шинэ зүйл санаачлах нь буурдаг ч юм билүү хэн мэдлээ.

Мандиханы Парчин 10 нас хүрээгүй байхдаа 2000 шахам хос шүлэгтэй Эргэл Түргэл туулийг сурсан байна, ийм чадавхи оюуны хомсдолгүй ямар ч хүүхдэд бүрэн байх боломжтой, гагцхүү

түүнийг нь хөгжүүлэх л хэрэгтэй. Нэг туулийг манай туульчид гол араг ясыг нь алдагдуулахгүйгээр өөр өөрсдийн арга барилаар, ялгаа агуулга бүхий үйл явдлаар дүрслэн харуулдаг байж, энэ чинь маш чухал, хүний оюуныг яг ингэ, яг тэг гэж гаднаас нь зарлигдан хүчин дэх нь гэмт хэрэг мөн, харин түүний оронд чиг зүгийг нь ерөнхийд нь хэлж өгөөд, өөрөөр хэлбэл чиглүүлээд орхичихвол хүүхэд өөрөө л сэтгээд-хөгжөөд-яваад байна, хөлд, хэлд орж буй ач зээ нараа ахмадууд бид нар "чи буруу явж байна, ингэж яв, чи буруу хэлж байна, ингэж зөв хэл" гээд гаднаас нь яг таг зааж зурдаггүй биз дээ, тэгсэн атлаа яахаараа сургуульд ормогц нь хажуугаас нь зааж заавардан оюун сэтгэлгээг нь хүлэн боож байгаа юм бэ?, энэ асуултыг хүн бүр бодвол зохилтой.

Уламжлалт бичиг үсгээр ирийтэл нь эгнүүлэн бичсэн мэдээллийг хүлээн авч буй үед хүний тархины зөвхөн зүүн хагас нь ажилладаг болохыг тархи судлаачид тогтоосон байна. Тийм замаар тархинд орсон мэдээлэл хүний ой тойнд тэр бүр хоногшин тогтох нь муу, алдагдан мартагдах нь хурдан, ингээд хичээл давтах гэдэг ажил ундардаг байна.

Гэтэл оюуны зураглалын аргаар мэдээлэл хүлээн авах үед хүний тархины баруун, зүүн хэсэг хоёулаа зэрэг ажилладаг ажээ. Ийм аргаар тархинд орсон мэдээлэл тэр бүр түргэн мартагддаггүй, эргүүлж санахад амар байдаг нь судалгаагаар тогтоогджээ, ингэх ч ёстой, тархи бүтнээрээ ажиллаж байгаа юм чинь хадгалахад хавьгүй амар байхгүй юу. Оюуны зураглалыг хийхдээ аль болох олон өнгө будаг хэрэглэвэл илүү сайн болдог байна, өөрөөр хэлбэл харааны ойг давхар ашиглаж буй хэрэг юм. Тархинд буй бүх мэдээллийн 90%-ийг харах эрхтэн болох нүдээр авдаг бөгөөд үүний 80%-ийг нь өнгөт зүйлстэй холбоотой буюу өнгөлөг зүйлээс авсан мэдээлэл байдаг ажээ. Хүн нэг харснаа барагтай бол эндүүрдэггүй нь үүнийг нотлоно, 1000 сонссоноос 1 үз гэдэг.

Дүгнэвэл, уламжлалт бичиг үсэг нь хүний ой тогтоолтын ерөнхий механизмтэй тохирохдоо төдий л сайнгүй болох нь илэрхий байна, эндээс нэг бол уламжлалт бичиг үсгийн зэрэгцээ шинэ бичиг үсэгтэй болох, эсвэл тархиа өөрчлөх ац боломж үүснэ, бодвол та эхнийхийг нь сонгох биз дээ.

Манай ном, сурах бичиг, сонинууд нь бүгдээрээ нэгэн хэвийн, харавтар үсэг бичгээр зай завсаргүй ирийлгэн өрсөн байдаг, уншихад хэцүү,...гэтэл барууны сурах бичиг, ном товхимолыг харъя, гаднаасаа л өөр, гол санаагаа эвтэйхэн гаргачихсан, зураг дүрсээр баяжуулчихсан, өнгө будаг хосолсон, цаанаа л нэг хүний төлөө.

Орчин үед багаар ажиллах шаардлага эрс ихэслээ,...хамтран шийдвэрлэх асуудал алхам тутамд тулгарч, хүмүүс ганц нэгээрээ бус баг хамт олноороо хэлэлцэж байж л шийдвэрлэхээс өөр аргагүй байдал хааяагүй таарах болов, "ганц хүн хүн болдоггүй" гэдэг үг монголчууд бидний оройруу орж байх шиг. Барууныхан багаар асуудлыг шийдвэрлэхийн тулд think thank буюу сэтгэх хүч –оюуны дайралтын аргыг ихэд ашигладаг ба ширээ тойрч суугаад асуудлаа тал талаас нь хөндөж, шинэ санаа оноо гаргаж бодлоо уралдуулан эцсийн нэгдмэл шийдэлд хүрч чаддаг байна.

Дүгнэвэл, оюуны зураглал бол багаар ажиллахад гойд тохиромжтой бичиг үсэг мөн. Монгол улсад "бүтээлч

сэтгэлгээ" гэдэг нэр томъёо моодонд ороод байна уг нь тун чухал санаа бөгөөд сэтгэлгээгээ өөрчлөе, тэгэхдээ бүтээлчээр сэтгэдэг болцгооё гэсэн мөрөөдөл юм, энэ чиглэлээр Соросын сангийн ихээхэн хөрөнгийг зарцуулсан, их ч ажил өрнүүлсэн, гэтэл бүтээлчээр сэтгэдэг хүн нь харагдахгүйгээр үл барам харин ч цөөрөөд байх шиг санагдана, яагаад ингэдэг билээ?,... хариулт нь тодорхой байна, тэр нь бүтээлчээр сэтгэж суръя гэвэл эхлээд бүтээлч сэтгэлгээнийхээ бичиг үсэгт нь тайлагдчих ёстой агаад, тэр бичиг үсгийг оюуны зураглал гэнэ, энэ нь ном уншия, ном бичье гэвэл уламжлалт бичиг үсэгт тайлагддагтай адил болой.

Бүтээлч сэтгэлгээний бичиг үсэгт тайлагдаагүй багш мэдээж хэрэг, өөрийн сайн мэддэг уламжлалт бичиг үсгээр ажлаа явуулна, тэр бичиг үсэг нь сурагч, оюутны сэтгэн бодох чадварыг боон баглана, тэгээд их мэддэг атлаа сул сэтгэдэг мэргэжилтнүүд төлөвшин бойждог ажээ.

Ингэж бүтээлч сэтгэлгээний хомсдлын эх үүсвэр тавигддаг байна. Ерөнхий боловсролын сургуулийн болон их дээд сургуулийн багш нарын дотор хичээлээ хэдэн үсэгт тааруулан хайрцаглахгүй юмсан, конспект харж өөрийгөө хүлэхгүй байхсан, санаа бодлоо чөлөөтэй гаргаж, сурагч оюутны сэтгэлийг эзэмдэн заах гэж боддог, хэрэгжүүлэхээр оролддог багш цөөнч гэсэн бий нь бий, тэд бол шинэ бичиг үсэг хэрэгтэйг зөнгөөрөө мэдэрсэн, оюуны зураглалыг бага ч болов хэрэглэх гэж хар таамгаар чармайж, хар практикаар оролдож буй хүмүүс, гагцхүү түүнийгээ ямар хэлбэрээр яаж илэрхийлэн баримтжуулахаа мэдэхгүй байгаа юм, ийм нөхцөлд хичээлийн эмх цэгц алдагдаж "багш сайхан заадаг, даан ч үлдэц бага" гэсэн үг гардаг,ингэд тэр багш удирдлагаасаа сануулга авснаар ажил хуучин хэвдээ орж, халцарсан дугуйтай морин тэрэг майжигнан мөлхсөөр, сурагч оюутны сэтгэлгээг хайрцаглан таглаж, өөрийн хурданд тохируулан барьж зуурсаар байх бөлгөө.

Дүгнэвэл: Оюуны зураглал бол бүтээлч сэтгэлгээний бичиг үсэг юм байна.

Оюуны зураглал гэж чухам юу вэ, ямар гээчийн бичиг вэ гэдгийг хэд гурван үгээр тоймлоход амаргүй юм, товчхоноор бол, мэддэг хүндээ мэргэн цоохор, мэддэггүй хүндээ эрээн цоохор юм бий, ёстой жинхэнэ эрээнээс эрээн цоохор, учрыг нь олчихвол аргагүй л оюуны бичиг мөн. Энэхүү оюуны зураглалыг Хан-уул дээд сургуульд зайшгүй үзэх хичээлээр орсон нь оюутнуудын таашаалд нийцэж байна.

Оюуны зураглалын талаар нэрд гарсан Тони Бьюзан, Барри Бьюзан нарын хамтын бүтээл болох "Оюуны зураглал: Уураг тархины хүчин чадлыг бүрэн ашиглах цацаргах сэтгэлгээний тухай" номыг тус сургуулийн эрдэмтэн багш нар орчуулан хэвлэж гаргаад байна.

Эртний монголчуудыг, эзэн Чингисийг бичиг үсэггүй байсан гэдэг үзэл баримтлал нэлээд гарсан, үүнийг наанатай цаанатай ойлгомоор байна, ямартай ч, монголчууд оюуны бичиг үсгийг анхны хувилбараар нь ашиглаж байсан баримт элбэг бий.

ГАДААДЫН ХИЛЧДИЙН АЛБА, АМЬДРАЛ

УСАН ХИЛИЙГ НАЙДВАРТАЙ МАНАЖ ХАМГААЛАХАД ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ

магистр, бэлтгэл хурандаа Х.Гөлгөө

Улсын хил хамгаалалтын орчин үеийн төрөл бүрийн техник хэрэгслийн талаар хилчиддээ зориулан гаргадаг цуврал буландаа энэ удаад усан хилийг манаж хамгаалахад зайлшгүй шаардлагатай зарим төрлийн техникүүдийн тухай оруулаа. Эдгээр техник хэрэгслүүд нь улсын хил хамгаалахад шинжлэх ухаан техникийн сүүлийн үеийн ололтыг өргөнөөр нэвтрүүлэхээр зорьж байгаа ХХБ-ын ойрын болон хэтийн бодлоготой нийцэж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Түүнчлэн ХХБ-д ажиллагсдын дундаас шинээр бүтээх, шинэ санаа шинэлэг зүйлийг хийж бүтээхэд тус дэм болгох зорилгоор зарим төрлийн техникийн талаар сонгон авч орчуулан өөрийн бодол санааг тусгаж оруулсан болно.

Агаарын чарга



Агаарын чарга нь хамгийн сүүлийн үеийн технологийг ашиглан бүтээсэн тээврийн хэрэгсэл бөгөөд олон талт ажиллагаагаараа зөвхөн агаарын дэр бүхий хэрэгслүүдтэй өрсөлдөх чадвартай юм. Агаарын чаргын үүсэл нь 1904 оноос гаралтай бөгөөд Оросын авъяаслаг инженер зохион бүтээгч Сергей Сергеевич Неждановский анх удаа дотоод шаталтат хөдөлгүүрийг агаарын сэнсний хамтаар чарган дээр суурилуулжээ. Иймэрхүү төрлийн машинууд Герман, Австри болон бусад орнуудад ч бүтээгдэж байсан төдийгүй дэлхийн 1 дүгээр дайны үеэр дайтагч талууд маш идэвхтэй ашиглаж байжээ. Орчин цагийн агаарын чарга, агаарын гулсуурууд нь газар орон дээр явахгүй газар гэж үгүй бөгөөд өвөл, зун, ус намаг, цас, мөс, өгсүүр уруу, өвс ургамалтай ямар ч нөхцөлд найдвартай туулах чадвартай бүтээгдсэн байдгаараа илүү сонирхолтой техникийн нэг төрөл юм. Агаарын чарга нь маш их хөдөлгөөнлөг шинжтэй төдийгүй гулсалтын горимд хялбарханаар шилждэг. Удирдлагыг босоо удирдлагын жолоог ашиглан агаарын урсгалыг хэрэгцээтэй чиглэлдээ өөрчлөх замаар хөдөлгөөн үйлдэнэ.

Агаарын чарганы тактик техникийн зарим үзүүлэлтүүд.

Нэр	Хүчин чадал, м.х.	Оврын хэмжээ, мм	Дээд хурд Усан дээр/цасан дээр, км/цаг
Аэробот «Тайфун»	265	6500/2250/2600	65/75 аас дээш 100
Аэроглиссер «Кейс-600» агаарын гулсуур	65	4400/1500/1900	80/120
Аэроглиссер «Экстрим» агаарын гулсуур	100	6300/2800/3200	40-50/90-100
Аэроглиссер «Т-501» агаарын гулсуур	170	5500/2000/2600	50/100
Аэросани "Патруль" агаарын чарга	100-160	5300/2000/2500	50/130
Аэросани "Амфибия АС-2" агаарын чарга	150	5800/2000/2350	50/90

http://www.katera, http://www.aif.ru/auto/article/17151

Өнөөдөр Орос орны алслагдсан хүрэхэд хүндрэлтэй газруудад ашиглагдаж байгаа дугуйт болон гинжит тээвэрлэгчүүд нь бүгд нэг л нийтлэг дутагдалтай байдаг бөгөөд тухайлбал шатахуун зарцуулалт ихтэй, жолоочийн болон зорчигдын тав тохи муутай, намгархаг болон цасан талбайд туулах чадвар султай, газрын хөрс ургамлын бүрхэвчид сөрөг нөлөөтэй байдаг гэжээ. Гэсэн хэдий ч олон улс оронд ийм төрлийн техникүүдийг өргөнөөр үйлдвэрлэн өдөр тутмын амьдрал үйл ажиллагаандаа ашигласнаар эдийн засгийн хэмнэлттэй байх, газар орны саад бэрхшээлтэй хэсгүүдийг туулах, тээврийн зарим бэрхшээлийг даван туулахад зохих үр дүнд хүрч чадаж байна.



ОХУ-д уламжлалт техникүүдийн өрсөлдөгчөөр 1996 онд Трэкол пүүсийн бүтээгдэхүүн болох 4-6 хөтлөгч дугуйтай, бүрэн дамжуулагатай, газрын хөрсөн дээр үзүүлэх хэт бага даралтын дугуйтай газар сайгүй явагч шалгарч бөөнөөр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн шат дамжлагад шилжих болжээ. Энэхүү газар сайгүй явагч машины техникийн үндсэн шийдлийн нэг онцлог нь жирийн резин дугуйнаас нимгэн ханатай боловч маш уян зөөлөн, дугуйн дотоод даралт багатай дугуйг ашигласанд оршино. Дугуйн дотоод даралт буюу хийн даралт нь 0,08 атм байхад газар сайгүй явагчаас хөрсөн дээр үзүүлэх даралт нь маш бага буюу дөнгөж 0,1 кг/см^2 байна.

Дугуйн даралтын ийм онцлогоос хамаарч Трэкол газар сайгүй явагч нь ямар ч гүнтэй намаг, цас, элсийг саадгүй туулахын хамтаар өргөн биш усан саадыг ч хөвөлтөөр туулах бололцоотой болжээ. Хөрс султай газар орон дээгүүр өнгөрөх


үедээ газрын гадаргуу дээр маш өчүүхэн төдий цариг мөрийг үлдээдэг учраас шатахуунд хэмнэлттэй, хөрс ургамлын бүрхэвчийг гэмтээдэггүй онцлогтой. Газар сайгүй явагчийн хөвөх чадвар нь эргэлдэж байгаа дугуйн усан багтаамж буюу өөрөөр хэлбэл ус самрах маягийг ашиглан 10 км/цаг хүртэл хурдлах боломжтойгоор бүтээжээ. Газрын хөрсөн дээр үзүүлэх даралт нь туйлын бага байдгийг батлах жишээ бол өвсөн дээр хэвтэж байгаа хүний дээгүүр Треколыг гаргахад ямарч гэмтэл учруулахгүй гээд бодоход хангалттай юм. Газар сайгүй явагч ТРЕКОЛ нь 17 төрлийн патентээр эрх нь хамгаалагдсан бөгөөд ОХУ болон хилийн чанадад түүнтэй зэрэгцэх төстэй зүйл одоохондоо байхгүй. Трекол пүүсийн зүгээс нийтдээ 7 төрлийн сайжруулсан загварыг үйлдвэрлэдэг бөгөөд тэдгээрээс 4 загвар нь 6 хөтлөгч дугуйтайгаар гардаг байна. Үүнд:

- ТРЭКОЛ-39294 маягийн (Жолоочийн хамтаар 8 хүний багтаамжтай) шил хуванцарын холимог бүхий сендвичин бүхээгтэй зорчигч тээвэрлэлтийн;
- ТРЭКОЛ-39295 маягийн (Жолоочийн хамтаар 4 хүн багтаамжтай, нэмэлтээр 400 кг ачаа тээвэрлэх боломжтой/, шил хуванцарын холимог бүхий сендвичин бүхээгтэй зорчигч тээвэрлэлтийн
- Дунд зэргийн хөдөлгүүртэй ТРЭКОЛ-39292 маягийн /жолоочийн хамтаар 8 хүний багтаамжтай/ хөнгөн цагаан хайлш бүхий бүхээгтэй зорчигч тээврэлэлтийн
- УАЗ ТРЭКОЛ-39293 маягийн ачаа тээвэрлэлтийн зориулалттай 2 хүний багтаамжтай, 550 кг ачаа зөөх боломжтой загваруудыг үйлдвэрлэдэг байна.

Түүний зэрэгцээ 4 дугуйтай хувилбараар 5-6 зорчигч тээвэрийн зориулалттайгаар, 50-60 кг ачааг тээвэрлэх боломжтой ТРЭКОЛ-39445, УАЗ-31512, УАЗ-31514/төмөр бүхээгтэй/, ТРЭКОЛ-39041 маягийн газар сайгүй явагч техникүүдийг бүтээж үйлдвэрлэдэг байна.







Трэкол пүүсийн газар сайгүй явагчууд дээр цахилгаан лебедк, дулаацуулах төхөөрөмжүүд, урьдчлан асаалтын халуун тогоо зэрэг олон нэмэлт төхөөрөмжүүдийг захиалагчийн хүсэлтээр нэмж байрлуулж өгдөг. Трэкол газар сайгүй явагчийн нийт эд ангийн 70 орчим хувь нь Оросын ГАЗ, УАЗ, ВАЗ загваруудын үйлдвэрийн хийцүүд бөгөөд 1996 оноос хойш 1300

гаруй газар сайгүй явагчийг үйлдвэрлэж Краснодараас Чукоткийн хязгаар, Хойт туйлаас-Казакстан хүртэл өргөн уудам нутаг дэвсгэрт амжилттай ашиглагдаж байна. Трэколын баталгаат хугацаа 6 сар буюу 5000 км. Газар сайгүй явагчийг жолоодохын тулд В ангилалын жолооны эрхтэй байх ба нийтийн зориулалттай замыг ашиглана. Дэлгэрэнгүй мэдээллийг www.trecol.ru сайтаас авч үз.


Агаарын чарга "Патруль"

Зориулалт нь: Энэхүү агаарын гулсуур чарга нь замгүй газраар хөдөлгөөн үйлдэх, цас, мөс, усан дээр зорчигч, ачаа тээшийг тээвэрлэхэд зориулагджээ.

Энэ техникийг онцгой байдлын алба, улсын хилийн хамгаалалт, аврах алба, усан дээрх ангуучлал, хувь хүмүүсийн хэрэгцээд зориулан бүтээсэн байна.

Хийцийн зарим онцлог:

Чарганы зорчигчдын бүхээгийн хагардаггүй шилэн бүхээг аэродинамикийн болон бусад бүх ачааллыг хүлээн авч гадаргуугийн байдалд зохицуулан өөрчлөгдөх зориулалт бүхий зөөлөвчүүд дээр бэхлэгдсэн хөвөгч техник юм. Энэхүү зөөллөгч дэрнүүд нь 10 ширхэг хийлсэн баллон сав бөгөөд эдгээр савыг ПВХ маягийн материалаар хийж чаргазавины ёроолыг хуванцраар бэхжүүлсэн ба газрын гадаргуугаас ирэх аливаа цохилтын хүчийг сулруулах, тоотын бүрэлдэхүүнд учрах аливаа таагүй байдал болон бие ангийг эвдэрч гэмтэхээс хамгаалах үүрэгтэй.





Техникийн үндсэн үзүүлэлтүүд:

Оврын хэмжээ: уртаараа, м	5,3/6
Өргөнөөрөө , м	2
Өндрөөрөө , м	2,4
Зорчигчдын тоо. хүнээр	5-7
Тээвэрлэх ачааны жин, кг	450-550
Чарганы нийт жин кг	420/490
Усан дээр явах хурд , км/цаг	55
Цас, мөсөн дээр явах хурд , км/цаг	130 хүртэл
Туулах хамгийн өндөр,	30 градус
Шатиахууны савны багтаамж, л	70
Шатахуун зарцуулалт, л/цаг	15-20
Шатахууны төрөл	Бензин АИ-92, АИ-95
Хөдөлгүүрийн чадал (Subaru Ez-30, Subaru Ej-25), м.х	210/160

Орчуулагч судлаачийн дүгнэлт: Ийм төрлийн тээврийн хэрэгслүүд нь ***хойт*** *хил болон намаг шавар шалбааг ихтэй усан саадтай бусад газруудад* ***өргөнөөр*** *ашиглаж хилийн албаны үйл ажиллагаанд бүрэн тохирох тээврийн* ***хэрэгслүүд*** *юм. Холбогдох албад, мэргэжилтнүүд өөрийн улсын хил хамгаалалтын* ***нэн чухал*** *нэг төрлийн тээврийн хэрэгсэл болгох талаар анхаарч үзнэ гэдэгт* ***найдаж байна.*** *Түүнчлэн манай алтан гартай техникийн бүрэлдэхүүн өөрийн орны* ***нөхцөлд хийж*** *бүтээх бүрэн боломжтой юм*

УСАН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ОРЧИН ҮЕИЙН ЗАРИМ ТЕХНИКҮҮД





Аэробот маягийн гулсагч завь нь өвөл зуны улирлууд болон завсрын **улиралд** зорчигчдыг тээвэрлэх, аялал, зугаалга, ан ав зохион байгуулахад зориулагдсан бөгөөд ус, өвс ургамал, дэрс хулс, цас, шаварлаг газруудыг туулах боломжтой. Завины ёроол нь АМГ-5 маркийн 4 мм зузаантай гангаар хийж 8 мм **зузаантай** хуванцараар давхарлан бөхлөж өгсөн нь эдэлгээний хугацааг уртасгах боломжтой болж нь өвс ургамлын бүрхэвч бүхий газруудад чөлөөтэй гулсах боломжийг эрс нэмэгдүүлж өгдөг.



Давуу талууд нь:

1) Хөдөлгүүрийг нь завины ёроолд байрлуулсан нь хүндийн төвийг тогтвортой болгох нөхцөл бүрдүүлжээ.


2) Их биеийг нь сайн чанарын эдэлгээ урттай АМГ-6 маркийн гангаар хийсэн

3) Завины жин нь 550 кг-аас ихгүй болсон нь чиргүүлд ачих, усан оруулаха ажиллагааг хөнгөвчилсөн шийдэл болж чадсан.

Аэрогулсагч



Аэроглиссер өвөл зуны улирлууд болон завсрын улиралд зорчигчдыг тээвэрлэх, аялал, зугаалга, ан ав зохион байгуулахад зориулагдсан бөгөөд ус, өвс ургамал, дэрс хулс, цас, шаварлаг газруудыг туулах боломжтой. Завины ёроол нь АМГ-5 маркийн 3 мм зузаантай гангаар хийгдсэн нь өвс ургамлын бүрхэвч бүхий газруудад чөлөөтэй гулсах боломжийг өгдөг.



Давуу талууд нь:

1) Хөдөлгүүрийг нь завины ёроолд байрлуулсан нь хүндийн төвийг тогтвортой болгох нөхцөл бүрдүүлжээ.

2) Их биеийг нь сайн чанарын эдэлгээ урттай гангаар

3) Завины жин нь 500 кг-аас ихгүй болсон нь чиргүүлд ачих, усан оруулаха ажиллагааг хөнгөвчилсөн шийдэл болж чадсан

Аэрочарга- АМФИБИЯ:



Аэрочарга-амфибия –бүхий л улиралд ашиглахад зориулагдсан тээврийн хэрэгсэл бөгөөд газрын янз бүрийн гадаргуу дээр хөдөлгөөн үйлдэх боломжтой байхаар бүтээсэн. Улсын хил хамгаалалтын зориулалтаар манай орны нөхцөлд нуур, цөөрөм, цас ихээр унадаг газруудад тохиромжтой нэг төрлийн тээврийн хэрэгсэл байх боломжтой. Энэхүү агаарын чарганы хөдөлгүүрийг харьцангуй доор суулгаж өгсөн нь тогтвортой байдлыг сайн хангаж байгаагийн хамтаар агаарын сэнс нь 35 хүртэл хажуугийн эрстэй газар орон дээр нэмэлт татах хүчийг бий болгодог. Бүхээг нь -45 аас +40 хэмийн нөхцөлд тоотын бүрэлдэхүүн, зорчигчдыг хэвийн ажиллах нөхцлийг хангана. Урд суудал нь авагддаг. Хойд суудал нь эвхэгддэг

бөгөөд 1,55х2,2 м хэмжээтэй шал болж 3 хүн чөлөөтэй амрах боломжтой, Зогсож байгаа үедээ агаарын сэнсийг унтрааснаар хөдөлгүүрийн дуу чимээ эрс багасч хоорондоо чөлөөтэй ярилцах боломжийг бүрдүүлнэ.

ЭКРАНОЛЕТ:



Агаарын дэр бүхий энэхүү жижигхэн хөлөг ЭСКА-1 нь 5 жил гаруй хугацаанд туршигдсан бөгөөд барууны орнуудын Х-113 загвартай ижил төсөөтэй бүтээгдсэн. Зорчигчдыг тээвэрлэх, ачаа зөөх, усан дээр ажиллах бүрэлдэхүүний анхан шатны сургалт явуулах, ус, цас, мөсөн дээр ашиглах боломжтой. Өөрөөр хэлбэл хөлгийн нисгэгчийн шийдсэнээр хөвөх, ус, өвс ургамал бүхий хөрсөн дээр гулсах, цасан дээр гулгах зэргээр хөдөлгөөнийхөө горимыг өөрчилж болдог. Энэхүү онгоц хэлбэрийн хөлөг нь хажуугийн тогтворжуулагч бүхий хөвөгч хоёр тулгуур, босоо кильтогтворжуулагчийн хамтаар хийгдсэн нь нэг талаараа усан дээрээс хөөрч буудаг онгоцыг санагдуулна.

ЯПОНД ҮЙЛДВЭРЛЭСЭН АЭРОЧАРГА


Үнэ 1 700 000 р.

Үйлдвэрлэгч улс: Япон

2011-оноос үйлдвэрлэгдэж байгаа

Хөдөлгүүрийн багтаамж 2 000 куб. см. 4 тактийн бензин хөдөлгүүртэй

Усан хилийг манаж хамгаалах зориулалт бүхий эдгээр техник хэрэгслүүд нь манай орны нөхцөлд нэн тохиромжтой төдийгүй ашиглахад хэлбэр, газар орны янз бүрийн нөхцөлд ямар ч бэрхшээлгүйгээр хөдөлгөөн үйлдэх боломжтойн дээр жилийн аль ч улиралд ашиглахад зориулагдсан байдгаараа давуу талтай болно.



ГАДААДЫН УЛС ОРНУУДЫН ГОЛ, НУУРЫН ЭРГИЙН ХАМГААЛАЛТ

магистр, дэд хурандаа Ё.Хадхүү

Хилчний алба нь олон улс оронд байдаг бөгөөд усан хил дээр ч явагддаг. Усан хил дээр мөн л адил хилийн зөрчлүүд элбэг байхын зэрэгцээ загас агнах, байгалийн баялаг ашиглах зэрэг зөрчлүүд ихэвчлэн гардаг нь хилчид хил зөрчигчдөөс байгалийн баялгаа хамгаалах, үйл ажиллагаанд чиглэгддэг нэгэн чиг зорилготой байна.

Аль ч улс орны хилийн албаны үндсэн үүрэг нь:

- Улсын хил хамгаалалт
- Эдийн засгийн хамгаалалт / сонирхол/
- Террорист халдлагын эсрэг арга ажиллагаанд оролцох
- Эрлийн ажиллагаанд оролцох /эрэх, хайх, саатуулах, баривчлах ажиллагааг хамтатгах/
- Ард иргэдийн хөвөх хэрэгслийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа
- Эдийн засгийн болон байгаль орчны аюулгүй байдлыг хангахад оролцох зэрэг болно.

Тухайн улс орнуудын усан хил хамгаалах салбаруудын хувьд өөр өөрийн орны болон тухай хил хязгаарын онцлог, цагийн байдал, түүнд орсон өөрчлөлтөөс хамааран янз бүр байх бөгөөд тус тусдаа өөр өөр яаманд харъяалагдана.Тухайлбал:

- Америкийн усан цэрэг нь Засгийн газартаа,
- Японы усан цэрэг нь Аялал жуулчлалын яамандаа,
- Норвегийн усан цэрэг Зэвсэгт хүчиндээ тус тус харъяалагддаг.

Байгаль, цагуур, газар орны болон тухайн улс үндэсний хил хамгаалалтын онцлог хүч хэрэгслээс шалтгаалан усан хил хамгаалалтын эргийн хамгаалалт нь өөр өөр чиглэлээр явагдах юм. Жишээлбэл: Америкийн эргийн хамгаалалт нь:

- Усан хилийн,
- Хяналтын системийн,
- Зогсоолын,
- Шинжлэх ухааны чиглэлээр,

Эрэх, хайх, аврах чиглэлээр,

- Мөрдөх, аваараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гэх мэт.

Хилийн алба нь усан дээр хяналт шалгалтыг 2000 усан онгоцоор хамгаалдаг байна.

ОХУ-д голын эргийн хамгаалалтанд 13.000 хөлөг онгоц ашигладаг бөгөөд хөлөг онгоцыг байлдааны, тээврийн, зорчигч тээврийн, ачааны гэж ангилна.

ОХУ – ын усан хил хариуцдаг отряд нь 300–400 км, застав нь 15–16 километр хэсгийг тус тус хамгаалдаг.

Гол, нуурын эргийн хамгаалалтанд ашиглаж байгаа катерийг РЛС-ээр тоноглодог. РЛС нь 300-400 метрт харах ба 1500 метрийн зайд яваа явган хүнийг, 2-5 км–т яваа хөнгөн завийг тус тус илрүүлэх чадвартай байна. Мөн хөнгөн катерийг 200 м – ээс илрүүлэх боломжтой ба хүний нүдээр 500 м–т илэрнэ.

Моторгүй завь нь 1 цагт 5-8 км

Моторт завь нь 1 цагт 15-18 км замыг тус тус туулна.

Усан хил хамгаалалтанд катерийг өргөн ашигладаг бөгөөд хамгийн сайн

катер нь 1500000 рублийн үнэтэй байгаа бол сүүлийн үеийн шинэ "Айст" катер нь 500000 долларын үнэтэйбайна.

Усан хил хамгаалалтанд эргийн хил хамгаалалт нь 1. Оператив чиглэл / ХЗЯБЧ /,2. Эргийн хамгаалалтаар тус тус зохион байгуулагддаг байна.

Гол, нуурын хамгаалалтын үндсэн хүч хэрэгсэлд гадаад, дотоод хүчин зүйлс нөлөөлдөг.

Гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл:

- физик- газарзүйн,
- байгаль, цаг уур /манан, шуурга/
- усны түвшингийн байдал багтдаг.

Судалгаанаас үзэхэд ОХУ–ын Дальный Востокт 70 км хэсгийг хариуцдаг Хамык гэдэг нуурын хамгаалалтыг зохион байгуулдаг. Тэрхүү нуур нь манай улсын Буйр нууртай маш ойролцоо бөгөөд түүний хамгаалалтанд 40 тоннын даацтай хөнгөн хөлөг ашигладаг байна.

Хятадын эргийн хамгаалалтын цэрэг

Хятадын ардын чөлөөлөх армийн тэнгисийн цэргийн хүчний эргийн хамгаалалтын цэрэг нь эргийн артиллерийн хүчний үндэс суурин дээр хөгжсөн бөгөөд газар суурьтай хөлөг онгоц эсэргүүцэх хэрэгч пуужингийн цэрэг, эргийн артиллерийн цэрэг, "гадаргуу – агаар" ангилалын пуужингийн цэрэг, тэнгисийн агаарын нисэх хүчин, далайн гүнд ажиллагаа явуулахад тусламж үзүүлэх зорилготой урьдчилан анхааруулах цэргээс бүрдэнэ.

Байлдааны журам, зэвсэг техникийн хуваарилалтын хувьд хуучин ЗХУ-тай адил эргийн хамгаалалтын хүчин нь бие даасан хороо, батальонуудын зохион байгуулалттай бөгөөд тэдгээр нь тэнгисийн цэргийн боомт, баазуудад тархан байрласан байдаг.

Тэд, тэнгисийн цэргийн түргэн дайрах хөлөг онгоцны анги салбартай хаалттай байдалд хамтран ажилладаг бөгөөд эргийн хамгаалалтын анги салбарууд нь хятадын эргийг болзошгүй дайсны дайралтаас хамгаалдаг байна.

Хятадын ардын чөлөөлөх армийн тэнгисийн цэргийн хүчний эргийн артиллерийн цэрэг нь анх 1958 онд тайваний хоолойн хоёр эргийн хямралын үед, хятадын ардын чөлөөлөх армийн тэнгисийн цэргийн хүчин, хуурай замын цэргийн зүгээс Гоминданы булаан эзэлсэн Цюму, Мазу арлуудад артиллерийн хүчтэй цохилт өгсөн тэр үеэс хойш хятадын ардын чөлөөлөх армийн түүхэнд чухалд тооцогдох болсон гэж болно.

Хятадууд 1960,1970 онуудад, газарт суурьтай хөлөг онгоц эсэргүүцэх пуужин болон эргийн артиллерийн цэргийг хятадын улс төр, аж үйлдвэрийн төв Бээжин, Тиэнжинийг ЗХУ–ын болзошгүй аюул занал дайралтаас сэрэмжлэх зорилгоор хойд эргийн дагуу байрлуулсан бөгөөд 1980 – аад оны эхээр, хятадын ардын чөлөөлөх армийн тэнгисийн цэргийн хүчин, далайн боомт, хоолой, тэнгисийн цэргийн баазуудад эргийн хамгаалалтын 20 гаруй хороог байгуулжээ.

Зэвсэг техникийн шинэчлэлийн хувьд эргийн артиллерийн хүчин нь, "НУ-2" загварын пуужингуудаа шинэ үеийн, хөлөг онгоц эсэргүүцэх пуужингаар сольсон байна.

Хүйтэн дайн дуусч хятад, ЗХУ–ын харилцаа сайжирч, далайгаас ирэх гадны аюулгүй болсон нь хятадын ардын чөлөөлөх армийн тэнгисийн цэргийн хүчний цэргийн стратегид үндсэн өөрчлөлт гарч, эргийн

хамгаалалтаас далайн гүнд хориглон хамгаалалтыг идэвхитэй явуулах хэлбэрт шилжсэн. Үүнтэй холбогдож, эргийн хамгаалалтын хүчний бие бүрэлдэхүүний тоо харьцангуй багассан.

ОХУ–ын хилийн отряд, заставын гол, нуурын эргийн хил хамгаалалтын зохион байгуулалт.

ОХУ–ын хилийн заставын хариуцсан хэсэгт улсын хил хамгаалалтыг заставын дарга биечлэн зохион байгуулахын тулд:

- Цагийн байдлыг судлах
- Дүгнэлт гаргах
- Шийдвэр гаргах зэрэг ажиллагааг явуулдаг.

Цагийн байдлыг судлахдаа:

- Ахлах даргын шийдвэрийг судлах
- Өөрийн хүч хэрэгсэлийг үнэлэх
- Зэргэлдээ заставуудтайгаа харилцан ажиллагаа тодотгох
- Газар орноо судлах
- Хил зөрчигчийн гаргаж болох арга заль мэхийг тооцоолох
- Бүх төрлийн хангалт хийх боломж
- Хүч хэрэгсэлээ тараан байрлуулах, бүлэглэх аргууд зэрэг болно.

Хилийн заставын дарга нь гол, нуурын эргийн хамгаалалтыг зохион байгуулахдаа:

-эрэг дээрх мөр хянах зурвас,

-инженерийн торон хашааны байдал,

-бусад төхөөрөмжлөл,

-хэн, хаана, ямар хугацаагаар үүрэггүйцэтгэх,

-хилийн манаануудыг ямар бүрэлдэхүүнтэй томилох,

-тэдэнд ямар техник хэрэгслийг олгох зэргийг харгалзана.

Хилийн заставын дарга гол, нуурын эргийн хамгаалалтыг зохион байгуулахдаа орон нутгийн иргэдээс ажил үйлдвэрлэл явуулж буй газар орон, тэдний үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулах шаардлагатай.

Гол, нуурын хил хамгаалалтанд хилийн хөнгөн хөлгийг өргөн ашиглах бөгөөд гол нуурын хэсэгт үүрэг гүйцэтгэх хилийн хөнгөн хөлгийг томилохдоо цаг агаарын байдлыг үнэлэн, техникийн аюулгүй байдлыг заставын дарга биечлэн шалгаж, тушаал өгснөөр шуурхай жижүүрийн тасралтгүй удирдлаганд үүрэг гүйцэтгэнэ.

Хилийн хөнгөн хөлөг 2-10 хүртэл хүний даацтай, багтаамжтай боловч марк, загвараас суух хүний тоо хамаарна.

Хилийн хөнгөн хөлөг нь байнгын бэлэн байдалд байх ёстой. Нөөц хилийн хөнгөн хөлөг 1-2 цагийн дотор бэлэн байх бөгөөд холбоо, хүнс зэвсэг гэх мэт бүх юм хилийн хөнгөн хөлөг дээр байна.

Өөрсдийн ашиглаж байгаа хөнгөн хөлгийн техник үзүүлэлтүүдийг харгалзан үүрэг гүйцэтгэх хугацааг тодорхойлох хэрэгтэй.

Үүрэг гүйцэтгэх үед хилийн хөнгөн хөлөг дээр хяналт явуулах бүдүүвч, журам байна.

Үндсэн даалгавар:

1. хил зөрчигчийг эрэх, хайх,
2. гадаадын хөлгийг замчлах,
3. хэсгийн удирдлагын цаг хугацааны хаалт, /нууцлалт/
4. эрэх бүлгийн харилцан ажиллагаа,

5. агаарын хяналт хийх,

6. хөдөлгөөн үйлдэх үеийн аюулгүй ажиллагааны зааврыг хөнгөн хөлөг дээр хангах,

Хамгийн чухал гол асуудал бол аюулгүй ажиллагааг хангах зааврыг чанд мөрдөх явдал юм.

Голын түвшин их, бага байх нь ялгаатай асуудал боловч голын түвшинг байнга хянаж байхын тулд түвшин хэмжигчийг суулгах ёстой. Гол, нуурын хил хамгаалалтанд байгаль, цаг уурын байдлыг байнга хянаж ажиллах хэрэгтэй бөгөөд хөнгөн хөлгийг манантай үед ашиглаж болохгүй.

Гол, нуурын эргийн хамгаалалтанд ашиглагдаж байгаа хөнгөн хөлөгт дараах зүйлүүд нэн чухал хэрэгтэй. Үүнд:

1.зогсоол,

2. шатах тослох материал,

3. сэлбэг хэрэгсэл,

4. сэнс,

5. эрэг дээр аюулгүй ажиллагааны зааврыг хангах,

6. хилийн хөнгөн хөлөгт нөөц ус байх зэрэгболно.

Харин эрэгт байгаа хөнгөн хөлөгт доорх зүйлүүд шаардлагатай: Үүнд :

1.шатах тослох материал,

2. торхнууд /масло хийх/,

3. том хөлгийг хамгаалагч гэх мэт болно.

Ямарч хөлөгт цоожлогч буюу зангуу заавал байх ёстой бөгөөд түүний урт нь 50 метрт хүрч байх ёстой юм.

Хөлөгт техникийн үйлчилгээ 1, 2-ыг тогтмол хийж, эвдрэл гэмтлүүдийг засах арга хэмжээг тухай бүр нь зохион байгуулж, шаардлагатай бол төвлөрсөн засварын газарт явуулна.

Жижүүрийн хилийн хөнгөн хөлөг 2 минутын дотор бэлэн болсон байх шаардлагыг тавьдаг.

Хөнгөн хөлгийг хүлээн авахаас өмнө дээрх шаардлагуудыг бэлэн болгосон байх ёстой.

Гол, нуурын хэсгийн хил хамгаалалтын аргууд:

1. хөнгөн хөлөг /сэргийлэх манаа /,

2. эрэх манаа,

3. эрэл,

4. хянах манаа,

5. хүмүүс зөөвөрлөх манаа,

6. хил зөрчигчийг мөрдөх, илрүүлэн саатуулах,

7. гадаад, дотоодын хөлөг онгоцуудыг замчлах,

8. хил зөрчигчийг төөрөгдүүлэх,

9. хил хамгаалалтанд оролцох хүч хэрэгслийн холбоог бүлэглэх,

10. хянах цамхаг бусад объектуудыг барих,

11. баривчлах,

12. хөлөг дээр техникийн хяналт зохиох, инженер техникийн хэрэгсэл ашиглан эсвэл нисдэг тэрэг болон онгоц ашиглан илрүүлэх зэрэг аргуудыг хэрэглэдэг.

Дээрх хил хамгаалалтын аргуудын техник хэрэгслүүд нь нэг нь нөгөөгөө нөхөж харилцан ажиллагаатай явагдана.

Баривчлах гэдэг нь хил зөрчигчийн хөдөлгөөнийг техник хэрэгслийн хүчээр илрүүлэн саатуулахыг хэлнэ.

Алба явуулах арга нь өгөгдсөн өгөгдөхүүн, томилгоот тоот зогсоол руу холбогдож хууль эрх зүйн актыг мөрдүүлэх явдал юм. Хилийн албанд гадаад болон дотоод нөхцлөөс шалтгаалан зөвшөөрөл олгох, эсвэл дотоод нөхцөлд /зогсоолд/ техникээр хамгаалах боломж олгон ажиглалт хийнэ.

Хилийн албаны хөвөх хэрэгсэл нь замчлах, үзлэг шалгалт явуулах, хил зөрчигчийг илрүүлэх, саатуулахад зориулагдана. Хэрвээ нөгөө хөлөг нь /экипаж/ цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан холбогдохгүй байгаа нөхцөлд нууран дээр өөр газар очиж холбоо барина.

Гадаадын хөлөг онгоцыг саатуулсан тохиолдолд өөрсдийн хүмүүсийг үлдээж болохгүй, яагаад гэвэл сүүлд нь янз бүрийн асуудалд орно. Тухайлбал: эвдэрсэн, хэмхэрсэн, эд зүйл алга болсон гэх мэт маргаан үүсдэг.

Гол, нуурын эргийн хил хамгаалалтыг зохион байгуулахад хилийн заставын дарга шийдвэр гаргах ажиллагаа үе шаттайгаар явагдана. Үүнд:

Нэгдүгээр үе. Бэлтгэл хангах:

- ахлах даргаас хөнгөн хөлгийн даргад өгөх үүргийг судлах,
- гадаад цагийн байдал, түүнд орсон өөрчлөлтийг судлах,
- ахлах даргын шийдвэрийг судлах,
- өөрийн хүч хэрэгслийг үнэлэх,
- зэргэлдээ байгууллагын даалгаврыг судлах,
- харилцан ажиллагааг зохион байгуулах,

Хоёрдугаар үе. Үндсэн шийдвэр гарах:

- цагийн байдлыг дүгнэх,
- газар орныг судлах,
- эсрэг талын хүч хэрэгслийг буюу хил зөрчигчийг судлах,
- бусад нөхцлүүдийг үнэлэх зэрэг болно. Энэ бүхнээс дүгнэлт гаргана. /хэн, хэзээ, хаана... гэх мэтээр/

Гуравдугаар үе. Шийдвэрт тусгагдах зүйл:

- үндсэн хүч хэрэгсэл / хөнгөн хөлөг хаана байрлах /
- бусад чиглэл
- хангалтын асуудал
- харилцан ажиллагааны асуудал
- холбоо зохион байгуулалт
- удирдлагын асуудлууд байна.

Хөнгөн хөлгийн даргын шийдвэрийн дараалал:

1. Хоногийн төлөвлөгөө
2. Хоногийн шийдвэр
3. Өгөгдсөн цагийн байдал
4. Цаг агаарын байдал
5. Хөлгөөс хилийн хөнгөн хөлөг руу өгөх дохио /дуут ба үзэгдэх/ зэрэг болно.

ОХУ-ЫН ХИЛИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНД ХИЙГДЭЖ БУЙ ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ШИНЭЧЛЭЛ

магистр, ахмад Х.Асхар

ОХУ-ын ХАБА-ны Хилийн Алба, Дотоод хэргийн яам болон бусад тусгай хүчний байгууллагуудад хилийн боомт бүхий газруудад хяналт шалгалтын үйл ажиллагаандаа ашиглаж буй орчин үеийн техник хэрэгслийн нэг "Дозор" нэртэй тоног төхөөрөмжийн талаар орчуулан толилуулж байна.

ОХУ-ын Засгийн газрын 2010 оны 7-р сарын 30-ны өдрийн № 1285-р тогтоол, "Терроризмтэй тэмцэх тухай" 2006 оны 3-р сарын 6-ны өдөр батлагдсан Оросын Холбооны Улсын хуулийг хэрэгжүүлэх хүрээнд ОХУ-ын Хөлөг онгоц үйлдвэрлэх нэгтгэл корпорациас "РОССКАН" нэртэй төслийг хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн байна.

Уг төсөлт ажил нь рентген цацрагийн буцах ойлтын шинэлэг технологийг судлан улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, хилийн боомтуудын аюулгүй байдлыг хангах асуудлыг шийдвэрлэх явдал юм.

Энэхүү шинэлэг технологи нь улсын хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгсэлд нуугдсан хил зөрчигч, тэсэрч дэлбэрэх бодис, зэвсэг, галт хэрэглэл, хар тамхи зэргийг илрүүлэх боломжийг олгож байгаа юм.

"Дозор" нь рентген цацрагийг буцах ойлтын мэдрэмтгий байдал, /ОРРИ/ технологийг ашиглан ердийн автомашин дээр суурилагдсан хяналт, үзлэг шалгалтын төхөөрөмж юм.

Овор хэмжээ багатай, ашиглахад ердийн, хүний хяналтанд бага өртөхийн чацуу хурдан шуурхай маневр хийхэд Дозор системийг маш өндөр бүтээмжтэйгээр ашиглах боломж олгодог бөгөөд сэжигтэй тээврийн хэрэгслүүдийг богино хугацаанд шалган тэсэрч, дэлбэрэх аюултай зүйлс байгаа эсэхийг тогтоож аюулгүй байдлыг хангах боломжтой болдог байна.

Энэхүү тоног төхөөрөмжийг агаарын замын болон төмөр замын хилийн боомтуудад зайнаас үзлэг шалгалт, хяналт хийх замаар ашиглахад маш өндөр үр, ашигтай гэдгийг туршилтын хугацаанд ажиглагдсан байна. Ингээд энэхүү төхөөрөмжийг ашиглан хэрхэн хяналт шалгалт хийж буй байдлыг нь зургаар дүрслэн харуулж байна. Үүнд.

Нисэх буудлын эргэн тойронд хяналт тавих
"Дозор"-ыг нисэх буудлын эргэн тойронд хяналт тавихад ашиглана.
5 метрийн зайнаас илрүүлэн мэдээллийг хүлээн авах хүчин чадалтай.



Агаарын замын хилийн боомтын объект руу эргэн тойронд 5 метрийн зайд ямар нэг сэжиг бүхий обьект байгаа эсэхийг илрүүлнэ. (зураг № 1-ээр үзүүлэв);


Нислэгийн зурваст тусгай зөвшөөрлөөр гарсан тээврийн хэрэгсэлд шалгалт хийх
Нислэгийн зурваст гарч байгаа тээврийн хэрэгсэлд алан хядагчид болон тэсэрч дэлбэрэх бодис, тэдгээрийн төхөөрөмжийг нуусан байгаа эсэхийг тогтоохын тулд шалгалтыг хийнэ.




Агаарын замын хилийн боомтын үйлчилгээний зориулалт бүхий тээврийн хэрэгсэл /зорчигчид тээвэрлэх автобус гэх мэт/-д тэсэрч дэлбэрэх төхөөрөмжүүд суурилуулсан байгаа эсэхийг шалгах (зураг № 2-ээр үзүүлэв);

Мөн нисэх буудлын зурваст очиж байгаа тухайлбал шатахуун цэнэглэгч, хүнсний зүйл хүргэж байгаа тээврийн хэрэгслүүдэд тэсэрч дэлбэрэх бодис суурилуулсан болон хүн нуугдсан

Ачааны контейнер болон агаарын хөлгийг скайнердан шалгах



Ачааны контейнер болон агаарын хөлгийг скайнердан шалгах



№ 4,-өөр үзүүлэв.)

Тус шинэ технологиор хийгдсэн "Дозор" төхөөрөмжийг Монгол улсын автозам, төмөл зам, агаарын замын хилийн боомтуудад ашиглахад бүрэн боломжтой. Өнөөгийн Монгол улсын хилийн боомтуудын ачаалал эрс нэмэгдэж байгаа үед түргэн шуурхай найдвартай шалгах шаардлага тулгарч байна.


Ийм тохиолдолд зорчигчдын ачаа бараа тээврийн хэрэгслийг ачигдсан үеэс нь эхлэн хянаж, эрсдэлийг нь тодорхойлон, хяналт шалгалт явуулах шаардлагатай болоод байна.

байгаа эсэхийг шалган тогтоох


Агаарын хөлгийн ачааны чингэлэгт байгаа ачаануудад байгаа ачаа, бараа нь гаалийн мэдүүлэгт заасан ачаа бараатайгаа тохирч байгаа эсэхийг шалгана (зураг № 3 -аар үзүүлэв).

Агаарын хөлгийг бүхэлд нь гадна талаас скайнердан шалгах ба дотор орж тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийх шаардлагагүй, агаарын хөлгийн чингэлэг, бусад хэсэгт хориотой болон хязгаарласан ачаа бараа, хар тамхи, тэсэрч дэлбэрэх бодис, зэвсэг галт хэрэгсэл, хил зөрчигч нуугдсан тохиолдлуудыг илрүүлнэ. (зураг

Агаарын хөлгийн урд хэсгээс тэсэрч бодис илэрсэн байдлыг ердийн байдалтай нь түүнийг харьцуулсан нь



Агаарын хөлгийг бүрэн скайнердан шалгах



Агаарын хөлгийн 1,5 метр зайнаас скайнердсан байдал

Агаарын хөлгийн 3 метр зайнаас скайнердсан байдал

Олон улсын худалдааны өнөөгийн орчин ч үүнийг шаардаж байгаа бөгөөд хилийн хяналтын байгууллагууд тэр дундаа хилийн шалган нэвтрүүлэх бүтцийн хувьд цомхон, илүү шат дамжлагагүй байх нь засгийн газрын хувьд ч хэмнэлттэй гэдгийг иш үндэс болгож байна.

Ингэснээр үзлэг шалгалтанд зарцуулагдах цаг богиносч, ачаа бараа тээврийн хэрэгсэл, зорчигчид хил дээр саатахаа больж, ажил үйлчилгээ үзүүлэхийн тулд ихээхэн хэмжээний дэд бүтэц барьж байгуулах шаардлагагүй болж, импортын зардал хямдарч, хэрэглэгчийн нуруун дээр үүрүүлдэг үнийн өсөлт буурна.

ХИЛИЙН ТҮҮХ

МЯНГАН УДАА СОНСОХООР НЭГ УДАА ҮЗ

Ш.АРВАЙ- НҮБ-д зөвлөх эрхтэй мэдээлэлжүүлэлтийн Олон Улсын академийн жинхэнэ ба тэргүүлэгч гишүүн, Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, цэргийн шинжлэх ухааны доктор, профессор, дэслэгч генерал

2012.12.28. цас орж явган шуурга тавьсан энэ өдрийн өглөө есөн цагт Улаанбаатар хотоос бид нисэж дөрвөн цагийн дараа Япон улсын бороо шаагисан томоохон хот дахь Нарита нисэх буудалд газардав. Монголын иргэний агаарын тээврийн компаний Баярхүү даргатай нисэх багийн жолоодсон агаарын мөнгөн хөлөг арван мянган метрийн өндөрт, цагт 950 км-ийн хурдтай дүүлэн ниссээр сонин сэтгүүл уншин, цай ууж, хоол зооглох хооронд гурван мянган гаруй км урт замыг туулан бидэнд зорьсон хэргээ биелүүлэх сайхан бололцоо олгов.

Идэр залуу насны цог хийморь бадарч явах үед буюу эдүгээгээс тавин нэгэн жилийн тэртээд улсын хил манах дунд шатны мэргэжилтэн болохоор Москва хотод суралцаж байхдаа бид зуныхаа амралтыг Хар далайн хөвөөнд Крымээс Гагра хэмээх нэгэн газар өнгөрүүлж, далайн хөвөөнөөс гүн рүү 200 м өлхөн сэлж сурсан юм. Мөн сургалт, амралт хослуулан Герман, Латви, Литви зэрэг Атлантын далай хөвөөлсөн улсуудаар нэг бус удаа очиж явлаа. Тэгэхдээ Ази-Европ тивүүдийн улс орнуудаар зорчихдоо ямагт нар даган умар зүг чиглэн явжээ.

Өтөл насанд ургах нарыг сөрөн ертөнцийн зүүн зүг рүү жолоо залж энгүй их Номхон далайг үзэхээс өнө эртнээс "Наран улс" гэж алдаршсан Япон улсын эгэл жирийн амьдрал байдалтай хувь хүний чөлөөтэй аяллын хэлбэртэй явж танилцах сайхан боломж олдов.

Би энэ удаад ханийхаа хамт хүү, бэр, ачийнхаа урилгаар ирэв. Би олон улсад ирсэндээ тэр тусмаа энэ улсын засаг захиргааны нэгжийн 47 нэгжийн нэг болон бидний ойлгосноор тус улсын зүүн талын Номхон далай хавийн засаг захиргааны үндсэн нэгж хэмээх аймаг, Кашиба гэдэг хотод оршин амьдрах завшаан тохиосонд нэн сэтгэл хангалуун байлаа. Манайхаар хязгаарын аймаг сумтай дүйцэх нэгж бололтой юм. Эндээс далайн хормойд очьё гэвэл хурдны авто замаар 1 цаг 30 минут явахад хангалттай хүрнэ.

Миний судалгааны ажлын гол зорилго нь улсын хил ялангуяа хязгаар нутгийн хөгжлийг анхаарч, тэнд ард иргэд амар түвшин байж тэдэнд аюулгүй байдлаа хангах бололцоо олгоход л чиглэж байгаа юм. Судлаач эрдэмтэн хүний эрхэм хүслэн бол бүтээлийнхээ үр дүнг харах, амсах явдал.

Миний төрсөн эх оронд гадаад, дотоод объектив, субъетив, бодит ба бодит бус маш олон хүчин зүйлүүдийн нөлөөллөөс шалтгаалан бичсэн бүтээлийн минь үр дүн богино хугацаанд харагдахгүй байж мэднэ. Тэгэхдээ ёс журмаараа хэрэгжих цаг ирнэ гэдэгт би өчүүхэн ч эргэлздэггүй.

Хэрэв хэн нэгэн надаас магадлалын

хувьд бүтээлийн чинь хүлээгдэж байгаа үр дүн юу юм бэ ? гэж асуувал би орчин үед Япон улсын энэ хязгаар нутагт өрнөж байгаа хөгжил, хэрэгжиж байгаа хүний эрх, эрх чөлөө, хангагдаж байгаа аюулгүй байдал эдгээрийн бодит илрэлтэй үндэстэй үзүүлэлт байх болно гэж хэлмээр байна.

Тийм ч учраас би үзсэн, харсан бүхэндээ сэтгэл нэн хангалуун байна. Харин тэр бүгдийг хугацаа богино орчин харьцангуй хязгаарлагдмал, дээр нь хэлний бэрхшээлээс улбаалж бодит амьдралын объектив мэдлэгийн агуулга, цар хүрээнд нь бүрэн багтааж олон түмний сэтгэлд шингэтэл хүргэж чадахгүй болов уу гэхээс сэтгэл өвдөж яс хавталзах авч бичихээс өөр аргагүй гэсэн сэтгэгдэл намайг хөтөлсөн юм.

Японы ард түмнээс сурах юм дааНч их байна

Монгол улс, Япон улсын найрамдал хамтын ажиллагаа өргөн дэлгэр болж байгаа нь үнэхээр бахархууштай. Монгол, Японы ард түмний хооронд халуун элгэн харилцаа тогтоох оролдлого олон зуун жилийн өмнө гарч байсан баримт жишээ цөөнгүй.

Монгол, Японы орчин үеийн харилцаа тавигдах эх үндэс одоогоос 48 жилийн өмнө тавигдан хоёр ард түмний найрамдлын нийгэмлэг чухамдаа дэлхий ертөнц капиталист ба социалист гэсэн эсрэг, тэсрэг хоёр системын харилцаа хурцдаж байсан 1965 онд байгуулагджээ. Бүхнээс хүчтэй байдаг ард түмний эв санаанд нэгдэл бүхнийг ялж Монгол, Японы бүрийн тал өргөн бүх салбарт өрнөсөн шинэ эрин зуунд гар гараасаа хөтлөлцөн, хөл нийлүүлэн алхаж байгаа үед бид амьдарч байгаа юм.

1998 онд Токио хотноо гаргасан "Монгол улс, Япон улсын хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэлд"...хоёр тал Монгол, Японы харилцааг урт хугацаанд хэрэгжүүлэхийг..." чухалд үзсэн юм. Манай хоёр улс дипломат харилцаатай найрамдал хамтын ажиллагааг өргөн дээдэлдэг.

Монгол Улсыг таван мянган жилийн түүхэн өв санд түшиглэсэн төрт улсаа байгуулсныг хоёр мянга хоёр зуун хорь гаруй жилийн өмнө саяхан тэмдэглэсэн.

Азийн төв хэсэгт Умард талдаа Оросын Холбооны Улс, Өмнө хэсэгтээ Бүгд Найрамдах Хятад Улстай хаяа залган оршдог нэг хүнд оногдох газар нутгаараа дэлхийд дээгүүрт ордог. Эх газрын уур амьсгалтай, далайд гарцгүй улсуудын нэг. Улс, ард түмнийхээ үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаагаар олон улсад үлгэр дууриалал болж байгаа улсуудын нэг учраас Япон улс, Японы ард түмнээс сурах юм бидэнд их байна.

Япон улс нь өнө эртний түүхтэй, Далай тэнгисээр хүрээлэгдсэн, олон мянган арлууд, тэр дундаа Хоккайдо, Хонсю, Кэосно, Сикору гэсэн дөрвөн томоохон хэсгээс бүрдсэн 377,9 км газар нутагтай улс юм. Хүн амын 26,6-д хүрчээ. Япон улс нь Үндсэн хуульт ба хаант засаглалтай, хоёр шаттай парламент бүхий хуулийн дээд байгууллагтай, VII-VIII зуунд феодолын нийгэмд орж 1867-1868 онд хөрөнгөтний хувьсгал ялсан үеэс эдүгээ хүртэл эрчимтэй хөгжиж дэлхийн тэргүүлэх улсуудын түвшинд хүрсэн нэр нөлөөтэй улсын нэг болж байгаа юм.

Япон улсын зан заншил, соёл иргэншилд Буддо, Синто шүтлэг тэргүүлэх байр эзэлдгээс гадна Япон хэл нь Алтайн хэлний ангилалд батдгаараа бас онцлогтой. (үргэлжлэл бий)

БАЙТАГ УУЛ ОРЧМЫН ГАЗАР НУТГИЙН МАРГААН

докторант, дэд хурандаа Н.Даваадорж

Монгол улсын баруун зүгийн хил нь Ховд хязгаарын захиргаанд байсан олон ястан, үндэстэн хошуудын нутгийн хил хязгаарын үүсэлт, өөрчлөлтийн явцаас эхлэн бүрэлдэн тогтжээ. Алтай таван богд уулаас эхлэн Монгол Алтайн нуруугаар Булган, Чингэл голын хоорондуур Байтаг, Бага Хавтага, Их Хавтага уулын зүүн суга хүртэл байгаа 850-иад км хил нь 1730-аад оноос эхлэн тогтоогдож ирсэн боловч түүхийн хугацаанд янз бүрээр улиран хувьсаж өөрчлөгдөн ирсний эцэст Монгол, Хятадын 1962 оны хилийн гэрээгээр тодотгон тогтоогдож албан ёсны хил болж батлагджээ.

Хятадууд 1911 оны Монголын тусгаар тогтнолыг бүрэн зөвшөөрөхгүй байхын зэрэгцээгээр зарим хэсэг газрыг таслаж эзэмшихийг элдэв аргаар оролдож байжээ. Хятад түшмэл Шипин, Сюй Шучень, Чен И нар ийм оролдлого явуулж байжээ. Тухайлбал: Хятадын элчин Чень И Алтайн 10 хошууг Шинжаанд харъяалуулах бодлогын тухай бичсэн илтгэлдээ: "Алтайг өмнө зүг Синьцзян, баруун зүг Или, Тарвагатай амьсгал, дуу чимээгээ эртнээс авалзах болсны гавъяаг үнэлээд цааш бичихдээ ганц модыг тогтооход бэрхтэй тул тэр өнчин ганц модны үндсийг түшигтэй болгох аргыг бодох хэрэгтэй. Алтай хязгаар нь алс хол ганцаараа байна. Засгийн газар нь ташуураа урт болгох боловч хүрэхгүй ядарч байна. Иймээс Алтайг Шинжаанд нийлүүлэх хэрэгтэй. "Мянган ширхэг юмыг нэгэн ширхэг утсаар холбож буй мэт оршиж байгаа Алтайг ганцаар нь байлгаж болохгүй Чень И миний бодоход нэгэн цагт түгшүүртэй явдал тохиолдвол заавал алдахад хүрнэ. Хожимдвол хэрхэн гэмшивч тус болохгүй" гэж бичжээ.

Хятадын түшмэл Ши Пин нь 1913 оны 10-р сараас 1918 оны 12-р сар хүртэл Хуц гэдэг газраас Булган, Чингэл, Шар булаг, Хурт-Ус, Шар сүмийн зэрэг газруудаар явж орон нутгийн эдийн засгийн судалгаа явуулан энэ газруудыг харъяалах сяны захиргаа байгуулахаар төлөвлөсний дотор эндэх монгол нь тоогоор цөөн, мунхаг, бүдүүлэг, хасгууд нь хэрцгий хулгайч, ямагт хулгайлах, дээрэмдэх, алах дуртай гэж дурьджээ.

/Бүгд найрамдах монгол ард улсын газар зүйн байрлал, нутаг дэвсгэр судалгааны материал х-108. Хилийн түүхийн секторт үндсэн эх нь бий./

Ховдод сууж байсан хятад түшмэл Сюй Шучжень өөрийн саналыг гаргахдаа: Ямарч бэрхшээлийг харгалзахгүйгээр бэлтгэл хийх, газрын зураг үйлдэх, чухал газарт цэрэг оруулж хамгаалах хэрэгтэй хэмээвээс гадна Алтайн урианхай, торгууд нарын ноёд нь халхтай нэгдэхээр бичиг явуулсныг дурдан харамсаж эцэст нь бороо орохоос урьд бороноос хамгаалах хэрэгтэй гэж арга хэмжээ авахыг санал болгосон ийм бичгийг 1919 онд засгийн газартаа өргөжээ.

Хятадууд алтай хязгаарын 10 хошууны нутаг дэвсгэрийг эзлэн авахын тул 1913 оны зуны эхээр Синьцзяны зүгээс Ма дайран гэж нэрлэгдсэн хятад цэргийн даргын командалсан цэргийн отрядоор Ховдын Булганы нутагт шууд

цөмрөн орж эзэрхийлсний улмаас монголын цэргүүд тэнд хүрэлцэн очиж хятад цэргүүдийг буудаж хөөсөн бөгөөд монгол, Синьцзяны хооронд байлдааны ажиллагаа эхэлжээ.

Энэ үед орос, хятад 2 нь Бээжинд явуулсан нууц хэлэлцээрээр Алтай хязгаарыг Монголоос таслахыг харилцан зөвшөөрөлцсөн үе байсны улмаас байлдааны ажиллагаа цаашид даамжиран үргэлжилэхээс сэрэмжилж байсан оросын хаант засгийн газар нь энэ байлдааны ажиллагааг зогсоохын тулд идэвхитэй арга хэмжээ авч чадсан байдаг.

Монгол, Шинжааны хооронд үүссэн байлдааны гал зогсоох хэлэлцээг Булганы газраа яаралтайгаар эхлүүлж монголын талыг торгуудын ван Балт төлөөлж, Шинжааны талыг Шар сүмийн газар суусан оросын консуль Кузминский төлөөлөн хэлэцэж, 1913 оны 12-р сарын 8-ны өдөр протокол байгуулжээ. Тэр протоколоор Монгол, синзъяны хооронд байлдааны гал зогсоох шугамыг тогтоохдоо: монгол Алтайн нуруугаар уруудаж Алтайн нурууны Ганц модны даваанд хүрээд Булган голын гульдралаар уруудан өмнө зүг чиглэн Цагаан түнгэ, Туханцэг, Хараатын ам хүртэл шугамыг зааж 8 сарын хугацаагаар тогтоожээ.

Энэ протоколын эцэст дайны галыг зогсоох шугам нь хил биш гэж тэмдэглэсэн байдаг.

Орос, хятад 2 этгээд нь хоорондоо нуцаар тохиролцсоноо монголчуудаар хүлээн зөвшөөрүүлэхийн тулд 1914 оны 9-р сард Хиагт хотноо Монгол, Орос, Хятад 3 улсын бага хурлыг хуралдуулж орос, хятадын "илэрхийлэн гаргах бичиг"-ийг үндсэнд нь тулган хүлээлгэж 1914 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр гарын үсэг зуржээ. Энэ бага хуралд оросын талаас хүрээнд суугаа ерөнхий консул Миллер, хятадын талаас манжуурын тугийн цэргийн генерал Би Гүйфен, монголын талаас дотоод яамны сайд да лам Дашжав, сангийн яамны сайд Түшээт хан Чагдаржав нар оролцож гарын үсэг зуржээ.

Ингээд орос, хятад 2 улс нь монголын асуудлыг бүрэн шийдэж дуусгахын тулд 1915 оны дундуур монголыг оролцуулан Хиагт хотноо хуралджээ. Үүнээс гадна хаант орос нь ар монголд, япон нь Өвөр монголд нэвтрэн эзэмших тухай урьд хийсэн нууц хэлэлцээг сэргээн үргэлжлүүлэн явуулж 1912 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Петербург хотод гарын үсэг зурсан байжээ. Энэ хэлэлцээрийн ёсоор Манжуурыг хуваарилснаас гадна Ар монгол ба Өвөр монголын хилээс Бээжин хүртэл 116 градус 27 минутаар шугам татаж түүний дорнодыг япон, өрнөдийг орос нөлөөндөө оруулж ашиглахаар тохиролцсон байжээ.

Ингээд 1915 оны 5-р сард орос, хятад, монгол 3 улсын хооронд хэлэлцээ явагдаж 1915 оны 6-р сарын 7-ны өдөр Хиагт хотын гэрээ байгуулагдан гарын үсэг зуралцжээ. Монголын талаас Шүүх яамны дэд сайд жонон бэйс Ширнэндамдин толгойлж Сангийн яамны сайд Чагдаржавын хамт гарын үсэг зуржээ.

Хиагтын 3 улсын гэрээ нь орос, хятадын засгийн газруудын хооронд "илэрхийлэн гаргах" бичиг гэдгээ солилцсон нот бичгийг монголд албан ёсоор хүлээлгэж Ар монголыг хятадын харъяат өөртөө засах "автономит" эрхтэй муж болгон үлдээжээ.

Хиагтын гэрээний 11 зүйлийн ёсоор "автономит гадаад монголын газар болбоос: Дундад иргэн улсын 2-р он 11 дүгээр сарын 5, орос улсын 1913 он октябрь сарын 23-ны өдөр Дундад, орос 2 улсын солилцсон нот бичгийн 4-р зүйлийн ёсоор урьдах хүрээний сайд, Улиастайн жанжин, Ховдын сайдын захиргаанд байсан газрууд бөгөөд дундад улс лугаа нийлсэн хил болбоос зүүн зүгт Хөлөн буйр, өмнө зүгт дотоод монгол, баруун өмнө зүг шинэ хязгаар, баруун зүг алтайн хязгаар лугаа зах нийлсэн халхын 4 аймаг ба ховдын хязгаарын олон хошуудын хилээр буй амой. Дундад улс, Орос 2 улс автономит Гадаад монголын төлөөлөгчид тусгай хамт нийлэн шийтгэвээс зохих тул энэхүү гэрээг тогтоосноос хойш 2 жилийн дотор хамт нийлэн үүсгэн байцаамой" гэж заасан юм. */Бүгд найрамдах монгол ард улсын газар зүйн байрлал, нутаг дэвсгэр судалгааны материал х-127/*

Хиагтын гэрээний 11 зүйл нь Ар монголын газар нутгаас урианхайн 7 хошуу, хошоодын 1 хошуу, шинэ торгуудын 2 хошууны нутаг дэвсгэр буюу одоогийн Баян-Өлгий аймгийн бараг бүх нутаг, Ховд аймгийн нутгийн хагасыг таслан авах гэсэн хэрэг байлаа.

Хиагтын 3 улсын гэрээ нь бүгд 22 зүйлийн заалттай байсны жинхэнэ утга агуулга нь Богд хаант монгол улсыг Хятадын 1 муж болгон үлдээж, худалдаа, эдийн засгийн зарим асуудлаас бусад талаар гадаад улсуудтай харилцах эрх мэдэлгүй байлгахаас гадна орос, хятад 2 улс нь монголыг хэрхэн эзэмших эрх хэмжээгээ хоорондоо зохицуулж түүнээ монголд албан ёсоор хүлээлгэсэн зүйлүүдээр бүрдэл болжээ.

Монголчууд 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалаараа дэлхийн олон улсын тавцанд тусгаар тогтносон бүрэн эрхт Монгол улсыг байгуулж, улсын хил хязгаар, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлын төлөө дахин тэмцлийн замд орсон билээ.

Ховд хязгаарын төлөөний сайд Д.Догсом цэрэг захирах жанжин Л.Гомбо-Идшин нар Ховд хязгаарыг тохинуулах саналаа Засгийн газар цэргийн яаманд тавьж байжээ.

Л.Гомбо-Идшин 1922 оны долдугаар сарын 25-ны өдөр ерөнхий сайд бүх цэргийн тэргүүн нарт бичсэн бичигтээ: " ... Алтай Шар сүмийн талаас нэн сэжиглэлтэй байна. Шар сүмийг эс авбал Урианхайн долоон хошууг тохинуулж үл чадах бөгөөд байлдахаас өөр үгүйд нэгэнт хүрч байгаа мэт боловч одоо хэр манай цэрэг цөөхөн хүч буурай, өмнө хойт этгээдээр газар арвин, зам сүв олон, ялангуяа төр засгийн газраас тусгайлан их зааваргүй, дураараа явахад нэн бэрх хэдий ч нэг удаа үйлдэхэд хялбар боловч төгсгөхөд нэн бэрхтэй хэрэг болоод байгаа тул эрхэмлэн болгоомжилж байна. Зах хязгаарыг яахан бүрэн бүтэн болгон төвшитгөн тохинуулахыг нэгд нэгээр тодорхой сурган сийрүүлэхийг би хүлээнэ" *(БХТА ф-1 д-1 хн-28)* гэжээ.

Дэлхийн II дайны жилүүдэд хил хязгаарын дагуу нутагладаг ардууд улсын хилийн шугаманд ойртохгүй байсан бол дайны дараа улсын хилийн шугамыг мэдэх, мэдэхгүй хэн алин боловч ердийн байдлаар улсын хилийг зөрчин хоорондоо уулзах, малаа бэлчээрлүүлж нутаглах, газар нутаг булаалдаж маргах, гомдол гаргах явдал үргэлжлэн гарах болжээ. Хятадын

талаас түүхэн үнэн байдлыг гуйвуулж зохиомлоор гүтгэн газар нутгийн маргаан гаргаж, хятад хүмүүсийг хил давуулан нутаглуулж, манай талын иргэдийг хил зөрчин орж ирсэн болгож, хэл ам хийн хөөн туудаг болсон байна.

Алтайн Хуримт голын Шинэ салаа хэмээх газарт буй болор чулууны уурхайг Шинжааны иргэдэд түр зуур ашиглуулах шийдвэрийг 1944 онд тэндэх цэргийн ангиас гаргажээ. Гэтэл энэ шийдвэрийг орон нутгийн зарим иргэд эсэргүүцэн төвд мэдүүлсний улмаас 1950 оны 6 дугаар сарын эхээр тэдгээр Хятадуудыг хилчид буцаан гаргасан байна.

1950 оны 8 дугаар сарын 19-нд Өвөр Монголын цэргийн тойргийн командлагч Улаандалай гэгчээс манай Дотоод явдлын яамны сайдад мэдэгдэхдээ: "...Төвөөс мэдэгдсэн ёсоор Шинжаан мужийн Алтайн районы хилийн асуудлыг дипломат шугамаар шийдвэрлэх болно. Танай элчин сайдтай энэ асуудлаар ярилцахыг Хятадын гадаад яаманд үүрэг өгөгдлөө" гэжээ.

Мөн 1951оны 5 дугаар сарын 24-нд Хятадын цэргийн 2 дугаар армийн тусгай отрядын штаб, Шинжааны дотоодыг хамгаалах салбараас Ховд аймгийн захиргаанд ирүүлсэн бичигтээ: Энэ оны 5 сарын 17-нд Монголын цэргүүд Улаан ууланд ирж байрлав. Энэ газар бол өнгөрсөн жил нь хилийн шугам болгон түр тогтоосон газар юм. Гэтэл танай цэргүүд улсын хилээс 8 км гүн орж манай 8 хүмүүсийг баривчилсан боловч тэдний эсэргүүцлээр суллан тавьсан байна. Танай цэргүүд 1950 онд манай ардуудын үйлдвэрлэлийг үймүүлэн самуурууулсантай адил хэрэг гэж бид үзэж байна гэжээ. Үүнд манай талаас хариу өгөөгүй нь алдаа болсон байна.

Учир нь Алтайн нурууны цаадах Хуримт голын эхний салаанууд болох Той тогос, Ямаат, Ёлт, Бага түргэн, Их түргэн голуудаар манай ардууд байнга нутаглаж байгаагүй боловч хилийн цэргийнхний хяналтанд байсан бөгөөд дээрхи нэр бүхий газар нутгийг Хятадууд Монголын газар нутаг гэж хүлээн зөвшөөрөхгүйгээр үл барам янз бүрийн өдөөн хатгалга, гүтгэлэг явуулж, улам улам газар түрж суурьших бодлого явуулж байсан юм.

Хятадын цэргүүд Хуримт голд хэрэм маягийн буудлагын бэхлэлт байгуулж, Улаан уул хэмээх газар цэрэг оруулан суулгасныг манай талаас 1955 оны 6 дугаар сарын 8-ны өдөр Баян-Өлгий аймаг дахь Аюулаас хамгаалах хэлтсийн дарга С.Гэрэлчулуун, Хятадын цэргийн харуулын дарга Мамарбек, Шар сүмийн цэргийн штабын офицер Сайж нартай албан ёсоор уулзаж Улаан ууланд буй цэргээ татаж авахыг шаарджээ.

Гэтэл 1955 оны 7 дугаар сарын 26-нд Хятадын гадаад яам манай элчин сайд Очирбатад "... Улаан хошуу гэдэг газар байгаа Хятадын цэргийг Монголын хилийн цэрэг хөөж байгааг танай засгийн газар мэдэж байгаа болов уу, шалгаж мэдэхийг хүснэ, хилийн асуудлыг гадаад харилцааны шугамаар ярилцаж зохистойгоор шийдвэрлэвэл сайн байна" гэжээ. Элчин сайд Очирбат төвөөс удирдамж авсны дагуу хэд хоногийн дараа Хятадын талд хариу мэдэгдэхдээ: "...Улаан хошуу гэдэг газарт болсон явдал нь орон нутгийн чанартай асуудал байна. Орон нутгийн байгууллагууд шийдвэрлэх биз" гэж туйлын тусгүй мэдэгдэл хийсэн байна.

Үүний оронд харин танай ХАЧА-ийн цэргийн анги эх орноо Гоминдааны үлдэгдлүүдээс чөлөөлсний дараа 1950 оны эхээр манай нутгийн Улаан хошуу хэмээх газрыг эзлэн авч тэнд байнгын цэргийн харуул суулгасныг баримттайгаар нотлон Хятадын талд цэргийн анги, салбараа буцааж гаргах талаар эсэргүүцэл тавих ёстой байжээ.

1956 оны 8 дугаар сарын 16-ны өдөр Хятадын гадаад яамнаас манай элчин сайдын яаманд мэдэгдэхдээ: Даян нууруас гарсан 4 монгол хүн Улаан хошуугаар хил зөрчлөө. Мөн 19-22-ны өдрүүдэд хоёр хүн Хоровын салаа гэдэг газраар орж ирэн шинжилгээний ажил хийв. Хилийн асуудал нь харилцан бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх зарчмын үндсэн дээр шийдвэрлэгдэнэ гэдэгт итгэж байна гэжээ. Манай элчин сайдаас Хятадын гадаад яаманд очиж Даяннууруас гарсан монгол хүн Хятадын хил зөрчсөн асуудлыг судалж байна гэж яаравчлан мэдэгдсэн байх юм. */Гадаад хэргийн яамны архив. Ф-1. д-3. хн-126/*

Хоровын салаа гэдэг газар бол улсын хилийн шугамаас 15 км, Улаан хошуунаас 20 км манай нутгийн гүнд Алтайн нурууны наад талд байгаа нутаг юм. Дээрх баримт нь газар нутаг, хилээ мэдэхгүй, анхаарахгүй хариуцлагагүй хандаж байсны илрэл гэлтэй. Үүгээр ч зогсохгүй Ховд аймгийн гүйцэтгэх захиргаа нь 1954 оны зуднаар Шинжаан мужийн захиргаанаас өөрсдийн нутаг болох Их шар булаг, Байтаг зэрэг газруудад өвөлжүүлэх хүсэлт гаргаж байсан нь туйлын гашуун эмгэнэлтэй үйл явдал болсон ба 1962 оны Монгол, Хятадын хилийн гэрээнд ч Байтаг уулын ар оройгоор хил тогтооход ч нөлөөлсөн байж болзошгүй. Учир нь хилийн гэрээнд Шинжааны талаас оролцсон төлөөлөгч Байтагын орчим газар нь манай нутаг дэвсгэр мөн гэсэн хатуу байр суурийг баримталж хилийн хэлэлцээрийг зарим үед тасалдуулах явдал ч гаргаж байсан байна.

Энэ үед төр засгаас хил хамгаалалтын анги, салбаруудыг татан буулгасан бөгөөд баруун, баруун хойт хилийг Ховд аймаг дахь Булган, Баян-Өлгий аймаг дахь Даяннуурын хилийн пунктийн /нэг пункт нь 10-12 хүнтэй байсан/ хүч хэрэгслээр 800 гаруй км хэсгийн хамгаалалтыг зохион байгуулж байсныг Хятадын тал далимдуулан улсын хилийг зөрчин хайгуул, шинжилгээний ажил явуулах, байгалийн баялгийг ашиглах, мал бэлчээрлүүлэх, орон сууц, барилга байшин барих, худаг шуудуу гаргах, зарим хүүр, оршуулгын газруудыг сэргээн засварлах зэрэг үйл ажиллагаа явуулж байлаа.

Улс орны үндэсний аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдалд бодит аюул заналыг хөрш зэргэлдээ улсын зүгээс байнга учруулах болсноор БНМАУ-ын Засгийн газар нь БНХАУ-тай хилийн хэлэлцээ явуулах санал төлөвлөгөө боловсруулахыг Гадаад явдлын яам, Нийгмийг аюулаас хамгаалах яаманд даалгажээ. Энэ талаар бэлтгэгдсэн нот бичгийн төслийг БНХАУ-д суугаа элчин сайд Лувсанд урьдчилан танилцуулж, санал авахаар явуулсан төсөлд Монгол, Хятадын хилийг түүхийн үүднээс тодотгон тогтооё гэсэн утгатай төсөл байжээ.

Элчин сайд Лувсан уг төсөлтэй танилцаад Монгол, Хятадын хилийн хэлэлцээг түүхийн үүднээс тодотгон тогтоох гэснийг хасаж өөрчлөн түүний

оронд "одоогийн хилээр" тодотгон тогтооё гэсэн санал оруулжээ. Энэ нь Зөвлөлт, Хятадын хооронд 1945 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Монголын тусгаар тогтнолыг зөвшөөрөн хүлээсэн нотод "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнолыг одоогийн хилээр нь зөвшөөрнө" гэж Хятадын гоминдааны засгийн газар илэрхийлсэн билээ. "Одоогийн хил" гэдэг нэр томъёог БНХАУ-ын засгийн газар хэрхэн үзэхийг манай нам төрийн удирдлага болон хилийн экспертийн гишүүд бид тэр үедээ маш их онцлон сонирхож байсан тухайгаа Б.Цэдэн-Иш гуай дурдатгалдаа онцлон тэмдэглэсэн байдаг.

1957 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр БНМАУ-ын засгийн газраас Монгол, Хятадын хилийг "одоогийн хилээр" тодотгон тогтоох хэлэлцээ явуулах санал тавьсан нотыг БНХАУ-ын засгийн газарт албан ёсоор анх удаа гардуулжээ. Хариу нотыг манай тал 1958 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авч үзэхэд "Хятад, Монголын хооронд хил тогтоогдоогүй, БНМАУ-ын "одоогийн хил" гэсэн явдал бол хил тогтооход зарчмын үндэс болно" гэж нотдоо дурьдсан байна. */Бүгд найрамдах монгол ард улсын газар зүйн байрлал, нутаг дэвсгэр судалгааны материал х-178/*

Манай хилийн экспертийн хэсгийнхэн одоогийн хилийн шугамыг газрын зураг дээр хэвээр нь зурж Хятадын засгийн газарт саналаа тавих нь зүйтэй гэж үзээд 1958 оны 7 дугаар сарын 18-ны өдөр БНМАУ-ын засгийн газраас БНХАУ-ын засгийн газарт тус улсын "одоогийн хил"-ийн шугамыг 1:1000000-ын масштабтай газрын зураг дээр зурж тодорхойлон нот дагалдуулан хүргүүлэв. Хятадын тал манай саналыг хүлээн авааД хилийн хэлэлцээрт бэлтгэж, 1958 оны намраас эхлэн хилийн дагуу олон тооны групп, хэсгүүдийг гаргаж газрын зураг үйлдэх, газар хэмжих, хилийн овоо тэмдгүүд дээр шинээр тоо дугаар тавих, нэмж мод босгох, хилийн овоонуудын хоорондох хилийн шугамыг тодорхойлж, гадас хатгах ажлуудыг 1960 он хүртэл явуулахаас гадна өөрийн нутгийн гүн талаас хятад иргэдийг хилийн шугамд олноор нь нүүлгэн шилжүүлж, заримдаа манай нутагт хашаа хороо, байшин барилга бариулах, худаг ус гаргах зэргээр өөрийн эзэмшлийн ул мөрийг баримтжуулах оролдлогыг явуулж байжээ.

Манай гадаад явдлын яамны дорнод хэлтсийн эрхлэгч Пүрэвжалаас Хятадын элчин сайдын яаманд Булган, Байтагийн чиглэлээр нутаг түрэн орж ирсэн айлуудаа буцаан гаргаж авахыг 1961 оны 8 дугаар сарын 19-нд шаардахад Хятадын гадаад яамны Азийн хэлтсийн дарга нь манай элчин сайдын яаманд мэдэгдэхдээ: "Байтаг богд түүний хавь газар бол Хятадын нутаг юм, Монголын боомтын дарга Цэдэв манай хүмүүсийг хөөж байгааг манай тал зөвшөөрөхгүй байна. Бид хилийн хэлэлцээнд идэвхтэй бэлтгэж байна. Дахин ийм явдал гаргахгүй байхыг Монголын засгийн газарт уламжилж байв.

Бээжинд суугаа манай элчин сайдын яам нь зохих удирдамж ёсоор Хятадын гадаад яаманд 1961 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр дор дурдсан асуудал тавив. Үүнд: "Хятадын сангийн аж ахуй 1952 онд Байтаг уулын өвөрт буй болсон юм. Тэр нь сүүлийн 2 жилийн дотор

Байтаг уулын ар талын манай нутагт орж бэлчээр эзэмшихийг оролдож байгааг та нөхөд анхаарч үзмээр байна. Монголын иргэд ба цэргийн хүмүүс Хятадын нутагт орсон удаагүй, гагцхүү танай талаас хил давж манай нутагт орж ирсэн айлуудыг буцаах гэсэн зүй ёсны шаардлага тавьсан юм, тавих ч болно, Байтагийн сангийн аж ахуйдаа айл, малаа маргаан гаргахгүйгээр татаж авах талаар заавар өгөхийг хүсье" гэжээ. / *Гадаад хэргийн яамны архив. Ф-1. д-2. хн-235/*

Энэ талаар Хятадын Гадаад яам хариу өгч асуудал ярилцаагүй байтал 1962 оны 2 дугаар сарын 8-ны өдөр Байтагийн сангийн аж ахуйн бригадын дарга Жархай гэдэг хасаг хүн манай пунктэд ирж мэдэгдэхдээ "...бид өөрийн засгийн газрын шийдвэрээр 52 суурь хонин сүргийг Байтаг уулын Нарийн харгайт, Бүдүүн харгайтад оруулж улмаар Гурван хүүхэд, Уушиг, Бүдүүний ус хүртэл нүүдэллэж хонио төллүүлнэ. Энэ газрууд бол Хятадын нутаг гэж манай дээд газар зааж өгсөн билээ. Гэтэл нүүж ирээд байгаа айлуудыг танай ардууд хөөж байгаа нь зохимжгүй байна" гэжээ. Ингэж 2 тал маргалдсаар нилээд хэдэн сарыг үдсэн байна.

Газар нутгийн маргаанаас гадна хоёр талаас харилцан зодолдох, зарим үед буун дуу ч хүртэл гарч байсан баримтууд цөөнгүй бий. Тухайлбал: Хятадууд Байтагийн ар оройд байсан хэсэг төгөл модыг огтолж байхад манай хүмүүс болиулж, ачааны машинд ачин хурааж авахад өмнөөс нь эсэргүүцсэний улмаас харилцан зодоон үүсчээ. Хятадууд зургийн аппаратаар зураг дарж байх хооронд манай хүмүүс хурааж авсан модоо аван буцжээ.

Байтаг богд уулаар манай хилийн дотор орж ирээд суурьших гэж байсан Хятадын 20 гаруй тооны айлуудыг 1962 оны 3 дугаар сарын 20-ны өдөр манай талаас тэдний гэрийг буулган ачаад хил тийш явж байтал морь унасан 5 хятад иргэн давхиж ирээд тэмээн ачааны татлагуудыг зад татан хаяж, нэг этгээд нь дүүгүүрээр манай хүмүүсийн толгойг хага цохихоор довтлох үед нь винтовоор цохин унагажээ. Мөн 1962 оны 3 дугаар сарын 24-нд Байтаг уулын зүүн хажуугаар манай нутагт орж ирсэн айлуудыг буцаан нүүлгэхийг шаардаж очсон манай хилчний бууг булааж авахыг завдсан хятадыг гуяа руу нь буудан унагажээ. Гэтэл 3 хоногийн дараа Хятадын гадаад яамнаас манай элчин сайд Тойвыг дуудаж түүнд мэдэгдэхдээ: "Манай хоёр улсын хил дээр цус дуссан харамсалтай явдал боллоо. Өөрийн иргэдийг хамгаалахын тулд бид цэргээ оруулав" гэжээ. Энэ мэдээг хүлээн авсан тэр өдөр Хятадын цэргүүд аль хэдийн манай нутгийн Хуримт гол, Ямаатын гол, Их шар булаг, Бага шар булаг, Баянмод, Байтаг уулыг бүхэлд нь эзэлж, Говь хонин усны чиглэлээр манай хилийг 5-15 км гүн зөрчин орж суурьшсан байжээ.

Манай талаас газар нутаг түрж эзлэх явдлаа зогсоох, хилийн хэлэлцээг эхлүүлэхийг 1960 онд Хятадын ерөнхий сайд Жоу Эньлайд мэдэгдэж хилийн маргааны зөрчил, тэмцэл нилээд хурцадмал байдалд хүрсэн үе буюу 1962 оны тэргүүн хагаст Хятадын зүгээс хилийн хэлэлцээ явуулахыг яаравчилсан байдалтайгаар хүлээн зөвшөөрч, нэн даруй хилийн төлөөлөгчдөө томилж, хил хязгаарын асуудлыг шийдвэрлэе гэж уриалсан юм.

1962 оны 10 дугаар сарын 16-нд хилийн комиссын анхдугаар бүгд хуралдаан болж комиссын гишүүн Б.Цэдэн-Иш 2 талын маргаантай 30 хэсэг газрын талаар Монголын төлөөлөгчдийн баримтлах саналыг хэлсэнд Хятадын тал нэгд нэгэнгүй тэмдэглэж аваад танай саналыг судалж үзээд 2 хоногийн дараа хариу өгье гэснээр хуралдаан түр засварлажээ. Үүнээс хойш 4 хоногийн дараа Хятадууд манай саналын хариуд 30 хэсэг газрын 16-г манай саналаар болгож, 5 хэсэг газарт ялимгүй засвар хийж, 9 хэсэг газарт өөрийн саналыг хэвээр хадгалахаар баримтална гэдгээ мэдэгджээ.

Хилийн комиссын 5 дахь удаагийн уулзалтаар маргаантай 10 хэсэг газрын асуудлыг шийдвэрлэж чадсан боловч Байтаг, Бага Хавтага, Баянмод, Соёлз зэрэг 4 газрын асуудлаар харилцан буулт хийлгүй маргалдаж эхэлжээ. Энэ үед Хятадууд нь танайх 1945 он хүртэл Байтагт хүрч байгаагүй гэж сүржин байдлаар илэрхийлэхэд үүний хариуд манай тал нь Байтагт хүрсэн хүрээгүйг танай хятад хүмүүс сайн мэднэ. Хасагийн дээрэмчдийг номхотгохоор Өрөмчийн Хятад цэргүүд ба манай цэргүүд Байтагт хамтран ажиллаж явсныг мартаагүй байх гэх зэргийн баримтыг ярьжээ. Хятадууд өөрсдийн хэлснээ цааш нотлохыг оролдсонгүй, харин тэр үеийн хасагийн мууг одоогийн хасагт тохож болохгүй гэжээ.

Хоёр талын төлөөлөгчид Соёлз уулын орой хүртэл одоогийн хилээ 15 км цааш сунгаж, Монголын талд нэг хэсэг газрыг оруулж, Байтаг уулын ар хормойгоор хилийн шугамыг тахиралдуулан Хятадын нутагт нэг хэсэг газрыг өгч байж харилцан тохиролцсоноор мухардмал байдлаас гарчээ.

Монгол, Хятадын хилийн хэлэлцээ уул асуудлаа шийдвэрлэж, 1962 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр монгол, хятадын хилийн шугамыг тодорхойлсон анхны протоколд гарын үсэг зурагдсанаар маргаантай гэх 30 хэсэг газрын 17321 ам дөрвөлжин км нутаг дэвсгэрээс 12314 ам дөрвөлжин км газар нь манайд үлдэж, 5007 ам дөрвөлжин км газрыг Хятадын талд оруулан баталгаажуулсан байна.

Баруун өмнө ба баруун зүгийн хилийн асуудал түүхийн хугацаанд ихээхэн хувьсаж, өөрчлөгдөж ирснийг дээр дурьдсан билээ. Хиагтын гурван улсын гэрээгээр Алтайн хязгаарын 10 хошууг Монголоос тусгаарласнаар 100000 ам дөрвөлжин км нутаг алдагдсан билээ. Гэвч 1962 оны энэхүү хилийн гэрээгээр 10 хошууны нутгийн дундуур буюу Монгол Алтайн нурууг барьж шинэ хил тогтоосноор дээрх 100000 ам дөрвөлжин км нутаг дэвсгэрээс 55000 ам дөрвөлжин км газар нутгийг Монголчууд эзэмших болсноороо түүхэн ач холбогдолтой гэрээ яахын аргагүй мөн болжээ.

МАНЖ ЧИН УЛСЫН ХОЙД ЗҮГИЙН ХИЛИЙН БОДЛОГО БА ТАГНА-ТУВА

дэслэгч Л.Одзаяа

Монголд тогтсон Манжийн төрийн бодлогыг судлах нь Монголын түүх, тэр дундаа хилийн түүхийн судалгаанд чухал ач холбогдолтой юм. Манж Дайчин гүрэн бол Хятадыг захирахад Хятадын төрийн уламжлалыг өвлөн авч хэрэглэж, Монголыг захирахад Монголын төрийн уламжлалыг өвлөн авч тэдгээр улсуудыг захирч байжээ. Өөрөөр хэлбэл Монголын эзэн харъяатын ёсны суурин дээр Манжийн дэглэмийг тогтоож, үүнийгээ бататгахын тулд тэд эдийн засаг, гадаад харилцааны гол арга болох худ ургийн холбоо тогтоох, бэлэг өгөх зэрэг уламжлалт аргуудаа ашиглан Монголыг болон бусад улс, үндэстэнг эзлэн авсан билээ[1].

[1] David Sneath. Headless state. NY 2007. pp 35

Энэ үед Хаант Орос улсл Волга мөрнөөр нутаглаж байсан Халимаг, Байгал нуурын зүүн эргээр нутаглаж байсан Буриадуудыг өөрийн хараат болгож цаашид тус улсын эзэн хааны эрх мэдлийг Төв азид тогтоохоор зүтгэх болсон. Иймээс энэхүү бодлогоо хэрэгжүүлэхийн тулд Оросын I Петр хаан Халх Монголын хойд хилийг тогтоох нь Манжийн хааны онцгойлон анхаарсан хэрэг байсан бөгөөд ялангуяа Енисейн эх газар Их Орос улсад харьяалагдах ёстой хэмээн Петр хаан захисан байдаг. Ингээд захиас ёсоор XIX зууны сүүлчээс алт олзворлогч Оросууд Урианхайн хязгаарт ирдэг байсан ба улмаар түүнийг дагаад Оросын тариачин ардууд нутагших болжээ.[2]

Иймээс Манж улс Хаант Оросын газар нутгийн түрэлтийг зогсоохын тулд Халхын хойт хилийг нарийвчлан тогтоохоор Хаант Оростой хилийн хэлэлцээр хийж, 1727 онд Буурын гэрээ байгуулав. Уг гэрээгээр Эргүнэ голын зүүн эргийн Авгайт уулнаас баруун Саяны нурууны Шавинайн даваа хүртэл хил тогтоожээ. Ийнхүү Манж Дайчин улс–Хаант Оросын хилийг Ар Монголын нутгийн хойгуур буюу Барга, Халх, Хөвсгөлийн болон Тагна Урианхайн нутгийн хойгуур тогтоосон ба энэ нь одоогийн Монгол улсын хойд хилийн үндэс болсон хэдий ч үүнээс Тагна-Урианхайн нутгийг XX зууны эхээр үүрд алдсан юм.[3]

Тухайн үед Манж улс Хаант Оростой төдийгүй Зүүнгартай мөн хилийн хэлэлцээ хийж байсан бөгөөд Тагна, Хэм, Хэмчигээр нутагладаг урианхай буюу Туваг өөр өөрсдийн нутаг дэвсгэрт багтаах сонирхолтой байсан авч эцсийн дүнд эл бүс нутгийг хуучин харъяалын дагуу Манж Дайчин улс өөрийн нутаг дэвсгэр хэмээн Хаант Орос болоод Зүүнгараар хүлээн зөвшөөрүүлж чадсан юм. Улмаар Манжийн хаан Тагны Урианхай нарыг Оросод дагаар орохоос сэргийлж, Улаангом болон Хан хөхийн нуруугаар дотогшлуулан суулгаж байгаад хожим манжууд бүх монголчуудыг эзлэн авсны дараа тэд нарыг суугуул нутагт нь буцаасан билээ.[4]

[2] Умард хөрш сэтгүүл. УБ., 2007. 1-р сар. т. 7

[3] Б.Цэдэн-Иш. Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс. УБ ., 2003. т.155

[4] Ж.Гэрэлбадрах. Монгол нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ.,2006. т.96

Ингээд Манж улсын Найралт төв хаан Тагна-Урианхайг өөртөө багтаахын тулд Зүүнгартай найрамдалт харьцаа тогтоох бодлого баримталж Тагна уулаар нутагладаг Урианхай нарын монгол ноёдод алба барьж байсан явдлыг чадамгай ашиглаж, Урианхайн нутаг буюу хожим "Тагна-Урианхай" хэмээгдэх болсон газар нутгийг Манж Чин улсын нутаг дэвсгэрт багтааж чадсан байна. [5]

Цаашлаад Манж улсын хаан Тагна-Урианхай нараар 4 хошуу 26 сум зохиож (тэд Улиастайн жанжинд өргөсөн бичигтээ ийнхүү бичсэн байдаг). Харин судлаач Ж.Гэрэлбадрах 4 хошуу, 21 сумтай байсан гэж өөрийнхөө бүтээлдээ бичсэн байна[6]. Тэдгээр 4 хошууны үхэр да[7] (Тагна-Урианхайн хошууны захирагч) нар Улиастайн жанжинд захирагддаг байв. Тагна Урианхайгийн үхэр да нар цаашид өөрсдөө тамгаа барин хэрэг шийтгэж байх хүсэлтээ илэрхийлэн дээш өргөн мэдүүлсэн бичигтээ:

Урьд бид боолын боол дор явсныг богд эзэн энэрэн өршөөж дараа дараагаар өндөр зузаан хүнд их хишиг хүртээж, үхэр да-гийн алтан тамга өгч хошуу зохиож, туг хиур, мэйриний зангийн зэрэг, үхэр да сумны занги, хүнд бошго тавьж, боол болгон тус тус жаргуулснаас хойш, халхын мэйриний занги Мунижав, тэргүүн зэргийн тайж Гомбожав, туслагч Дэлэгдаш нар үхэр дагийн тамга барьж сургамжлан захирч мунхаг маныг бичиг хэрэг шажин ном дор сургасан бөгөөд боол бид мунхаглан санаваас, гагцхүү бид лугаа адил боол Алтай Урианхай, Захчины үхэри да Занабага нар богд эзний хайрласан алтан тамгыг тэдний биесэд тушаан бариулаад алтай урианхай захчин нарыг Ховдын хэбэй амбан захирсан бөгөөд, Тагна Урианхай биднийг Улиастайн жанжин, хэбэй амбан захирсан тул эдүгээ мунхаг бид хичээнгүйлэн санахуул үр үрийн тойн дор хүртэл халхаас гарч захирч суухад адил боолууд бид Манжаас Монголд суулгаж байсан төлөөний сайд суухад адил боолууд бид Алтайн Урианхай, Захчин нартай нэгэн адил маньд өршөөсөн тамгыг боол бидний нэгэнд бариулбаас болох, үл болох явдал захирсан ноён таны газраас уламжлан өргөюу сурган заах ажаамуу[8] хэмээн мэдүүлсэн байна. Үүний дараа тэд дахин өөрсдийн биеэр ирж Дэлэгдашаар уламжлан ирж Хэбэй амбанаас хошууны алтан тамгаа өөрсдөө барья гэж гуйхаар мэдүүлэхэд хариу болгож ийнхүү мэдүүлсэн:

Өдгөө тэсгим хүйтэн цас бас их эрхэм албаны хэрэггүй бөгөөд ... Дэлэгдаш нь мэйриний зангийн зэрэг тайш нарт харуул орох тэмдэгт бичгээн эс өгсөн нь зөв. Энэ жил 7 сард мэйриний зангийн зэрэг тайш, үхэри да нарт тамгаа барихыг гуйх тул бичиг өргөөд Дэлэгдашийн газраас уламжлан өргөн хүргэж ирсэнд бид даруй хойш буцааж тушаасан билээ. Эдүгээ тайш нар бас биеэр ирж тамга барихыг гуйя гэсэн нь ихэд буруу болжээ.[9] хэмээн хэбэй амбаны газраас тэднийг сүрхий донгодсон байдаг. Дээр өгүүлсэн мэдээнээс харуул орох тэмдэгт бичиг гэсэн мэдээг нягталж

[5] О.Оюунжаргал. Манж Чин чин улсаас Монголчуудыг захирсан бодлого. т.36

[6] Ж.Гэрэлбадрах. Монгол нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ., 2006. т. 95

[7] Тагны Урианхайн 4 хошууны бүгдийн дарга нарыг ийнхүү нэрлэж байжээ.

[8] Тувагийн түүхэнд холбогдох архивын баримтын эмхтгэл. Боть I. УБ., 2011. т. 13

[9] Тувагийн түүхэнд холбогдох архивын баримтын эмхтгэл. Боть I. УБ., 2011. т. 14

үзвэл 1727 оны Манж-Оросын Буурын гэрээгээр Халхын нутгийн хойт хилийг тогтоохдоо Тагны нутгийн хойгуур тогтоосон байсан хэдий ч хилийн харуул нь Тагна урианхайн урдуур байжээ гэдгийг нотолж байна. Дээрх мэдээг судлаач Ж.Гэрэлбадрах: XIX зууны дунд үеэс Тагнын Тувагийн Оростой хиллэх Саяны нуруугаарх хилийн хамгаалалт хяналт сул, хилийн шугам ч тодорхой бус байсан. ... Ийм учраас Оросууд Туватай зах нийлэх хилийн шугам, овоо тэмдгийг тогтоох, шалгах ажлыг хэдэнтээ хийж, улмаар 1727 онд тогтоосон хилийн шугам төдий л өөрчлөгдөлгүй XX зуунд хүрсэн гэж үзжээ.[10] Мөн үүний талаар судлаач Д.Шүрхүү: XX зууны эхээр Хаант Орос тус хязгаарыг эзлэн авах шалтаг болгон урианхайн хилийн асуудлыг гаргаж тавьсан байдаг. Тухайн үеийн Оросын хэвлэлээр хэд хэдэн үндэслэл гаргаж тавьсан байдаг. Үүнд:

1. Орос-Манжийн хил нь Саяаны нуруугаар бус Тагна нуруугаар байх ёстой

2. Енисей бол Оросын мөрөн, эх оросуудын мэдэлд байх ёстой.

3. XVII зууны үед Енисей мөрний эх Тагна, Саяаны нуруугаар нутагтай урианхай нар Алтан хааны захиргаанд байх үедээ Орост дагаар орж үслэгийн алба барьж байсан.

4. Манж Чин улс хилийн харуулуудаа Тагна уулын өвөөр суулгаж, Улиастайн жанжин тус хилийг шалгахдаа зөвхөн Тагна уулын өвөөр шалгаж байсан.

Үүн дээр үндэслээд Оросууд Орос-Манжийн хилийн шугам урианхайн хязгаарын хаагуур байж болох вэ? гэдэг асуудал дэвшүүлсэн.

Энэ үед Тагна-Урианхай албан ёсоор Манж Чин улсын бүрэлдэхүүнд улиастайн жанжны захиргаанд багтаж байсан боловч засаг захиргааны талаар нэг хэсгийг Улиастайн амбан ноён, нөгөө хэсгийг нь Халхын ноёд, харин хамгийн том хэсэг болох Хэмчигийн хошуу нь бие даасан байдалтай байв.[11]

Манжийн засаг захиргаа энэ үед гол төлөв татвар татах, албан тушаалд томилох, зарга мэдүүлгийг шүүх зэргээр ажиллаж байв.

Гэвч удалгүй Чин гүрэн задран унаж Монгол улс тусгаар тогтнолоо зарласан нь Хаант Орос улс Монгол тэр дундаа урианхай хязгаарт явуулах бодлогоо эргэн харах шаардлагатай болжээ.

Монголын засгийн газар Хаант Оростой урианхайн асуудлаар харилцахдаа Оросыг эсэргүүцэх үү, Монголын тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэх гадаад бодлогын түшиг болгохын тулд эвлэрэнгүй бодлого явуулах гэсэн альтернатив сонголттой тулгарсан. Ингээд сонголтоо хийж Хаант Оросыг түшиж түүнтэй эвлэрэнгүй харилцах бодлого явуулахаар тогтсон билээ.

1914 онд Хаант Орос Урианхайн хязгаарыг ивээлдээ авч, оросын оршин суугчдад зориулан тосгон байгуулан, цаашлаад тус оны 4-р сарын 17-нд Туваг өөрийн хараат болгосон тухайгаа зарлан Урианхай хязгаар г эсэн нэрийн дор Енисейн амбан захирагчийн мэдэлд шилжүүлэн авснаар[12] Буурын гэрээрээр тогртосн хилийн шугам өөрчлөгдөн Монголын баруун хойд хил дотогшлох үндэс тавигдсан байна.

[10] Ж.Гэрэлбадрах. Монгол нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ., 2006. т. 95, 96

[11] Д.Шархүү. Диссертаци. Монгол-Тувагийн харилцааны олон улсын байр суурь. УБ., 1999. Т. 8

[12] Умард хөрш сэтгүүл. УБ., 2011 оны 10 сар. т.16

ЦЭРГИЙН СЭТГЭЛ СУДЛАЛЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, СЭТГЭЛ ЗҮЙН АЖЛЫН ОНЦЛОГ

магистр, дэслэгч Ж.Гэрэлчимэг

Цэргийн сэтгэл судлалын түүхэн хөгжил, зорилго, судлах зүйл

Цэргийн сэтгэл зүйн ухааны үүсэл хөгжлийн тухай асуудал бол цэрэг дайны түүхтэй салшгүй холбоотой бөгөөд хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн явцад цэрэг арми үүсч хөгжсөн тэр цагаас эхлэлтэй гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Сэтгэл судлалын ухаан одоогоос 2000 гаруй жилийн өмнө эртний Грекийн их сэтгэгчид Демокрит, Платон, Аристотель нарын философийн сургаалийн бүрэлдэхүүн хэсэг болж үүссэнийг бид мэднэ. Сэтгэл судлалын ухаан түүхэн хөгжлийнхөө явцад улам боловсронгуй болж түүний судлах зүйл, судалгааны арга хэлбэр ч төгөлдөржихийн зэрэгцээ бие даасан шинжлэх ухааны хувьд өөрийн гэсэн салбаруудтай болж өргөжсөний нэг нь цэргийн сэтгэл зүйн ухаан юм. Цэргийн сэтгэл зүйн шинжлэх ухааны үүсэл хөгжилд эртний Грек, Рим зэрэг улсуудад хөгжиж байсан философийн шинжлэх ухааны үзэл санаа онолын чиглэл урсгалууд ихээхэн нөлөөлсөн нь дамжиггүй.

Манай эриний III зууны үед Александрын эмч Герофил, Зразистрат нар нервийн тухай анхны сургаалыг боловсруулан хүний сэтгэцийн үйл ажиллагаа, түүний гүйцэтгэх үүрэг нь тархинд үзүүлсэн цочролоос шалтгаалдаг бөгөөд хүний тодорхой нэг эрхтэн бүр нь түүний сэтгэл санаатай холбоотой байдаг гэж тодорхойлж байсан юм.

Мөн манай эриний өмнөх II зууны үед Римийн эмч Гален тэр үеийн физиологи, анагаах ухааны ололт амжилтыг нэгтгэн дүгнэж хүний сэтгэцийн үйл ажиллагааны физиологи үндсийн тухай анхны төсөөллийг боловсруулсан нь цэргийн сэтгэл зүйн ухаанд онол, арга зүйн талаар томоохон нөлөө үзүүлсэн дорвитой нээлт, тулгуур болсон юм.

Эртний соёл иргэншлийн өлгий болсон Монгол, Рим, Грек, Орос зэрэг улс гүрнүүдийн цэрэг дайны үйл ажиллагааны тухай түүхэн уг сурвалжуудаас авч үзэхэд цэргийн жанжин, жирийн цэргүүдийн баатар зоригийн талаар их анхаарч зоригтой шийдэмгий дайчдыг ихэд дээдлэн хүндэлдэг байсан баримт жишээ цөөнгүй бий.

Эрт эдүгээгээс эхлэн цэргийн хүний боол, гладиаторуудын хувьд ч ялгаагүй зоригийн шинж чанарыг ихээхэн эрхэмлэдэг байсан бөгөөд тухайн үеийн цэргийн сэтгэл зүйн ухаан цэрэг дайчдад эр зоригийн хүмүүжил, тэсвэр хатуужил олгох чиглэлээр түлхүү хөгжиж байсан гэж үзэх бүрэн үндэслэлтэй юм.

Цэргийн сэтгэл зүйн ухааны хөгжилд дорвитой хувь нэмэр оруулсан хүн бол Английн сэтгэл зүйч, философич Джон Локк /1632-1704/ бөгөөд тэрээр анх удаа туршилтын сэтгэл зүйн онолын үндэслэлийг боловсруулсан юм. Ж.Локкийн сэтгэл зүйн ухаанд эмпиризм чиглэлийг оруулж ирэхдээ гаргаж тавьсан гол үзэл санаа нь хүний

амьдралын бүх мэдлэг, дадлага, чадвар зэрэг нь түүний туршлагаас хамаарна гэж үзэж, уг суурь ойлголтыг дараах хоёр үндэслэлээр тавьжээ. Үүнд:

1. Мэдрэхүйн гадаад эрхтний үйл ажиллагаа

2. Оюун ухаан үйл ажиллагаа гэж тайлбарласан байдаг. Тэрээр хүн төрөхдөө бэлэн үзэл санаагүй төрдөг. Хүний оюун санаа бол цэвэр самбар юм гэж сэтгэцийн үзэгдлийн мөн чанар, зүй тогтлыг тайлбарлаж байсан нь тухайн үеийн цэргийн сургалт бэлтгэл, цэргийн сэтгэл зүйн ухаанд тодорхой нөлөө үзүүлж байсан байна.

Мөн түүнчлэн цэргийн сэтгэл зүйн ухааны цаашдын хөгжилд онолын үүднээс шийдвэрлэх нөлөө үзүүлсэн бүтээл бол Оросын алдарт физиологич, сэтгэл судлаач И.М.Сеченовын 1863 онд бичсэн "Тархины рефлекс" хэмээх зохиол юм. Уг бүтээлд хүний сэтгэц, ухамсар үүсч хөгжих зүй тогтлыг шинжлэх ухааны үүднээс нарийн тайлбарлаж сэтгэцийн үзэгдэл нь амьд биеийг хүрээлэн байгаа гадаад орчны тусгал болохыг баталж, хүний сэтгэцийн үйл ажиллагаа нь рефлексийн зарчмаар явагддаг зүй тогтлыг нээсэн нь цэргийн сэтгэл зүйн ухааны хөгжилд асар их ач холбогдол үзүүлжээ.

Орос оронд 1096 онд хэвлэгдсэн "Владимир Мономахын сургааль" хэмээх түүхэн сурвалж бичигт цэрэг хүн аян дайны үед биеэ хэрхэн авч явах талаар тодорхой өгүүлж байсан бол 1649 онд бичигдсэн "Алексей Михайлович хааны түүвэр сургаал" номонд цэрэг эрсийн сэтгэл санааны байдлыг алба хаах явцад нь анхаарах талаар бичсэн төдийгүй, цэргийн албанд ирсэн хүмүүсийн сэтгэл зүйг судлах шаардлагатай гэдгийг онцлон тэмдэглэж байжээ. Цэргийн хэргийн өсөлт хөгжил, зэвсэг техникийн шинэчлэлт Орос оронд байнгын арми үүссэн зэрэг тодорхой хүчин зүйлүүд цэргийн сэтгэл зүйн ухааны цаашдын хөгжил дэвшилд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн байна. Цэргийн хэргийн онолч Окисим Михакловын XVII зууны эхэнд зохиосон "Цэргийн хэрэг, их буучид"-ын дүрэмд цэргийн сургалт, хүмүүжлийн зарчмын талаар дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. XVIII зууны сүүлийн хагаст Орос оронд байнгын арми байгуулагдаж улс орныхоо аюулгүй байдал, газар нутгаа өргөтгөх төрийн бодлого хүчтэй явагдсан нь I Петр хааны /1672-1725/ бодлого үйл ажиллагаатай салшгүй холбоотой юм. Цэргийн сэтгэл зүйн ухааны онол практикт тулгуурласан цэргийн сургалт бэлтгэлийн системтэй үйл ажиллагаа гагцхүү I Петр хааны цэрэг армийн талаар авч явуулсан дэс дараатай арга хэмжээний үр дүнд бий болсон төдийгүй цэргийн сэтгэл зүйн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, практик үйл ажиллагаа тогтмолжсон нь I Петр хааныг цэргийн сэтгэл зүйн ухааныг үндэслэгч гэж нийтээр хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн юм. Тэрээр цэрэг дайчдад эх оронч, үндэсний үзэл төлөвшүүлэхэд үлэмж их анхаардаг байсан нь түүний Полтавын тулалдааны өмнө Оросын цэрэг дайчдад хандаж гаргасан уриалгад тодорхой тусгагдсан байдаг.

I Петр хааны цэргийн сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаанд оруулсан дэвшилтэт үзэл санааг үргэлжлүүлэгч нь цэргийн хэргийн онолч фельдмаршал П.А.Румянцев /1725-1796 он/, Оросын цэргийн нэрт


жанжин А.В.Суворов /1730-1800 он/ нар юм. Ялангуяа А.В.Суворовын цэргийн сурган хүмүүжүүлэх, сэтгэл зүйн ухааны салбарт оруулсан хувь нэмэр асар их. Тэрээр цэрэг дайчдыг учир утгагүй албадах, зодох явдлыг эрс эсэргүүцдэг байсан ба харин тэдэнд итгүүлэх, үнэмшүүлэх, эх орон ард түмнийхээ төлөө амиа эс хайрлах эх оронч үзэл санаагаар цэрэг олон түмнийг сургах хүмүүжүүлэх явдал туйлын чухал болохыг удаа дараа онцлон тэмдэглэж байсан нь түүний зохиол бүтээлд тэмдэглэгдэн үлджээ.

А.В.Суворовын шавь генерал М.И.Кутузов /1745-1813 он/ үргэлжлүүлэн дайны талбарт шийдвэрлэх үүргийг сайтар бэлтгэгдсэн цэрэг дайчид л амжилттай шийдвэрлэдэг болохыг онцлон үзэж байсан юм. Мөн түүнчлэн тухайн үеийн Оросын цэргийн нэрт жанжинууд, онолчид болох Ф.Ф.Ушаков /1745-1817 он/, адмирал Д.Н.Сенявин /1763-1831 он/ П.С.Нахимов нар ч цэргийн сэтгэл зүйн ухааныг онол арга зүйн талаар хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулсныг тэмдэглэх нь зүйтэй. XIX зууны сүүл, XX зууны эхэнд цэргийн сэтгэл зүйн ухааныг хөгжлийн шинэ шатанд гаргасан хүн бол Оросын агуу их адмирал С.О.Макаров /1848-1904/ юм. Тэрээр цэргийн сэтгэл зүйн бэлтгэлийн асуудлаар дагнан судалгаа, шинжилгээ хийж аливаа дайн тулаанд сэтгэл зүйн хувьд сайтар бэлтгэгдсэн эх орон, ээзэн хаандаа туйлбартай үнэнч цэрэг, усан цэргүүд л эх орныхоо найдвартай хамгаалагч байна гэдгийг нийгмийн бүх давхаргынханд ойлгуулах, соён гэгээрүүлэх ажлыг өргөн далайцтай хийсэн байна.

Цэргийн сэтгэл зүйн ухааны түүхэнд цэрэг дайчдын сэтгэл зүйн бэлтгэл түүний бүрэлдэхүүн хэсэг, сэтгэл зүйн бэлтгэлийг зохион байгуулах ажлын талаар томоохон хувь нэмэр оруулсан, цэргийн сэтгэл зүйн бэлтгэлийн онолыг үндэслэгч нь цэргийн сэтгэл судлаач генерал М. Драгомиров юм.

Цэргийн сэтгэл зүйг хавсрага салбар болоход И.М.Бехтерев, Н.П.Нечаев, Л.Калачников, В.Полянский зэрэг эрдэмтний туршилтыг хэрэглэсэн явдал тодорхой үүрэг гүйцэтгэсэн юм.

ШИНЭ НОМ



Хилчин овогт доктор, профессор, хуранда Н.Наранжамц "Бүс нутаг-хил хамгаалалтын үзэл баримтлал" нэртэй ном бүтээн туурвижээ. Энэхүү ном нь хил хамгаалах байгууллагын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсэн цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилго тавьсан дорвитой бүтээл болжээ гэж үзэж байна. Хил хамгаалалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах нь өнөөгийн нөхцөлд цоо шинэ зүйл мэт боловч 1990-ээд оны сүүлээр тухайн үеийн хил хамгаалах байгууллагын удирдлага, тухайлбал хошууч генерал, доктор профессор Д.Басарсадын (асан) дэмжлэгтэйгээр хурандаа Н.Наранжамцын идэвхи санаачлагаар хил хамгаалалтыг ирээдүйд бүсчилсэн хэлбэрт шилжүүлэх зорилгоор хилийн төлөөлөгчийг удирдах газруудыг байгуулан, үйл ажиллагааг нь эхлэн явуулж байсан билээ.

Монгол Улс өргөн уудам газар нутагтай хангай, говь, уул, хээр тал хосолсон физик газарзүйн онцлогтой, харьцангуй хүн цөөн, дэд бүтэц хангалттай бус зэрэг нөхцлийг харгалзан улсын хил хамгаалалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах, бүх төрлийн хангалтуудыг энэ чиглэлээр хийх ёстой гэж үздэг хүмүүсийн нэг хошууч С.Гүржав хянан тохиолдуулсан байна.

Зохиогч энэхүү бүтээлдээ:

-Монгол Улсын хил хамгаалалтын талаар гарсан зарим эрх зүйн баримт бичгүүд нь бүсчилсэн хил хамгаалалтад шилжих эрх зүйн үндэс болж байгаа;

-Монгол Улсын физик, газарзүйн онцлог, нутаг дэвсгэрийн байршил;

-Бүс нутгуудын өөрийнх нь байдал, түүнд тохирсон хамгаалалтын онцлог;

-Хилийн цагийн байдлын өнөөгийн нөхцөл, хилийн зөрчил зохион байгуулалттай хэлбэрт шилжиж байгаа;

-Хил хамгаалах байгууллагын бүтэц, зохион байгуулалт, бүх төрлийн хангалт үйлчилгээ;

-Хүний нөөц, түүний чадавхи;

-Хилийн отрядуудын зэрэглэл, түүний онцлог;

-Урамшууллын механизм болон бусад олон чухал асуудлыг хөндөн хилчид бидний өмнө дэлгэн тавьж байна.

Цаашид нарийвчилсан судалгаа хийж шинжлэх ухааны үндэслэлийг улам нарийн гаргаж хэрэгжүүлж ажиллавал Монгол Улсын хилийн аюулгүй байдал, хил хамгаалалтад үнэтэй хувь нэмэр оруулахуйц бүтээл болсоныг толилуулж байна.



Хилийн харуулаар улсын хилийг манах, хамгаалах ажиллагааны талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийгдэн ном, гарын авлагууд гарсан ба тэдгээрийн үргэлжпэл болгон улсын хилийн сэргийлэх болон хориглон хамгаалах үеийн хилийн хүчжүүлсэн харуулын тактик /байлдаан/-ийн ажиллагааны голлох асуудлуудыг доорх байдлаар илэрхийлж байна.

Энэ удаагийн Хилийн сургуулийн хилийн албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа Х.Жаргалсайхан "Хилийн харуулын тактик ажиллагаа" сэдэвт гарын авлагыг албан хэрэгцээнд сургалтанд зориулан хэвлүүлэн гаргасан байна.

Энэхүү бүтээлдээ

- Улсын хилийг сэргийлэн ба хориглон хамгаалах үед улсын хил зөрчин халдсан зэвсэгт бүлэглэлийн байрлал, бие бүрэлдэхүүн, түшиц газрууд, бааз болон удирдлагын байрыг цаг тухайд нь илрүүлэн устгах зорилгоор явуулах байлдааны ажиллагаанд хүчжүүлсэн хилийн харуулын хүчээр явуулах тактикийн тусгай ажиллагаа;
- Эдгээр үүргийг гүйцэтгэх хүчжүүлсэн хилийн харуул нь тодорхой хугацаанд товлосон хилийн хэсэг, чиглэлд бие даан үүрэг гүйцэтгэх чадвартай байх шаардлага;
- Хүчжүүлсэн хилийн харуулын тактикийн тусгай ажиллагаа нь хилийн бүс, зурвасын тодорхой хэсэгт зэвсэглэн халдсан ЗБГХБ- ийг илрүүлэх, тандах, устгах, зорилт тусгай томилгоот бүлгүүдийн хайгуул, цохилт, хэрэн сүйтгэх ажиллагаагаар тагнуул, жижиг бүлгүүд, холбоо удирдлагыг устгах зорилгоор хийгдэх отолт / давхар отолт, хуурамч отолт/, гэнэдүүлсэн дайралт зэргээр голлон явуулах;

Эдгээр байлдааны ажиллагааг явуулах хүч хэрэглийн гол цөм нь хилийн салбар, тусгай томилгоот бүлэг бөгөөд тэдгээрийг бүрдүүлэгч үндсэн нэгж нь хүчжүүлсэн хилийн харуулын тактик ажиллагааны талаар гүнзгийрүүлэн мэдлэг олоход тус дөхөм болсон нарын авлага хэвлэгдэн олны хүртээл болжээ.

ХИЛ СУДЛАЛ

ХСИС-ийн Хилийн Сургууль, Монголын Хил Судлалын Үндэсний нийгэмлэгийн онол-мэдээллийн сэтгүүл

Сэтгүүлийн зөвлөл:
Дарга: доктор, профессор, хурандаа Ц.Цэрэндорж

Хариуцлагатай эрхлэгч:
ОУМА-н академич, доктор, тэргүүлэх профессор Г.Давгажамц

Нарийн бичгийн дарга:
ОУМА-н академич, доктор, профессор, хурандаа Ц.Ганболд

Гишүүд:
Доктор, профессор А.Муратхан
Доктор, профессор Д.Нямдорж
Магистр С.Лхагвасүрэн
Магистр Х.Гөлгөө

Эхийг бэлтгэсэн:
ахмад Х.Асхар
Хэвлэлийн дизайн: Х.Айжан

Хэвлэлийн хуудас: 8.0
Хэвлэсэн тоо: 300 ш

Үүсгэн байгуулагч:
ОУМА-н академич, доктор, тэргүүлэх профессор Г.Давгажамц

* Нийтлэлийн хариуцлагыг зохиогч өөрөө хүлээнэ.
* Нийтлэлээс иш татахдаа сэтгүүлийн нэрийг заана.
* Сэтгүүлийг хувилан олшруулахыг хориглоно.
* Сэтгүүлд ирүүлсэн болон нийтлүүлсэн зүйлийн эхийг буцаахгүй

Манай хаяг:
Баянзүрх дүүрэг Хилчний гудамж,
ХСИС-ийн Хилийн Албаны Сургууль
Утас: 70155010, 99145087, 99061374
Факс: 976-70155010
И-мэйл: ganbold_bti@yahoo.com
ganbold.ts@leu.gov.mn

Улсын бүртгэлийн дугаар 921
Индекс 14921
Дансны дугаар
ХААН БАНК 5029511673-5